



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 15 (588)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭЭЛЖИТ ИЛТГЭЛ

- *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

Улаанбаатар хот

2009 оны дөрөвдүгээр сарын 20

№15 (588)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |     |
|------|---|-----|
| 204. | Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 339 |
| 205. | Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай             | 342 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭЭЛЖИТ ИЛТГЭЛ

- |      |   |     |
|------|---|-----|
| 206. | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл - 2008 | 342 |
|------|---|-----|

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

009 оны 03 дугаар арын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2009 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсыг хөгжүүлэх ангийн 2009 оны төсвийн тухай хуульд дор урдсан агуулгатай 6, 7 дугаар зүйл нэмсүгэй:

**6 дугаар зүйл.** Монгол Улсыг хөгжүүлэх ангийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн эсвийн орлогын дутагдлыг нөхөх эх үүсвэрээс Монгол Улсын 2009 оны төсвийн алдагдлыг энхүүжүүлэх эх үүсвэрт 219,600.0 сая төгрөгийг ирцуулахаар баталсугай.

**7 дугаар зүйл.** Монгол Улсыг хөгжүүлэх ангийн хөрөнгөөр бий болсон газрын тосны болон усний улаан буудайн нөөцийн хадгалалтын элсийг 3,298.1 сая төгрөгөөр баталсугай.

**2 дугаар зүйл.** Монгол Улсыг хөгжүүлэх ангийн 2009 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар йлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**5 дугаар зүйл.** "Монгол Улсыг хөгжүүлэх ангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө

оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралтаар, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс хойшлуулах төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай."

**3 дугаар зүйл.** Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн "45,232.8" гэснийг "51,282.2" гэж, 4 дүгээр зүйлийн "79,867.3" гэснийг "122,289.3" гэж, мөн зүйлийн "35,542.8" гэснийг "57,184.5" гэж, 6 дугаар зүйлийн дугаарыг "8" болгон тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ,  
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/Төсвийн ерөнхийлөн захирагчаар, сая төг/

Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил		Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2009 оны санхүүжилт
<b>I</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД</b>		<b>15,755.0</b>	<b>1,800.0</b>
I.1	Хөрөнгө оруулалт:		15,755.0	1,800.0
I.1.1	"Замын-Үүд" чөлөөт бүсийн мэргэжлийн албадын нэгдсэн байр /Дорноговь, Замын-Үүд/	2008-2009	1,000.0	800.0
I.1.2	"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн доторх хорооллын чанартай хатуу хучилттай авто зам, 0.8 км х13.8 км /Сэлэнгэ, Алтанбулаг/	2008-2010	14,755.0	1,000.0
<b>II</b>	<b>ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД</b>		<b>45,476.7</b>	<b>24,622.3</b>
II.1	<b>Цахилгаан дамжуулах шугам, дэд станц:</b>		<b>8,811.9</b>	<b>8,811.9</b>
II.1.1	Ил хуваарилах байгууламж-4-д 220/110/35 кВ-ын 125 мВа чадалтай автотрансформатор суурилуулах /Улаанбаатар/	2009	2,754.9	2,754.9
II.1.2	Умард дэд станцын трансформатор, хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/	2009	3,150.0	3,150.0
II.1.3	6, 10 кВ-ын дэд станцуудын тосон таслууруудыг вакуум болгох /РП 3, 5, 6, 13, 24/ /Улаанбаатар/	2009	1,080.0	1,080.0
II.1.4	Дархан хотын 220/110/35 кВ-ын дэд станц, 35 кВ-ын реактор суурилуулах /Дархан-Уул/	2009	1,827.0	1,827.0
II.2	<b>Дулааны станц, дулааны шугам сүлжээ:</b>		<b>33,314.8</b>	<b>15,310.4</b>
II.2.1	"ДЦС-4"-д "Усны дулаан солилцуулагч бүхий дулааны дэд станц" барих болон станцын дулааны дотоод шугам сүлжээг шинэчлэх, шинээр сүлжээний насос суурилуулах /Улаанбаатар/	2009-2010	21,715.2	4,340.8
II.2.2	Дулааны сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулахад насос станц №1, 6-ын хүчин чадлыг нэмэгдүүлж шинэчлэх /Улаанбаатар/	2009	1,776.1	1,776.1
II.2.3	Дулааны 5 "б" магистраль 1950м*2, 500 мм-ийн шугамыг 800 мм болгон өргөтгөж, шинэчлэх /Улаанбаатар/	2009	3,816.0	3,816.0
II.2.4	Дулааны 6 "б", "в" магистраль 2198м*2, 500 мм-ийн шугамыг 600 мм болгон өргөтгөж, шинэчлэх /Улаанбаатар/	2009	4,657.5	4,657.5
II.2.5	Дулаан хангамжийн системийг хаалттай системд шилжүүлэх /Дархан-Уул/	2009-2010	1,350.0	720.0
II.3	<b>Эрдэс баялаг:</b>		<b>3,350.0</b>	<b>500.0</b>
II.3.1	Хөрөнгө оруулалт: Газрын тосны чанарын хяналтын лаборатори байгуулах	2008-2010	3,350.0	500.0
<b>III</b>	<b>ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД</b>		<b>137,280.9</b>	<b>65,567.0</b>
III.1	<b>Авто зам:</b>		<b>53,790.8</b>	<b>15,587.8</b>
III.1.1	Өгийнуур-Хөшөөцайдам чиглэлийн 10 км хатуу хучилттай авто зам	2007-2009	1,298.9	280.1
III.1.2	Хархорин-Цэцэрлэгийн 74 км хайрган авто замыг хатуу хучилттай болгох	2007-2009	8,403.6	1,955.8
III.1.3	Цэцэрлэг-Их тамир-Тосонцэнгэл чиглэлийн 53 км хайрган авто замыг хатуу хучилттай болгох	2007-2009	8,296.0	1,528.2
III.1.4	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 109 км хатуу хучилттай авто зам	2007-2009	19,073.9	8,663.3
III.1.5	Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 30.4 км хайрган авто зам	2007-2009	3,040.0	221.8
III.1.6	Хархорин-Хужиртын 39 км хатуу хучилттай авто зам	2006-2009	5,841.2	1,002.2
III.1.7	Дамдинсүрэнгийн гудамжны авто зам /Улаанбаатар/	2006-2009	1,800.0	104.3
III.1.8	Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн 14.5 км хатуу хучилттай авто зам	2008-2009	3,045.0	1,045.0
III.1.9	Арвайхээр-Баянсонгор чиглэлийн 23 км хайрган замыг хатуу хучилттай болгох	2007-2009	2,992.2	787.1

III.2	Гүүр:		15,063.9	9,736.8
III.2.1	Эгийн голын 160 у/м төмөр бетон гүүр /Хөвсгөл, Түхэл/	2007-2009	1,812.5	1,532.5
III.2.2	Турганы голын 96.9 у/м төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Сагсай/	2008-2009	999.0	799.0
III.2.3	Туул голын Горхийн 211 у/м төмөр бетон гүүр /Улаанбаатар, Тэрэлж/	2007-2009	2,422.5	829.5
III.2.4	Ховд голын 181.8 у/м төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус/	2008-2009	- 1,500.0	1,080.9
III.2.5	Нарийний голын 325 у/м төмөр бетон гүүр /Увс, Тэс/	2006-2009	2,750.0	1,815.0
III.2.6	Их тэнгэрийн 258 у/м төмөр бетон гүүр /Улаанбаатар/	2007-2009	3,986.5	2,286.5
III.2.7	Идэрийн голын төмөр бетон гүүр /Завхан, Их Уул/	2008-2009	1,593.4	1,393.4
III.3	<b>Иргэний нисэхийн ерөнхий газар:</b>		<b>44,794.2</b>	<b>16,610.4</b>
III.3.1	Хөрөнгө оруулалт:		25,884.0	8,000.0
III.3.1.1	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвасын хучитгэлийн ажил, гэрлэн тэмдэгт /Улаанбаатар, "Чингис хаан" Олон улсын нисэх буудал/	2008-2011	7,000.0	1,500.0
III.3.1.2	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Говь-Алтай/	2008-2010	7,385.3	2,300.0
III.3.1.3	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Увс/	2008-2010	11,498.7	4,200.0
III.3.2	Тонгог төхөөрөмж: Бодит ажиглалтын систем /радиолокатор 3ш, VOR/DME 4ш/	2008-2009	18,910.2	8,610.4
III.4	<b>Тээвэр:</b>		<b>23,632.0</b>	<b>23,632.0</b>
III.4.1	Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлт /Их багтаамжтай автобус, 400 ш/	2009	23,632.0	23,632.0
IV	<b>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД</b>		<b>30,300.0</b>	<b>30,300.0</b>
IV.1	Хөрөнгө оруулалт: "Атрын 3 дахь аян" газар тариалангийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2009	30,300.0	30,300.0
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>228,812.6</b>	<b>122,289.3</b>

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2009  
ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС  
ХОЙШЛУУЛАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

/Төсвийн ерөнхийлөн захирагчаар, сая төг/

Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил		Төсөвт өртөг	Хойшлуулах хөрөнгийн дүн
<b>I</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД</b>	<b>1,080.0</b>	<b>630.0</b>
1.1	Хөрөнгө оруулалт: "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн хилийн боомттой холбогдох хэсгийн хатуу хучилттай авто зам /810м*28м/ /Сэлэнгэ, Алтанбулаг/	1,080.0	630.0
<b>II</b>	<b>ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД</b>	<b>3,350.0</b>	<b>500.0</b>
II.1	<b>Эрдэс баялаг:</b>	<b>3,350.0</b>	<b>500.0</b>
II.1.1	Хөрөнгө оруулалт: Газрын тосны чанарын хяналтын лаборатори байгуулах	3,350.0	500.0
<b>III</b>	<b>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД</b>	<b>17,700.0</b>	<b>2,700.0</b>
III.1	Хөрөнгө оруулалт:	2,700.0	2,700.0
III.1.1	Бизнес инкубатор байгуулах /Архангай, Баянхонгор, Хэнтий/	900.0	900.00
III.1.2	Технологи дамжуулах төв байгуулах /Ховд, Өвөрхангай/	900.0	900.00
III.1.3	Үйлдвэрлэл технологийн парк байгуулах /Ховд, Завхан/	630.0	630.00
III.1.4	Үйлдвэрлэл технологийн паркийн зураг төсөл боловсруулах	270.0	270.00
	<b>Дүн</b>	<b>22,130.0</b>	<b>3,830.0</b>





2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2009 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангийн "3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын санд 2009 оны төсвийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлийг 2009 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын доод дор дурдсанаар өөрчлөн найруулсугай: хэмжээг дор дурдсанаар баталсугай:

д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	102,430.5
2	Даатгуулагчаас төлөх шимтгэл	138,505.4
3	Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	55,798.4
4	Төр бүрэн хариуцах даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын хураамж	8,094.3
5	Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	39.2
6	Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	2,751.8
7	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	2,815.4
8	Бусад орлого	5,194.0
<b>Нийт орлого</b>		<b>315,629.1</b>

**4 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангийн зарлагын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Тэтгэврийн даатгалын сан	331,932.7
2	Тэтгэмжийн даатгалын сан	14,477.2
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	15,627.4
4	Ажилгүйдлийн даатгалын сан	5,619.3
5	Эрүүл мэндийн даатгалын сан	56,060.6
6	Үйл ажиллагааны зардал	8,585.7
7	Бусад зардал	235.3
8	Хөрөнгө оруулалт үүнээс:	3,000.0
8.1	Албан конторын барилга шинээр барих	1,000.0
8.2	Барилгын өргөтгөл, их засварын зардал	318.2
8.3	Тавилга, эд хогшил худалдан авах	122.8
8.4	Компьютер, тоног төхөөрөмж худалдан авах зардал	504.4
8.5	Ажилтнуудын орон сууцны хөнгөлөлт	705.0
8.6	Автомашин худалдан авах зардал	188.0
8.7	Ажлын дүрэмт хувцасны зардал	103.8
8.8	Автомашинь гараж барих зардал	5.0
8.9	Халаалтын зуух, тоног төхөөрөмж худалдан авах зардал	5.0
8.10	Агуулах, гараж худалдан авах зардал	23.9
8.11	Барилгын зураг төсөв хийлгэх зардал	24.0
<b>Нийт зарлага</b>		<b>435,538.2</b>

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ЭЭЛЖИТ ИЛТГЭЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ  
БАЙДЛЫН ТАЛААРХ ИЛТГЭЛ 2008 ОН

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТОН ҮҮСЭН ОЛОН НИЙТИЙН ЭМХ ЗАМБАРААГУЙ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ

Монгол Улс хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлсэн хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах зорилт дэвшүүлэн шинэ Үндсэн хуулиа баталж, иргэд тайван замаар хуран цуглах, үзэл бодлоо илэрхийлэх, төр засгийн үйл ажиллагааг шүүмжлэх эрх чөлөөтэй болсноос хойш нам улс төрийн хүчнүүд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд олон зуун жагсаал, цуглаан зохион байгуулж, үзэл бодлоо илэрхийлж байсан байна.

Нам, улс төрийн хүчнүүд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, иргэдээс зохион байгуулсан жагсаал, цуглаанаас гарсан иргэдийн дуу хоолой нь хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиулэн дэмжих, төр засгаас бодлого шийдвэр гарахад зохих нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. 2008 онд болсон Улсын Их Хурлын сонгуулийн үр дүн, сонгуулийн үйл явцтай холбоотойгоор зарим нам, улс төрийн хүчнээс зохион байгуулсан жагсаал, цуглаан нь даамжирч, нийтийн эмх замбараагүй байдал болж, хүний амь нас, цагдаа, хүчний байгууллагууд олон ажилтнууд, иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгөнд их хэмжээний хохирол учирч, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн харамсалтай үйл явдал өрнөсөн учраас Хүний Эрхийн Үндэсний Комиссын 2008 оны Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд энэ асуудлыг хөндөж дүгнэлт хийж байна. Тус Комисс энэ асуудлаар аль нэг нам, улс төрийн хүчин, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага, ямар нэг үзэл бодлыг баримтлахгүйгээр хараат бус үнэлэлт дүгнэлт хийхийг зорьсон болно.

#### Нэг. Жагсаал, цуглааныг зохицуулсан хууль, эрх зүйн актад хийсэн дүгнэлт

1.1. Монгол Улсад тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний эрх зүйн орчны талаар дагнаж хийсэн судалгаа, дүгнэлт ховор байна. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний чөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд 2001 онд энх удаагаа хийгдсэн "Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал" судалгааны явцад хууль, гогтоомжийн талаар зарим нэг харьцуулалт, нэлэлтийг өгснөөс гадна Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2004 оны илтгэлд үр эрхийн асуудал тусгагдсан байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйлд "Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлд "Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс уртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх

чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй" гэж заасан. Мөн пактын 19 дүгээр зүйлд "Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил язгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана" гэсэн ба дээрх зарчмыг Монгол Улс баримтлах олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй.

Иргэд үзэл бодлоо илэрхийлэх үндсэн арга бол тайван замаар жагсаал, цуглаан хийх явдал юм. 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг Улсын Их Хурлаас анх батлан гаргасан нь иргэдийн жагсаал, цуглаан хийх эрхийг эрх зүйн хувьд журамласан зохицуулалт болсон. Уг хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч зөвшөөрөл авна. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно" гэж заасан байв. Хүний Эрхийн үндэсний Комиссын 2004 оны илтгэлд жагсаал цуглаан хийх зөвшөөрлийн тогтолцоо, зөвшөөрөл олгох хугацаа, зөвшөөрөл өгч буй субъектын талаарх зохицуулалтыг хянан үзэхийг санал болгосон. Үүний дагуу Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд 2005 оны 11 дүгээр сард Улсын Их Хурал нэмэлт өөрчлөлт оруулсан ба үг өөрчлөлтөөр жагсаал, цуглаан зохион байгуулахад зөвшөөрөл олгодог тогтолцоог бүртгүүлэх болгон өөрчилсөн байна. Гэвч бүртгэлтэй холбоотой нэмэлт өөрчлөлт иргэний тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөгөө эдлэх баталгаа болж чадахгүй байна. Өмнөх хуульд байсан зөвшөөрөл өгөх, зөвшөөрөл олгох гэснийг бүртгэх, бүртгүүлэх гэсэн нэр томъёогоор хэлбэрийн төдий сольж, жагсаал, цуглааныг бүртгүүлээгүй бол албадан тараах эрх зүйн зохицуулалт хэвээр байгаа нь үнэн хэрэгтээ "зөвшөөрлийн тогтолцоо" үйлчилсээр байгааг харуулж байна. Жагсаал цуглааныг бүртгэх эрх нь улс төрийн албан тушаалтан буюу тухайн орон нутгийн Засаг даргад байгаа болон Засаг дарга жагсаал, цуглаан зохион байгуулах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор бүртгэсэн эсэхээ мэдэгдэнэ гэсэн заалтыг ч хянан үзэх шаардлагатай байна.

Жагсаал цуглааны аюулгүй байдал болон чөлөөтэй тайван замаар хуран цуглах эрхийг нь баталгаатай хангах үүднээс жагсаал цуглаан зохион байгуулагч нь Цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр жагсаал цуглаанаа зохион байгуулдаг болох нь илүү зохимжтой гэж үзэж байна.

**1.2.** Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактуудад жагсаал цуглаан хийх эрхийг баталгаажуулахдаа "Хүн бүр чөлөөтэй тайван хуран цуглах эрхтэй, тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө" гэжээ. "Тайван" гэдэг үгийг монгол хэлэнд "олон нийтийн амгалан тайван байдал, амгалан байдал" гэж ойлгодог.

Аливаа нийтийг хамарсан арга хэмжээний үед оролцогчдын зүгээс хууль тогтоомж зөрчих, энэ үйлдэл нь зохион байгуулагчийн хяналтаас гарах зэргээр үйл ажиллагаа хурцадмал хэлбэрээр өрнөж, нийгмийн хэв журмыг бүүдүүлгээр зөрчөөл олон нийтийн эмх замбараагүй байдал үүсдэг. "Нийгмийн хэв журам" гэдэг нь нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хууль тогтоомж, зан заншил, ёс суртахууны шаардлагыг алианаар ч тогтоосон хэм хэмжээг ойлгож болно.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар ч жагсаал, цуглааныг зохион байгуулагч болон түүнд оролцогчдод жагсаал, цуглаан зохион байгуулж буй газарт нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах, нийтийн аж ахуй, бусад эд хөрөнгөнд хохирол учруулахгүй байх, цуглааны явцад аливаа хэлбэрээр хүч үл хэрэглэх, халуун хүйтэн зэвсэг, тэсрэг дэлбэрэх бодис авч явуулах

2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн дүн дээр дурдсан байдлаар гарсан хэдий ч сонгууль шударга явагдаагүй, санал хураалт болон санал тоололт луйвартай болсон, олон тооны иргэний үнэмлэх хуурамчаар үйлдэж санал өгүүлсэн, иргэний үнэмлэх дээрх хаягийн бүртгэлийг сольж, санал давхардуулж өгүүлснээс иргэдийн сонголт зөв гарсангүй гэж үзсэн нам, улс төрийн хүчнүүд, иргэд жагсаал, цуглааныг зохион байгуулсан гэдэг нь одоогоор тодорхой байна.

Харин эрх, эрх чөлөөгөө эдэлж, тайван замаар жагсаал цуглаан хийж, үзэл бодлоо илэрхийлж байсан иргэд яагаад тайван замаасаа хальж, хүчирхийллийн замыг сонгож, цагдаа, хүчний байгууллагын ажилтнуудыг эсэргүүцэж, бусдын эд хөрөнгийг эвдэн бусниулж, галдан шатааж, дээрэм тонуул хийж, нийтийг хамарсан үймээн самуун болов гэдэг нь өнөөдөр хүртэл тодорхой бус байна. Үймээн самуун гарах болсон учир шалтгааныг нам, улс төрийн хүчнүүд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, иргэд өөр өөрсдийнхөөрөө тайлбарласаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллээс үзвэл жагсаал, цуглаан тайван замаасаа хальж хүчирхийлэл, үймээн самуун болж хувирсны шалтгааныг зарим нам, эвсэл, улс төрийн хүчин зориуд зохион байгуулсан, ихээхэн хэмжээний мөнгө, хөрөнгө гаднаас орж ирсэн, чулуу, мод, шатах, дэлбэрэх зүйлсийг зориуд авч ирсэн, мөнгө

### 2008 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн Улсын Их Хурлын сонгуулийн үр дүн

Нам	Суудал
Монгол ардын хувьсгалт нам	46
Ардчилсан нам	27
Иргэний зориг нам	1
Иргэний эвсэл	1
Бие даагч	1

байх, гудамж замын хөдөлгөөнд саад болохгүй байхыг үүрэг болгосон байна.

**1.3.** Зарим нам, улс төрийн хүчнүүд болон иргэд Монгол Улсын Их Хурлын сонгууль будлиантай болж, шударга явагдсангүй гэж үзэн 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод жагсаал, цуглаан зохион байгуулж, хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө эдэлсэн хэдий ч энэхүү жагсаал, цуглаанд оролцогчдод олон улсын гэрээ болон хуулиар олгогдсон эрхээ хэтрүүлж, жагсаал цуглаан тайван шиеж чанараа алдан, хүчирхийлэл, эмх замбараагүй байдал болон хувирч, хэд хэдэн хүний амь нас хохирч олон арван цагдаагийн алба хаагч болон жирийн иргэд бэртэж гэмтэн, эд хөрөнгийн ихээхэн хэмжээний хохирол учирсан нь тайван замаар ардчилал, зах зээлд шилжиж чадсан монголчуудын хувьд түүхэнд байгаагүй, гашуун сургамжтай өдөр болсон гэдгийг зориуд тэмдэглэж байна.

тараасан, цагдаа, тагнуулын ажилтнууд өөрсдөө зориуд зохион байгуулсан, монголын нийгэмд шударга бус бусармаг явдал газар авч, ард түмний бүхимдэл дээд цэгтээ тулж, энэ байдлаа хууль бус замаар бусдын эрхийг хөндөж илэрхийлсэн гэх зэргээр янз янзаар тайлбарласаар байна. Үймээн самууныг зохион байгуулсан гэгдэх хүмүүсийн хэргэ эцэслэн шийдвэрлэгдээгүй, нөхцөл байдал тодорхойгүй байгаа, дээр дурдсан учир шалтгааны аль нь үнэн, аль нь худал болохыг одоогоор үнэлж дүгнэх боломжгүй байна. Гэсэн хэдий ч иргэдийн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг ашиглаж тэднийг хууль бус үйлдэлд татан оролцуулах, хүчирхийлэлд түлхэх эрх хэнд ч, ямар ч нам, хүчэнд байх ёсгүй, энэ бол хүний эрх, эрх чөлөөг урвуулан ашигласан, хүний эрхийн ноцтой зөрчил гэж олон улсын жишигт үздэг.

Манай улс төрийн эрх барих дээд болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг иргэдийн сонгох, сонгогдох эрхэд тулгуурлан шинэ

<sup>1</sup> Монгол хэлний товч тайлбар толь – ЯЦЗөвл 514 дүгээр талд

<sup>2</sup> УДШ-ийн 2007.10.29-ний өдрийн №41 дүгээр тогтоол "Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэргэ болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар"

<sup>3</sup> Үймээн самуунаас хойш хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, мэдээлэлд бичигдсэн учир шалтгаанууд.

ардчилсан зарчмаар сонгодог болж хэд хэдэн сонгуулийг ардаа орхисон ч сонгуультай холбоотой зөрчил, маргаан, хэрүүл, будлиан улам их гарах болжээ. Сонгуулийн тухай хууль тогтоомжид хэд хэд дахин өөрчлөлт орсон ч сонгууль тойрсон маргаан, хэрүүл бүр даамжирч шийдвэрлэгдэхгүй сар, жилийн нүүр үздэг болсон байна. Бүх шатны сонгуульд ард иргэдээ ямар нэгэн байдлаар алагчлахгүйгээр бүрэн оролцуулж, өөрийн хүссэн төлөөлөгчийнхөө төлөө саналаа чөлөөтэй өгч төр барилцах эрхээ бодитой эдлэх боломжоор хангах, иргэдийнхээ өгсөн саналыг элдэв будлиангүйгээр зөв тоолж, шударга сонгууль явуулж сурах, ард түмнийхээ сонголтыг хүндэтгэн хүлээн зөвшөөрдөг, гарсан санал гомдлыг нь түргэн шуурхай шүүн тунгаах үнэн мөнийг нь олж, нийтэд зарладаг болох нь хүний эрх, эрх чөлөөний нэг чухал асуудал болсоор байна. Үүний тулд сонгуулийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй, ойлгомжтой, маргаан будлиан хийх хийдэлгүй болгох, сонгуулийн бүх шатны байгууллагын ажилтнуудыг нам улс төрийн хүчнээс хараат бусаар бие дааж үйл ажиллагаагаа шударгаар явуулах боломжоор хангах, сонгуулийн үйл ажиллагааг хөндлөнгөөс хянах, ажиглах тогтолцоог боловсронгуй болгох, иргэний бүртгэл, мэдээллийг баг, хорооноос нь эхлэн сайжруулж, бүх иргэдээ иргэний бичиг баримттай болгож, иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулж сонгууль шударга хуулийн дагуу явагдах нөхцөл боломжийг бий болгох шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ нам, улс төрийн хүчнүүд, эвсэл холбоод, улс төрчид төрийн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан төрийн хуулийг хүндэтгэн биелүүлдэг, сонгуулийг шударга, Будлиангүй явуулахын төлөө чин сэтгэлээсээ канддаг, иргэдийнхээ сонголтыг хүндэтгэж, улс эрнхээо санхүү эдийн засаг, ард иргэдийнхээ амьжиргааны сул талыг сөргөөр ашигладаггүй, эд өрөнгө амладаггүй, саналыг нь худалдаж авахыг зорьдоггүй, гарсан зөрчил будлианыг хуулийн дагуу тавьж, шударгаар шийдвэрлүүлж, гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрч чаддаг, иргэдийнхээ сонголтыг хүндэтгэж, ялж, ялагдаж сурах соёлд ичээнгүйлэн суралцах шаардлагатай байна. Ямар ч сайн хууль тогтоомж, дүрэм журам гарсан ямууд, улс төрийн хүчнүүд, улс төрчид эдгээрийг шударгаар биелүүлэх хүсэлгүй л бол эзээ ч хэрүүл, маргаан арилахгүй. Сонгуулийн үед арсан аливаа зөрчил будлиан ихэвчлэн улс өрчидтэй холбоотой гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй гэж үзэж байна.

**Хоёр. Олон нийтийн эмх замбараагүй байдал болон түүнийг таслан зогсоох, хэргийг**

**мөрдөн шалгах, шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүгнэлт**

2.1. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр болсон нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн, захиргааны "танхайрах" зөрчлийн шинжтэй үйлдэл нь даамжирч, нийгмийн хор аюул нь ихсэн олон нийтийг<sup>4</sup> хамарсан эмх замбараагүй байдал болон хувирч улмаар гэмт хэргийн шинж чанартай болсон байна. Уг жагсаал үдээс өмнө цугларч үдээс хойш жагсаал тайван шинж чанараа алдаж, 19.00 цагийн үеэс жагсаал цуглаанд оролцогсод Монгол ардын хувьсгалт намын байрны үүдэнд шилжин, уг байр руу дайрч цонхыг хагалан, цагдаагийн ажилтнуудыг эсэргүүцэж, гал тавьж, эд хөрөнгийг нь устгаж, дээрэмдсэн байна.

Жагсагчид Монгол ардын хувьсгалт намын байрнаас гадна түүний хойно орших Соёлын төв өргөөний зарим хэсэг буюу Уран зургийн галлерейг шатааж Улсын филармонийн эд хөрөнгийг нь дээрэмдсэн, ойролцоо байсан иргэдийн машины 5-ыг нь шатааж, 20-ыг нь эвдэлж хэмхэлсэн.

Олон нийтийн эмх замбараагүй байдлын улмаас 5 иргэн амь насаа алдаж, албан үүргээ гүйцэтгэж байсан онцгой байдлын албаны 4, цагдаа, дотоодын цэргийн 393 алба хаагч, түүнчлэн 401 иргэний бие эрхтэнд гэмтэл учирч, 155 иргэн, 118 аж ахуйн нэгжид 11.291.698.871 төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан байна<sup>5</sup>.

Цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын албаны нийт 397 алба хаагч гэмтэл авсан байх ба тэдгээрээс 87 нь тархи, хүзүү, толгойны, 22 нь нүүр, нүд, шүдний, 53 нь нуруу нугасны гэмтэлтэй, 41 нь хэвлий, гэдэс, цээж, 96 нь гар, шуу, тохойдоо, 245 нь хөл, шилбэ, тавхайндаа гэмтсэн, тэдгээрээс хүнд гэмтэлтэй 17, хөнгөн гэмтэлтэй 379 алба хаагч байсан. Эдгээр алба хаагчдаас 77 алба хаагчийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлж, 6 албан хаагчийн оношлогооны төлбөрт 450.000 төгрөг, 4 алба хаагчийн эмчилгээний төлбөрт 2.581.300 төгрөг, 2 алба хаагчийн сувиллын зардалд 380.000 төгрөг, нийт 12 алба хаагчид 3.411.300 төгрөгийн тусламжийг үзүүлсэн байна.

Монгол Улсын үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14-т "Монгол Улсын иргэн бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй", мөн хуулийн арван есдүгээр зүйлийн 1-д "төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн адлүүлэх үүрэгтэй" гэж заасан.

## Нөхөн олговорт шаардагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо<sup>6</sup>

<sup>4</sup> "олон нийт" гэдэг нь нийтийн нэг хэсгийг тодорхойлсон ойлголт" ЛУДШ-ийн 2007.10.29-ний йдрийн №40 дүгээр тогтоол/ ХЗДХЯ-аас боловсруулсан "Хохирогчид нөхөн олговорт олгох тухай хуулийн төслийн үзэл баримтлал" 2008 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар. Энэ тооцоонд амь насаа алдсан этгээдүүдийн ар гэрээс нэхэмжилж айгаа сэтгэл санааны хохирлын тооцоо ороогүй болно.



д/д	Хохирогчид	Учирсан хохирол /төг/	
		Мөрдөн байцаалтын шатанд тогтоогдсон	Нөхөн олговорт шаардагдах хөрөнгө /төг/
1.	МАХН-ын байр, уг байранд үйл ажиллагаа явуулж байсан 69 иргэн, аж ахуйн нэгж	8.794.438.099	8.794.438.099
2.	Соёлын төв өргөө, тус байранд үйл ажиллагаа явуулж байсан 79 иргэн, аж ахуйн нэгж	2.309.904.452	2.309.904.452
3.	МАХН-ын байр, Соёлын төв өргөөний орчимд 15 иргэн, 9 аж ахуйн нэгж	51.958.526	51.958.526
4.	Албан үүргээ гүйцэтгэж байсан /Онцгой байдлын алба хаагч, сурвалжлагч/ 12 хүн, 9 байгууллага, аж ахуйн нэгж	51.670.900	51.670.900
5.	Албан үүргээ гүйцэтгэж байсан 21 цагдаа, дотоодын цэргийн алба хаагч /эд хөрөнгөд/	83.726.804	83.726.804
6.	Амь насаа алдсан хүний ар гэрт /буудуулсан 4, угаартсан гэх 1/	-	80.000.000
7.	Албан үүргээ гүйцэтгэж яваад хохирсон цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын албаны алба хаагч	-	462.672.000
8.	Нийт	11.291.698.871	11.834.370.871

**Цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын албан хаагч нарт олгох нөхөн олговрын тооцоо<sup>1</sup>**

д/д	Биед учирсан гэмтлийн зэрэг	Хүний тоо	өсгөх хувь	Олгох нөхөн олговор		
				Албан тушаалын цалин <sup>2</sup> /төг/	Нэг албан хаагчид ногдох	Нийт
1.	Хунд	1	36	336.000	12.096.000	12.096.000
2.	Хүндэтгэр	17	12	336.000	4.032.000	68.544.000
3.	Хөнгөн	379	3	336.000	1.008.000	382.032.000
4.	Бүгд	397	-	-	-	462.672.000

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-дэх заалтад "Төрийн албан хаагч нөхөн төлбөр авах баталгаагаар хангагдана", "Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 8-д "үүргээ ёсчлон биелүүлснээс цагдаагийн алба хаагчид учирсан эд хөрөнгөний хохирлыг цагдаагийн байгууллага төлнө", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 6-д "үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцна" гэж тус тус заасан. Иймд төр иргэнийхээ өмнө хүлээсэн хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзэж, олон нийтийн эмх замбараагүй байдлын улмаас хохирсон этгээдүүдийн хохирлыг төрөөс нэг удаа нөхөн олговор олгох хэлбэрээр хохирлыг арилгах нь зүйтэй.

Жагсаал, цуглаан олныг хамарсан галдан шатаасан, дээрэм тонуул хийсэн үймээн самуун болгохгүйгээр, гарз хохирол бага, онц байдал зарлах хэмжээнд хүрэхгүйгээр таслан зогсоох, нийгмийн аюулгүй байдлыг хангах үүргээ цагдаагийн байгууллага хангалтгүй биелүүлсэн гэж зарим байгууллага, иргэд үзэж дүгнэж байгааг ч хүлээн зөвшөөрөх үндэстэй. Цагдаагийн байгууллага олныг хамарсан үймээн самууныг даамжруулахгүй, хохирол багатайгаар таслан зогсоох арга барил дутсан байна. Цагдаагийн байгууллага хэлэлцээр хийх, баривчлах, шалган нэвтрүүлэх гэх мэт бүлгүүдийг зохион байгуулж ажиллуулж чадаагүй байна.

Цагдаагийн байгууллагын тухай хуулиар цагдаагийн ажилтны хэрэглэдэг тусгай хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, нэг бүрийн тусгай хэрэгсэл гэж ангилж, хэрэглэх арга журмыг

<sup>1</sup> ХЗДХЯ-аас боловсруулсан «Хохирогчид нөхөн олговор олгох тухай хуулийн төслийн үзэл баримтлал»

<sup>2</sup> Албан тушаалын жижиг цалин /ТТ-6-3-аар ахлагч цолтой/



зохицуулжээ. Хуулийн 42 дугаар зүйлд заасан олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, усан хөөрөг, утаан хошиг үүсгэгч, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгаа тохиолдолд хэрэглэж болохоор заажээ.

Уг хуулийн 43 дугаар зүйлд зааснаар нэг бүрийн тусгай хэрэгсэлд:

1. Гар, хөл, хурууны гав
2. Хүлэг, ороох цамц
3. Резинэн борооход
4. Цахилгаан борооход

5. Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр  
6. Резинэн ба хуванцар сумтай буу багтдаг байна.

Нийслэл хотод болсон олон нийтийн эмх замбараагүй байдлын үеэр дээр дурдсан тусгай хэрэгслүүдээс резинэн, хуванцар, нулимс асгаруулагч сумтай буу, борооход, бамбай, сургалтын сумтай АКМ буу зэргийг зохих журмын дагуу хэрэглэсэн<sup>9</sup> боловч цагдаагийн олон албан хаагч бэртэл гэмтэл авч, олон нийтийн эмх замбараагүй байдлыг тарааж чадаагүй нь цагдаагийн алба хаагчид чанартай, шаардлага хангахгүй, хүрэлцэхгүй хэмжээний орчин үеийн тусгай хэрэгслээр бүрэн хангагдаж чадаагүйтэй лууд холбоотой байна.

Цагдаагийн байгууллагын тухай хуульд нийтийг хамарсан үймээн самууныг таслан зогсооход олон хүнд нөлөөлөх утаан хошиг үүсгэгч, усан хөөрөг хэрэглэнэ гэж заасан боловч ийм хэрэгслээр Цагдаагийн байгууллага хангагдаагүй, хэрэглэж буй тусгай хэрэгслүүд нь хүрэлцээтэй иш, чанарын шаардлага хангаагүй байсан байна. Цагдаагийн болон хүчний байгууллагад алба саагчдыг онцгой нөхцөл байдалд ажиллаж сургах, мэргэжил, чадвар, арга барилыг нь дээшлүүлэх, ианартай шаардлага хангахгүй тусгай хэрэгслээр ангах асуудал нь төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулахын зэрэгцээгээр нийгмийн хэв журмыг хамгаалах, иргэний эрхийг ангах чухал асуудал гэж үзэж байна.

Жагсаал цуглаан хийх журмын тухай уулийн 14 дүгээр зүйлд "...Засаг дарга хууль бус жагсаал цуглааныг 2 цагийн дотор тараахыг зохион яйгууллагчид нь бичгээр мэдэгдэнэ. Уг шаардлагыг с биелүүлбэл жагсаал цуглааныг цагдаагийн яйгууллага хуульд заасан арга, хэрэгслээр лбадан тараана. Жагсаал цуглааныг албадан араахад цагдаагийн байгууллагын хүч, хэрэгсэл үрэлцэхгүй бол дотоодын цэргийн тусалцаа авна" гэж заажээ.

Харин хуульд жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллагаас албадан тараах арга, хэрэгслийг Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаас өөр нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Уг зүйлд утаан хошиг үүсгэгч, усан хөөрөг, олон хүнд зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчийг нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, байгууллага, иргэдийн мэдлэд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг эзлэн авсныг чөлөөлөх, хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялсныг баривчлах, мөн хуулинд галт зэвсэг хэрэглэхээр заасан тохиолдолд урьдчилан сануулсны үндсэн дээр хэрэглэнэ гэж заасан байна. Энэ зүйлд заасан олон хүнд хэрэглэх тусгай хэрэгслүүдээр цагдаагийн байгууллага хангагдаагүй учраас цагдаагийн ажилтнууд энэ төрлийн хэрэгслийг хэрэглэх арга барилд суралцаагүй, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох хүч хэрэгсэл байхгүй гэж үзэж болохоор байна.

Иймээс улс орны аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг найдвартай хамгаалах, нийгмийн эмх замбараагүй байдлыг даамжруулахгүйгээр таслан зогсоох, цагдаагийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах шаардлагын үүднээс хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, цагдаагийн байгууллагыг шаардлагатай тусгай хэрэгслээр хангах, түүнийг хэрэглэдэг арга барилд мэргэшүүлэх, сургах шаардлага гарч байна.

**2.2. "Онц байдал" гэдгийг олон улсын түвшинд хуульд заасан хүний зарим эрх, эрх чөлөөг тодорхой болон тодорхой бус хугацаагаар хязгаарлахыг ойлгодог. Онц байдлын үед хязгаарлах хүний эрхийн хэм хэмжээг заавал үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулж өгсөн байх ёстой.**

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4 дүгээр зүйлийн 1-д "Улс үндэстний амьдрал аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс Пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь олон улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна зөвхөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчилах явдалд хүргэхгүй байх ёстой" гэж заасан байдаг.

Дэлхий дахинд 1907 оноос хойш нийт 48 удаагийн онц байдлыг зарлаж байсан байна. Эдгээрээс 11 удаагийн онц байдал нь улс төрийн шинжтэй үйл явдалаас үүдэн зарлагдсан бол бусад нь дайн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан зарлагджээ.



## Дэлхийн улс орнуудад 2007 оноос хойшхи хугацаанд онц байдал зарласан байдал

д/д	Улсын нэр	Он	Онц байдал зарласан шалтгаан
1.	Бангладеш	2007.01.11	Сонгуулийн үр дүнг эсэргүүцэн бий болсон ба 2008 оны 12 дугаар сарын 16-ны өдөр сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрснөөр онц байдал цуцлагдсан байна.
2.	Тайланд, Бангконг	2008.09.02	Ерөнхий сайд Самак Сундавараж иргэдийн бослого дэгдсэн учир онц байдал зарласан ба 2008 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр цуцлагдсан.
3.	Монгол, Улаанбаатар	2008.07.01	Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн иргэдийн жагсаал олон нийтийн эмх замбараагүй байдал болон хувирсан учир 4 хоногийн хугацаатай онц байдал зарласан.
4.	Армени	2008.03.02	Ерөнхийлөгч Роберт Кочарян 2008 оны Армений ерөнхийлөгчийн сонгуулийн дараа бослого үүссэн тул 18 хоногийн хугацаатай онц байдал зарласан.
5.	Пакистан	2007.11.03	Ерөнхийлөгч Первез Мушараф онц байдал зарлаж 2007 оны 12 дугаар сарын 15-ны өдөр цуцлагдсан.
6.	Грек	2007.08.25	Их хэмжээний ойн түймэр гарсан учир онц байдал зарласан ба 2007 оны 8 дугаар сарын 28-ны өдөр цуцлагдсан.
7.	АНУ, Калифорни, Санта Клара Коунти	2007.01	Өмнө нь тохиолдож байгаагүй их хэмжээний хүйтрэлт болсноос онц байдал зарласан.

**2.3.** Монгол Улсын үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, Онц байдлын тухай хуулиудад "Монгол Улсын Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц буюу дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөөх захирамж өгөх бүрэн эрхтэй" талаарх зохицуулалт тусгагджээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 194 дугаар зарлигаар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод дөрөв хоногийн онц байдал зарласан.

Түүнчлэн үндсэн хууль болон Онц байдлын тухай хуулийн дагуу Ерөнхийлөгч онц байдал зарласан бол Улсын Их Хурал зарлигийг гарсан өдрөөс хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал онц байдал тогтоох шаардлагагүй гэж үзвэл уул зарлиг хүчингүй болно гэж заажээ.

Улсын Их Хурал 2008 оны 7 дугаар сарын 3-ны өдөр онц байдал тогтоосон Ерөнхийлөгчийн зарлигийг хэлэлцэж, 52 дугаар тогтоолоор Ерөнхийлөгчийн 194 дүгээр зарлигийг баталсан байна. Иймээс энэ үйл явдалтай холбоотойгоор Ерөнхийлөгч онц байдал зарласан нь Монгол Улсын үндсэн хууль бусад хуулийн хүрээнд хүний эрх, эрх чөлөө, нийгмийн аюулгүй байдлыг хангахаар, хуулийн хүрээнд хийгдсэн арга хэмжээ гэж үзэж байна.

**2.4.** Харин онц байдлыг хэрэгжүүлэх, олон нийтэд түргэн шуурхай мэдээлэх, үр дагаврыг нь тайлбарлан таниулах, үймээн, самуунд оролцогчдыг баривчлах явцад хүний эрхийн багагүй зөрчил гарсан болохыг олон улсын болон дотоодын хүний эрхийн байгууллагууд шүүмжилж байгааг үндэслэлтэй гэж үзэж байна.

**2.5.** Онц байдлыг хэрэгжүүлэх, олон нийтийн эмх замбараагүй байдлыг тараах, түүнд оролцогчдыг саатуулах, баривчлах явцад 4 хүний амь нас хохирч, зарим иргэдийг хүнд гэмтээсэн нь хүний амьд явах эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл гэж үзнэ. Төрийн хуулийг сахиулж, иргэдийн амгалан тайван байдлыг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага иргэнийхээ амьд явах эрхийг хангаж чадаагүй нь нэгэнт тодорхой байгаа ба олон улсын, дотоодын хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд хурцаар шүүмжилж, цагдаагийн байгууллагын алба хаагчид 4 иргэний амь насыг хохироосон гэж үзэн олон тооны мэдэгдэл, мэдээлэл хийснийг зүй ёсны асуудал гэж үзэж байна.

Монгол Улсын үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. Эрүүгийн хуульд заасан "Онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг

хатуу хориглоно” гэж, арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуулиар хязгаарлаж болно. Тийхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг “үл хөндөнө” гэж заасан, үндсэн хуулийн энэхүү заалт онц байдал тогтоосон үед хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой олон улсын гэрээ конвенцийн шаардлагыг хангасан байна. Гэсэн хэдий ч цагдаагийн байгууллагын ажилтнууд үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн заалтыг үл ойлшоож, жагсаал цуглаанд оролцсон хүмүүсийг гараах явцад иргэдийн амь нас хохирсныг юугаар ч зөвтгөх аргагүй. Зарим мэдээллийн эх сурвалжаар цагдаагийн ажилтнууд иргэдийг хойноос нь машинаар хөөж байгаад буудсан тухай мэдээлж байсан. Амь насаараа хохирсон иргэд гартаа галт зэвсэг барьж, хүний амь нас бусниулахыг завдаагүй, ийм нөхцөл байдал тогтоогдоогүй байна. Энэ ноцтой хэргийг Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба мөрдөн шалгаж байгаа хэдий ч мөрдөн байцаалтын ажиллагаа ихээхэн удаашралтай байна. Хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй боловч гэсэн амь насаа алдсан иргэдийг цагдаагийн ажилтан буудсан нь тогтоогдож байгаа гэдгийг холбогдох албаны эх сурвалжууд нэгэнт мэдээлсэн болно. Хууль журмын заалтыг үл биелүүлж, иргэдийнхээ амь насанд халдаж буудсан, тушаал шийдвэр, заавар өгсөн албан тушаалтныг үнэн зөвөөр тогтоож, зохих хариуцлага хүлээлгэхийг иргэд, хохирогчид хүлээсээр байна. Гэм буруутай хүмүүсийг нэг бүрчлэн олж тогтоон зохих хариуцлага хүлээлгэх нь цагдаагийн ажилтнууд хуулийн хүрээнд шударга, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж ажилладаг болоход нь хатуу сурмаж болно гэж дүгнэж байна.

**2.6.** Түүнчлэн цагдаагийн ажилтнууд онцгой нөхцөл байдалд үүрэг гүйцэтгэх үр чадвар, хүний эрхийн талаарх мэдлэг хангалтгүй байгааг үүссэн нөхцөл байдал харууллаа.

Цагдаагийн байгууллагын тухай хуулиар цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх албан хаагчдад галт зэвсэг олгох, албан хаагчид нь уул зэвсгийг авч явах эрхтэй болохыг тогтоожээ. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 40 дүгээр зүйлд “Гэмт үйлдлийг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол цагдаагийн албан хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон, цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтанд байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсвэл

зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон, хүнийг барьцаанд авсан, ялтан цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд зугтсан, зэвсэглэсэн этгээд зэвсэг хураалгахыг эсэргүүцсэн, хорих, цагдан хорих, баривчлах байранд эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөнд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон тохиолдолд цагдаагийн албан хаагч урьдчилан сануулсны эцэст зэвсэг хэрэглэхээр” заажээ.

Үүний сацуу Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 1994 оны 75 дугаар тушаалаар “Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар”-ыг, Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 15/05 дугаар тушаалаар “Харуул хамгаалалтын алба хаагч галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх, нохой ашиглах заавар”-ыг баталж, зэвсэг хэрэглэх асуудлыг зохицуулжээ. Эдгээр хууль, дүрэм, зааврын заалтаас харахад цагдаагийн албан хаагч дээрх тохиолдлууд үүссэн бол урьдчилан сануулсны дараа шууд галт зэвсэг хэрэглэх эрхтэй байна. Харин галт зэвсгийг ямар хэмжээнд хэрэглэх, амь насыг хохироох хэмжээнд хэрэглэх эсхүл эсэргүүцлийг нь дарах, албадан саатуулах, баривчлах хэмжээнд хэрэглэх эсэх нь тодорхой биш байна. Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц болон үндсэн хуульд “Монгол Улсад зөвхөн хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж, шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор цаазаар авах ял шийтгүүлсэнээс бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэсэн заалт Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн “...урьдчилан сануулсны эцэст галт зэвсэг хэрэглэх эрх олгосон” заалттай нийцэж байгаа эсэхийг ч эргэн харж, хуулийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлага байна.

**2.7.** Төрийн хууль бус халдлагад өртөж, ойр дотны хүнийхээ амь насаар хохирч, хагацал үзсэн хохирогчдод төрөөс шударга нөхөн төлбөр олгож, уучлалт гуйх нь Монгол төрийн үүрэг гэж үзэж байна. Хүний амь нас өөр бусад хор хохиролтой дүйхгүй хэмжээний ноцтой хохирол мөн. Хохирогчдын өмчир хоцорсон ар гэрийнхэн болох үр хүүхэд, өндөр настан, хөдөлмөрийн чадваргүй иргэдийг төр халамжиндаа авч тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх шаардлагатай байна.

**2.8.** Монгол Улсын Ерөнхийлөгч онц байдал зарлахаас хоёр цагийн өмнө Монголын Үндэсний олон нийтийн радио телевизээр “...Хэрэв энэ ажиллагаагаа зогсоохгүй бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх хэмжээнд байдаг алхам хийх шаардлага гарч магадгүй гэж ойлгож байна. Тийм алхам хиймээргүй байна. Гэвч шаардлага гарвал хийнэ”<sup>10</sup> гэж мэдэгдсэн боловч уг мэдэгдлийг нийтийн эмх замбараагүй байдалд оролцогчид болон бусад иргэдэд хангалттай хүргэх арга хэмжээ аваагүй. Иргэдэд хангалттай мэдээлэл

<sup>10</sup> www.president.mn



хүргэж чадаагүй нь гэм зэмгүй иргэд хилсээр баривчилгаанд өртөж хохироход хүргэсэн байна. Онц байдал зарласны дараа цагдаагийн байгууллага 720 орчим хүнийг баривчилж, 266 хүнийг цагдаан хорьсон нь иргэдэд мэдээлэл хүрч чадаагүйгээс болсон гэж дүгнэхэд хүргэж байна. Нэгдсэн үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмжих, хамгаалах асуудлаарх Тусгай илтгэгч болон Эрүүдэн шүүх, бусад хэрцгий, хүмүүнлэг бус харьцаа, шийтгэлийн асуудлаарх Тусгай илтгэчийн Монгол Улсын Засгийн газарт хандан ирүүлсэн албан захидалд "Онцгой байдал зарлахдаа хөл хорьсон талаар иргэдэд хангалттай мэдээлэл өгөх арга хэмжээ аваагүй бөгөөд үүнээс болж гудамжинд байсан энгийн хүмүүс баривчлагдсан байна. Онцгой байдлын үеэр Монголын Үндэсний Олон Нийтийн адио телевизээс бусад бүх радио, телевизэд хориг тавьсан. Дээрх үйлдлийг Монгол Улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг боогдуулах гэсэн шууд оролдлого гэж үзэхэд хүргэж байна"<sup>11</sup> гэж дүгнэсэн юм.

Онц байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалтад "Онц байдал тогтоосон тохиолдолд олшруулах болон дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хязгаарлах буюу хориглох, шаардлагатай бол түр хураан авах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох" арга хэмжээ авч болно гэж заасны дагуу олон нийтийн радио телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг онц байдал тогтоох хугацаанд түр зогсоосон байна.

Монголын Үндэсний олон нийтийн радио телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг зогсоосон нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан "Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх" үндсэн зарчмыг баримталдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд тул онц байдлын үед хамгийн тэнцвэртэй, бодит мэдээллийг хараат бусаар хүргэх боломжтой гэж үзсэнтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Гэвч иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд бусад телевизүүдийн үйл ажиллагааг хаасныг хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх, мэдээлэл тэнцвэртэй байхтай холбон хурцаар шүүмжилжээ. "Онц байдлыг зарлахдаа Монголын үндэсний олон

нийтийн радио телевизээс бусад хэвлэл мэдээллийн бие даасан хэрэгслийн үйл ажиллагааг түр зогсоосон нь мэдээллийн тэнцвэргүй хомс байдлыг үүсгэж, бодит байдлыг бүрэн дүүрэн харуулаагүй мэдээллийг нийгэмд цацах нөхцөлийг бүрдүүлсэн. Нийгэм цочирдсон энэ үед мэдээллийн хомс байдал нь иргэдийн айдас түгшүүрийг улам нэмэгдүүлж, төрийн хамгаалалтанд итгэх итгэлийг нь алдагдуулаад байна. Энэ үйл явдал нь Монголын өнөөгийн нийгэмд ардчиллын баталгаа хэвэрг, хүний эрхийн хамгааллын механизм нэн сул байгааг бэлхнээ харууулаа"<sup>12</sup> гэсэн байна. Мөн "Сүүлийн өдрүүдэд Монголын үндэсний олон нийтийн радио телевиз нь нэг талыг баримталсан, эрх мэдлийн талд үйлчилж буй талаар иргэдээс мэдээлэл ирсээр буйд бид харамсан сэтгэл түгшсээр байна. Олон нийтийн өмнө хүлээсэн хариуцлагаа ёс төртэйгээр биелүүлж, иргэдийнхээ сайн сайхны төлөө энэхүү алдаагаа нэн даруй засаж, хууль ёсны үүргээ нэр төртэйгээр биелүүлж гэж бид найдаж байна"<sup>13</sup> гэжээ. Олон улсын болон дотоодын иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудын дүгнэлт, мэдэгдэл зэргийн үзэл онц байдал тогтоосон үед иргэдэд хангалттай, бодит, үнэн зөв тэнцвэртэй мэдээлэл хүрч чадаагүй байна.

Онц байдлын үед Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх, нийгмийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хэвийн болгох ажлыг зохион байгуулах шуурхай штабыг үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн даргэд байгуулж Штабын даргаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, орлогч даргаар үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга ажиллаж, бүрэлдэхүүнд нь Гадаад хэргийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Зэвсэгт хүчний жанжин штабын, Таниулын ерөнхий газрын, Цагдаагийн ерөнхий газрын, Хил замгаалах ерөнхий газрын, Онцгой байдлын ерөнхий газрын, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга нар багтаж шуурхай штабын мэдээлэл голдуу Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизээр цацагдаж байсан байна.

Хүний эрх, эрх чөлөөг хөндсөн тодорхой хязгаарлалт тогтоож, онц байдал зарлаж, түүнийг хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай штабын бүрэлдэхүүнд хүний эрхийн үндэсний байгууллага болон иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудаас төлөөлөл оролцуулаагүй нь мэдээлэл нэг талыг барьсан, иргэдийн дуу хоолойг сонсоогүй гэсэн дүгнэлтэнд хүргэх үндэслэл болсон байна.

Олон нийтийн эмх замбараагүй байдалтай холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаар нам, улс төрийн хүчнүүд, иргэд, төрийн

<sup>11</sup> 2008 оны 8 дугаар сарын 19-ны АЛ Г/СО 214 (67-14) G/SO 214 (53-21) MNG 1/2008

<sup>12</sup> 2008.07.02 – Хүний эрхийн байгууллагуудын мэдэгдэлээс

<sup>13</sup> 2008.07.06 – Онц байдалтай холбоотой хүний эрхийн мониторинг, хамгааллын эвслийн мэдэгдэлээс



албан хаагчид, улс төрчид болон иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, хууль хяналтын байгууллагуудаас 2008 оны 7 дугаар сарын 1-нээс 2009 оны 1 дүгээр сар хүртэл 5 сарын хугацаанд 7 телевизээр цацагдсан 61 бичлэг, өдөр тутмын 8 сонин, 2 цахим хуудас, долоо хоног тутмын 3 сонингуудад нийтлэгдсэн 272 мэдээ, мэдээлэл, 45 ярилцлага түүнчлэн BBC, CCTV9, "Аль Жазира" зэрэг олон улсын мэдээллийн агентлагуудаар цацагдсан мэдээллүүдэд дүн шинжилгээ хийж үзсэн болно.

Дээрх мэдээ, мэдээлэл, ярилцлагад хяналт шинжилгээ хийж үзэхэд 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр болсон олон нийтийн эмх замбараагүй байдлын улмаас таван хүний амь нас үрэгдсэн, иргэд, ажил үүргээ гүйцэтгэж байсан албан хаагчид эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон болон эмх замбараагүй байдлын үед төр, засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг иргэд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, улс төрчид өөр, өөрийн байр сууринаас авч үзэж үзэл бодлоо илэрхийлж байсан байна. Эдгээр мэдээллийн хэрэгслүүдээр доорх үүний үндсэн эрхүүд зөрчигдсэн гэж үзсэн байна.

1. Хүний амьд явах эрх ноцтой зөрчигдөж цагдаагийн ажилтнууд онц байдал тогтоосны дараа 4 хүнийг буудаж амь насныг нь хохироосон;

2. Мэдээлэл түгээх үйл ажиллагааг язгаарлаж Монголын үндэсний олон нийтийн радио телевизээс бусад телевизүүдийн үйл ажиллагааг үр хааснаар үнэн бодит мэдээлэл иргэдэд гүрээгүй;

3. Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй юрчих, халдашгүй чөлөөтэй байх эрх зөрчигдөж онц байдлын үед хөл хорио тогтоосон нутаг дэвсгэрээс өөр газарт явж байсан иргэдийн эрх төлөөнд халдаж албадан саатуулсан, баривчилсан;

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу баривчлагдан саатуулагдсан хүмүүсийн гэр үйлйнхэн болон өмгөөлөгчдөд нь нэн даруй эдэгдээгүй. 2008 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн айдлаар 30 хүн гэр бүлийнхэнтэйгээ холбогдоогүй;

5. Албадан саатуулагдсан, баривчлагдсан хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүдтэй хэргийг арьцаж, зодож цохисон, хоол ундгүй, хүнд нөхцөлд өөнөөр нь хорьсон;

6. Баривчлагдсан, саатуулагдсан хүмүүст эрхийг нь танилцуулаагүй, баривчилсан ндэслэлийг хэлээгүй, өмгөөлөгчгүй байцаалт авсан, эрх зүйн туслалцаа авах эрхийг нь зөрчсөн;

7. Цагдаа, хүчний байгууллага жагсаал углааныг онц байдал тогтоох хэмжээнд хүргэлгүйгээр таслан зогсоох боломж байсан боловч үсээгүй, зориуд зохион байгуулсан;

8. Амьтасна алдан хүмүүсийн эрхийнхэн, эрүүл мэндээрээ хохирсон иргэдэд зрөөс нөхөн төлбөр олгох.

2.9. үймээн самууны үеэр болон онц байдал тогтоосноос хойш иргэдийг хоморголон, нийтээр нь баривчилж, иргэдийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэж хүний эрхийн байгууллагууд үзэж байна. Комисс ч ийм дүгнэлт хийж байна. Онц байдал зарласны дараа буюу 7 дугаар сарын 2, 3-ны өдрүүдэд Хүний Эрхийн үндэсний Комиссоос албадан саатуулах, баривчлах төвд очиж нөхцөл байдалтай нь танилцахад 26 хүүхэд, 21 эмэгтэй нийтдээ 716 хүн баривчлагдан саатуулагдсан байсан байна. үймээн самуунд оролцсон хүмүүсийг баривчлах ажиллагаа 7 дугаар сарын 1-ээс эхлэн сар орчим хугацаанд үргэлжилжээ. Хүний Эрхийн үндэсний Комисс олон нийтийн эмх замбараагүй байдлын улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон, ял шийтгүүлсэн 100 хүнээс санал асуулга авч үзэхэд 7 дугаар сарын 1-ний өдөр 58 хүн, 7 дугаар сарын 2-10-ны өдрүүдэд 12 хүн, бусад нь 7 дугаар сарын 10-аас хойш баривчлагдсан байна.

2008 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт баривчлагдсан 700 гаруй хүнээс 154 хүн сэжигтэн яллагдагчаар цагдан хоригдож, 180 хүн бусдын батлан даалтанд гадуур шалгагдаж, нийт баривчлагдсан хүмүүсийн 50 гаруй хувь нь баривчлах байрнаас суллагдсан байна. Прокурор, цагдаагийн байгууллагаас авсан сүүлийн үеийн мэдээгээр 7 дугаар сарын 1-ний гэх хэрэгт 280 орчим хүнийг буруутган ял төлөвлөж энэ хэрэг дуусаж байна. Иймээс хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжиг, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон Үндсэн хуулийн заалтыг зөрчиж, олноор нь хоморголон баривчилсан гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Онц байдал тогтоох тухай Ерөнхийлөгчийн зарлигт Улаанбаатар хотын төвийн хэсэг буюу Бага тойрууд шөнийн 22.00 цагаас өглөөний 08.00 цаг хүртэл хөл хөрж, зөрчсөн этгээдийг цагдаа буюу цэргийн эргүүл хөл хорих цаг дуустал, иргэний үнэмлэх, бичиг баримтгүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар албадан саатуулах тухай заасан байна. Гэтэл баривчлагдсан хүмүүсийн дунд судалгаа хийж үзэхэд ихэнхи санал асуулгад оролцогч нь Сүхбаатарын талбайн дэргэдээс баригдсан гэж хариулсан ба зарим нь "Цэцэг" төв, Баянбүрдийн тойрог, "Ардын эрх" сонин газар, Гэмтлийн эмнэлэг, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Ленин клуб, Бөхийн өргөөний урд талын автобусны буудал, Баруун дөрвөн зам, "Тэнгис" кино театры, МУИС-ийн хичээлийн 1 дүгээр байр, 1 дүгээр хороолол, Баянгол дүүргийн 2 болон 9 дүгээр хороо, Төв номын сан, Цэргийн Госпиталын орчмоос баригдсан гэж хариулсан байна. Хөл хорьсон бүсээс гадна явж байсан иргэдийг баривчилж, албадан саатуулсан нь онц байдал тогтоосон Ерөнхийлөгчийн зарлигийг зөрчсөн байна.



2.10. 2008 оны 7 дугаар сарын 1-2-нд шилжих шөнө олон зуун хүн нэгэн зэрэг



баривчилснаас шалтгаалан албадан саатуулах, баривчлах байрны багтаамж хэтэрч, нэг камерт 30 орчим хүнийг бөөнөөр нь хорьж байснаас агаарын бохирдол ихтэй байсан байна. үүнээс гадна байрны багтаамж хүрэлцээгүйгээс задгай талбай дээр нар, бороонд хүмүүсийг бөөнөөр нь галуун цуваагаар суулгаж, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулж, хүнлэг бусаар хандаж байсан байна. Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудаас хийсэн судалгаагаар ундны цэвэр ус хангалттай байсан уу гэсэн асуултанд 75 хувь нь үгүй гэж хариулсан<sup>14</sup>. Баривчлах

Гэвч баривчлагдан шалгагдаж буй хүмүүсийн нөхцөл байдалд хяналт тавихаас өмнө хүмүүсийг баривчлахдаа баривчлагдсан үндэслэлийг хэлээгүй, тэдний ар гэрийнхэнд нэн даруй мэдэгдээгүй, баривчлах, байцаалт авах үедээ өмгөөлөгч авах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй айх эрхийг сануулаагүй, насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс байцаалт авахдаа эцэг эх, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг байлцуулаагүй зэрэг хүний эрхийн зөрчлүүд байсан нь иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудын судалгаанаас харагдаж байна.

2.12. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд "Хэнд ч



байранд байсан хүмүүсийг шаардлагатай хоол хүнсээр хангаагүй байна. Жишээ нь, эхний өдөр зарим газарт огт хоол, ус өгөөгүй, зарим газар нэг ширхэг боорцог, крантны уснаас өөр юм өгөөгүй, хоёр дахь өдөр цай өгчээ<sup>15</sup>.

2.11. Комисс дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийж гэм буруугүй хүмүүсийг нэн даруй суллах, байцаалт авахдаа өмгөөлөгч оролцуулах, гэмт хэргийн холбогдолтой хүмүүсийг шүүхийн шийдвэр гаргуулж холбогдох газарт нь яаралтай байршуулах арга хэмжээ авахыг эрх бүхий байгууллагуудад санал баталгосон. Комиссоос тавьсан саналын дагуу Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн салбар хороод болох "Нийтийн эрх ашгийг хамгаалах стратегийн өмгөөллийн хороо", "Насанд хүрээгүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хороо", "Гадаад харилцааны асуудал эрхэлсэн хороо"-дын 25 өмгөөлөгчийг "Олон нийттэй харилцах төрийн бус байгууллагуудын эвслийн мониторингийн ажлын хэсэг"-ээс зохион байгуулсан хамтарсан уулзалтанд оролцуулсны үндсэн дээр тэдгээр өмгөөлөгчид, нийслэлийн 6 дүүргийн Цагдаагийн хэлтэс дээр биечлэн очиж сэжигтнүүдийн ар гэрийнхэнд хууль зүйн зөвлөгөө өгсөн. Мөн Улсын мөрдөн байцаах газарт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангиас байцаалт авахаар ирүүлсэн сэжигтнүүдэд хууль зүйн зөвлөгөө өгч, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцсон байна. 2008 оны 8 дугаар сарын байдлаар Монголын өмгөөлөгчдийн холбооноос төлбөрийн чадваргүй нь холбогдох баримтаар нотлогдсон 5 хүнд өмгөөлөгч томилон ажилласан байна.

эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно" гэснээс гадна Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах шийтгэхийн эсрэг конвенцийн 2 дугаар зүйлийн 2-т "Дайны байдал, аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал, нийтийг хамарсан онц байдал тогтоох зэрэг нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй" гэж заасан байдаг. Манай улсын дотоодын хууль тогтоомжд ч энэ эрхийг баталгаажуулж өгсөн. Иймээс онц байдал тогтоосон, олон нийтийн эмх замбараагүй байдал бий болсон нөхцөл байдлууд нь эрүүдэн шүүх, хүнлэг бусаар хэрцгий хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг зөвтгөх үндэслэл болохгүй.

Гэвч үймээн самуунд оролцон иргэдийг баривчлах, саатуулах, байцаах явцад хүнлэг бус хэрцгий харьцсан, эрүүдэн шүүсэн, хэрэг тулган хүлээлгэхийг оролдож хүний эрхийг зөрчсөн тухай гомдол, мэдээлэл багагүй гарсан. Ялангуяа, хүний эрхийг хамгаалах иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудаас гаргасан удаа дараагийн мэдэгдэлд энэ тухай тэмдэглэж, эрх нь зөрчигдсөн тодорхой тохиолдлуудыг дурдсан байна. Хүний Эрхийн үндэсний Комисс нөхцөл байдлыг тодруулахаар ял шийтгүүлсэн 100 хүнээс санал асуулга авч үзэхэд баривчлах, байцаах явцад зодсон, хүч хэрэглэсэн, дарамталсан зүйл байна уу гэсэн асуултанд 88 хувь нь тийм гэж, 12 хувь нь үгүй гэж хариулсан байна.

<sup>14</sup> Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг, хамгааллын эвсэл, баримтжуулалтын тайлан, 22-р талд

<sup>15</sup> Онц байдалтай холбоотой хүний эрхийн мониторинг, хамгааллын эвслийн мэдэгдэл

Таныг баривчлах, байцаах явцад зодсон, хүч хэрэглэсэн, дарамталсан зүйл байна уу?



Санал асуулгад оролцсон зарим хүмүүс "Дэнжийн мянгад өмгөөлөгчгүй байцааж зодсон. Цахилгаан бороохой хэрэглэж, сэтгэл санааны дарамтанд орсон", "Намайг мөрдөн байцаалтын явцад хуурч мэхэлсэн. Ганц чулуу шидлээ гээд та нарыг шоронд хийхгүй. Их л удаж захиргааны арга хэмжээ авна биз. Олон мянган хүнийг шоронд хийх зай ч байхгүй гэх мэтээр хуурч байсан", "Намайг зодож хэрэг хүлээлгэсэн. Байцаагч хуурсан. Чулуу шидсэн гэвэл яах ч үгүй явуулна. Шидсэн гэж хэлэхгүй бол ганц хуудгийн шоронг мэдэх үү, тэнд хийчих нь шүү гэж айлгасан", "Хүч хэрэглэж, эрүүдэн шүүж, худал мэдүүлэг авсан. Мэдүүлэг зохион бичиж зодож гарын үсэг зуруулсан", "Үүнийг бичихэд үнэхээр хүнд байна. Учир нь тэр олон цагдаа нар бүгд зодсон. Дэнжийн мянга дахь албадан саатуулах төвийн цагдаа нар ухаан алдахад тогоор цохиулж сэрээгээд дахиад зодсон", "Зодсон. Гэрээс гаргаад машинд суулгаад "Чи чулуу шидсэн биз дээ" гээд зодсон. За больё, зүгээр чи цонхоор компьютерын процесс шидсэн гээд хэлчих. Чи шүүхдээд зүгээр ялгүй гарчихна гэж хэлсэн. Ингэж зодуулж байхаар зөвшөөрчих гээд намайг зодсон. Тэгэхээр нь би хэлсэн, айсан, өвдсөн" гэж хариулсан байна.

Эрүүдэн шүүгдсэн, зодуулсан, дарамтлуулсан талаар гомдлоо гаргасан уу гэсэн асуултанд 45 хувь нь тийм, 52 хувь нь үгүй гэж, 3 хувь нь асуултад хариулаагүй, харин таны гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ гэсэн асуултанд гомдол гаргасан хүмүүсийн 69 хувь нь миний гомдлыг шийдвэрлээгүй, авч хэлэлцээгүй гэж хариулсан байна.

Ийм төрлийн гомдлуудыг нь цаг тухайдаа гаргаагүйгээс түүнийг нь нотлох боломж алдагдсан байж болно. Тодорхой гэмт хэрэгт холбогдон цагдан хоригдсон хүмүүсийг цагдан хорих байранд хүлээн авч үзлэг хийхэд зодуулж, цохиулсан, биедээ гэмтэл, шарх авсан цөөнгүй хүмүүс байсан тухай албаны эх сурвалж мэдээлж байсан болно.

Эрүүдэн шүүгдсэн, зодуулж цохиулсан, хэрэг тулган хүлээлгэх гэсэн утга агуулгатай гомдлыг Хүний эрхийн үндэсний комисст 10 иргэн, Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд 11 иргэн гаргаж, шалгагдсан

боловч Нийслэлийн прокурорын газарт хянагдан эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж хаасан байна. Мөрдөн байцаах албанд гаргасан иргэдийн гомдлын 3 нь резинэн сумтай буугаар буудуулсны улмаас нүд нь сохорсон, гэмтсэн, бусад нь цагдаагийн ажилтнуудад зодуулж, дарамтлуулж, хүчээр хэрэг хүлээсэн, хилс хэрэгт шийтгүүлэх гэж байна гэсэн утгатай байсан байна<sup>16</sup>. Эрүү үүсгэхээс татгалзаж хаасан эдгээр материалуудтай тус Комисс судалгааны зорилгоор танилцах хүсэлт тавьсан боловч Нийслэлийн Прокурорын удирдлагууд Комиссын хүсэлтийг хүлээж аваагүй<sup>17</sup>.

Дээрх баримт, судалгаанууд нь олон нийтийн эмх замбараагүй байдал бий болгосон хүмүүсийг саатуулах, баривчлах, байцаах явцад эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар, хэрцгий, догшин харьцах зөрчил ямар нэг хэмжээгээр гарч байсан гэж үзэх үндэстэй байна. Гэхдээ тэдгээр хүмүүсийг албадан саатуулах, баривчлах үед цагдаагийн ажилтнуудыг эсэргүүцсэн, амь, биед нь халдсан хүмүүст эрх, үүргийнхээ дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл болох бороохой, гав, хүлэг хэрэгсэлийн улмаас тэдгээр хүмүүст гэмтэл бэртэл учирсан байхыг үгүйсгэхгүй. Тодруулбал хүч хэрэглэсэн нь хууль ёсны болон хууль бус байсан эсэхийг ялгаж салгасан судалгаа дүгнэлт гараагүй, тийм ч боломж байхгүй гэдгийг дурдах нь зүйтэй.

2.13. 2008 оны 7 дугаар сарын 1-ний үймээн самуунд оролцсон хүмүүсийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйл "Бусдын эд зүйлийг хулгайлах", 146 дугаар зүйл "Бусдын эд зүйлийг булаах", 147 дугаар зүйл "Бусдын эд зүйлийг дээрэмдэх", 153 дугаар зүйл "Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах гэмтээх", 155 дугаар зүйл "Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах", 179 дүгээр зүйл "Нийтийн эмх замбараагүй байдал бий болгох" зүйл ангиар зүйлчилж, ял шийтгэл оноосон байна.

Нийслэл, дүүргүүдийн Шүүхээр хэрэг нь шийдвэрлэгдэж ял шийтгүүлсэн 244 хүнд оногдуулсан ял шийтгэлийн байдлыг дараах хүснэгтээр харуулав.

Комисс үймээн самууны хэрэгт холбогдосдыг хэт хатуу чанга ял шийтгэл оноохыг зорилго зохион байгуулж, харгис хэрцгий ял шийтгэл оноож байна гэсэн гомдол, мэдээлэл ихээхэн гарч байгаад дүгнэлт хийж, ерөнхий дүр зургийг харуулах зорилгоор Нийслэлийн дүүргүүдийн шүүхийн 45 таслан шийтгэх тогтоолыг уншин судалж, 244 хүнд оноосон ял шийтгэлийн байдалд судалгаа хийж үзэв. Үймээн самууны хэрэгт нийтдээ 280 орчим хүн ял шийтгүүлж байгаа гэж үзэв. Судалгааны объектын хамрагдалт 87.1 хувьтай байгаа учраас судалгааны үр дүн бодитой гэж үзэж болно.

<sup>16</sup> 2008 оны 7-р сарын 1-ний үймээнтэй холбоотой гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн судалгаа. УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба. 2009 он.

<sup>17</sup> ХЗУК-ын тухай хуулийн 19 зүйлийн 18.3 дахь хэсэг: Комиссын гишүүн нь хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгогдсон, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэргийн материалтай танилцаж болно.

Зүйл анги	Хүний тоо	2 хүртэл жил	2-3 жил	3-аас дээш жил	Тэнсэн	Торгох	Баривчлах	Хэрэгсэхгүй болгосон
179 дүгээр зүйлийн 179.1 дэх хэсэг /нийт/	187	45	92	45	-	-	8	4
179 дүгээр зүйлийн 179.1 дэх хэсэг /дангаараа/	97	10	58	25	-	-	4	-
155 дугаар зүйлийн 155.1 дэх хэсэг	61	50	-	2	-	2	-	1
151 дүгээр зүйлийн 151.1 дэх хэсэг	8	-	-	-	-	-	8	-
147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсэг	14	-	5	9	-	-	-	-
147 дугаар зүйлийн 147.2 дахь хэсэг	38	-	1	36	-	-	-	1
147 дугаар зүйлийн 147.3 дахь хэсэг	2	-	-	-	-	-	-	2
145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсэг	-	-	-	-	-	-	-	-
145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэг	8	5	3	-	-	-	-	-
145 дугаар зүйлийн 145.3 дахь хэсэг	13	-	-	13	-	-	-	-
114 дүгээр зүйлийн 114.1 дэх хэсэг	1	1	-	-	-	-	-	-

Дээрх судалгаанаас харахад нийт ял шийтгүүлсэн 244 хүний 86.6 хувьд нь хорих ял, 8.9 хувьд нь баривчлах, 0.8 хувьд нь торгох ял оноож, 8 хүнд нь холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Үймээн самууны хэрэгт оролцсон хүмүүст холбогдох хэргийг хянан шийдвэрлэсэн байдлыг зөв буруу гэдгээр нь бус эдгээр хүмүүст холбогдох хэргийг шийдвэрлэж, ял шийтгэл оноосон байдлыг шүүхийн ял шийтгэлийн өмнөх жилийн улсын дундаж үзүүлэлттэй харьцуулж дүгнэлт хийв.

2007 онд улсын хэмжээнд 8463 хүн, 2008 онд 8495 хүн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдож ял шийтгүүлсний 49.2-50.6 хувьд нь хорих /хорих ялыг нь биечлэн эдлүүлэх/, баривчлах ял оноож байсан байна.<sup>18</sup> Үймээн самууны хэрэгт холбогдсон хүмүүст оноосон ял шийтгэлийг сүүлийн 2 жилийн улсын дундажтай харьцуулж үзэхэд үймээн самууны хэрэгт холбогдогдсон оноосон хорих болон баривчлах ялын хэмжээ бараг 2 дахин их<sup>19</sup> байгаа нь дээрх мэдээ судалгаанаас харагдаж байна.

Эдгээр хэргүүд давж заалдах болон хяналтын шатны шүүхээр дийлэнх нь хянагдаж ял

шийтгэлийг нь хөнгөрүүлсэн, зарим үйлдэл, хэргийг хэрэгсэхгүй болгосон, хорихоос өөр төрлийн ял шийтгэл оноосон тохиолдол цөөнгүй гарч байсан. Тухайлбал, Нийслэлийн давж заалдах шатны шүүхээр 174 хүнд холбогдох 35 хэрэг /бүрэн бус мэдээгээр/ хянан хэлэлцэгдсэнээс 11 хүнд оноосон хорих ялын хэмжээг багасгаж, 1 хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцаан, 2 хүнд оноосон хорих ялыг тэнсэж, 3 хүнд оноосон хорих ялыг хорихоос өөр төрлийн ялаар сольж, 9 хүнд холбогдох зарим зүйл ангийг, 1 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Түүнчлэн, Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны хуралдаанаар эдгээр хэргүүд хянагдаж, цөөнгүй хүний ял шийтгэлийг хөнгөрүүлж, хэрэг, үйлдлийг хэрэгсэхгүй болгосоор байна.<sup>20</sup>

Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссоос олон нийтийн эмх замбараагүй байдлад оролцсон гэж шалгагдан, ял шийтгүүлж, ялаа эдэлж буй 100 хүний дунд санал асуулга явуулж дараах асуултуудаар судалгаа хийж үзсэн болно.

Насны ангилал	16-18	19-25	26-29	30-35	36-40	40-өөс дээш
Хүний тоо	26	41	16	8	3	6


Та дээрх шүүхээс оноосон ял шийтгэлийг хүлээн зөвшөөрч байна уу? гэсэн асуултанд:

<sup>18</sup> 2007, 2008 оны шүүхийн статистик мэдээ тайлангаас.

<sup>19</sup> Зууны мэдээ сонин. 2009 оны 3-р сарын 5. Дугаар-49/3121/ 1-р нүүр. "өмнөх 2 жилд нийт ял шийтгүүлэгчдийн 49.9 хувьд нь л хорих, баривчлах ял оноож байсан бол үймээн самууны хэрэгт холбогдогдсон 95.5 хувьд нь хорих болон баривчлах ял оноосон.

<sup>20</sup> Үймээн самууны тодотголтой шүүх хурлууд УДШ-д өдөр алгасахгүй болж байна. Тухайлбал өчигдөр ЗХ-ийн 179, 147-д заасан үндэслэлээр Н, Б нарт оноосон 7 жилийн хорих ялыг 6 болгож өөрчлөв. М, Э нарт ЗХ-ийн 147-д заасан үндэслэлээр оноосон 6 жилийн хорих ялыг өөрчилж, 155-д зааснаар 3 сар баривчлах болгосон байна. Түүнчлэн Б, Б нарт оноосон 5 жилийн хорих ялыг 3 жил 4 сар болгон өөрчилсөн байна."





Нийт санал асуулгад оролцогчдын 94 хувь нь хүлээн зөвшөөрөхгүй гэсэн бол 5 хувь нь хүлээн зөвшөөрнө, 1 хувь нь бөглөөгүй орхисон байна.

Үүний зэрэгцээгээр үймээн самууны хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг зориуд хаалттай хийж, шүүн таслах үйл ажиллагаа ил тод байх зарчмыг гажуудуулж, үнэн бодит байдлыг ард түмнээс далд, насанд хүрээгүй нэг хүний хэрэгтэй хамт насанд хүрсэн олон хүний хэргийг хамтатган хаалттай шүүх хуралдаанаар хэлэлцэж байна гэсэн шүүмжлэлийг иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, иргэд гаргаж байсан. Манай Комиссын судлан үзсэн шүүхийн таслан шийтгэх тогтоолоос харахад 244<sup>21</sup> хүнд холбогдох 45 хэргээс 16 хэргийг хаалттай шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн байв. Хэргийг мөрдөн шалгасан болон хяналт тавьсан прокурорын ажилтнуудаас ямар нөхцөл байдлыг харгалзан хэргийг ийм маягаар нэгтгэн мөрдөж ял төлөвлөснийг лавлахад зураг бичлэгэн дээр хамт байсан, хамт явж байгааг баригдсан, нэг төрлийн үйлдэл хийсэн зэрэг шалгуурыг нь үндэслэж хамтруулсан гэсэн тайлбар өгч байв. Дээрх тайлбар болон судалгаанд хамрагдсан хэргийн 60 гаруй хувийг нээлттэй хэлэлцсэн зэргээс үзэхэд үймээн самууны хэргийн бодит байдлыг иргэдээс нууцлахын тулд шүүх хуралдааныг хаалттай хийсэн гэж дүгнэх боломжгүй юм.

Шүүхийн практикаас харахад эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлээр буюу үйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсрэг дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх замаар нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан, өдөөн турхирсан хэрэг гарч байгаагүй бөгөөд энэ зүйл ангийг илангуяа, "Өдөөн турхирх" гэдгийг яаж ойлгох, хэрхэн хэрэглэх талаар Улсын Дээд Шүүхээс албан ёсны тайлбар гараагүй байна. Тиймээс энэ зүйл ангийг зөв хэрэглэсэн эсэх, үймээн самуунд оролцсон хүмүүсийг энэ зүйл ангиар шийтгэх үндэслэлгүй, олон улсын практикт зөвхөн зохион байгуулагчдыг нь шийтгэдэг гэсэн санал, шүүмжлэл нэлээд гарсан байна. Энэ үймээн самуунд оролцож чулуу, мод шидэж, нийтийн эмх замбараагүй байдлыг өдөөн турхирсан гэсэн хэргээр зөвхөн Эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлээр Хүний Эрхийн үндэсний Комиссын судалгаанд хамрагдсан 244 хүний 97 хүн ял шийтгүүлсэн байна. Эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь хүндэтгэр гэмт хэрэг<sup>22</sup>-ийн ангилалд багтаж тухайн зүйл ангид торгох, баривчлах, 2-5 жил хүртэл хорих ял заасан бөгөөд оноосон хорих ялыг нь тэнсэх боломжтой байдаг. Гэтэл энэ зүйл ангиар ял шийтгүүлсэн 97

хүний 4 хүнд нь баривчлах ял оноож, бусдад нь зөвхөн хорих ял оноож биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Аливаа улс орон гэмт үйлдэл гэдгийг зөвхөн эрүүгийн хуулиараа тодорхойлдог бөгөөд энэ гэмт үйлдлийг маш тодорхой, ойлгомжтой томьёолж, тодорхойлох нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн хэм хэмжээ байдаг. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийг төсөвтэй хэрэглэхийг хатуу хорьж, гэм буруу нь гарцаагүй нотлох баримтаар тогтоогдсон нөхцөлд 9г хуулийг хэрэглэдэг<sup>23</sup> нь хуулийн онцлог зарчим байдаг. Сүүлийн жилүүдэд Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэд дахин өөрчилж, шинэчилж хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр олон чухал ахиц дэвшил гарсныг хэн ч үгүйсгэхгүй. Гэвч эрүүгийн ял шийтгэлийн бодлого, шүүхийн эрх хэмжээ, эрүүгийн хуулийн зүйл, заалтын ээр, томьёо, ойлгомжгүй байдлын талаар хуульчид, эрдэмтэн, судлаачид хурцаар шүүмжилсээр байгааг хууль санаачлагчид, хууль тогтоогчид анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Нийгэмд үүссэн шударга бус үйл явдал, сонгуулийн будлианаас үүдэлтэй нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас шалтгаалж, олон зуун иргэд ял шийтгүүлж, ажил амьдралаараа хохирч байгааг Комисс харамсаж байна.

### Гурав. Санал, зөвлөмж

Өнгөрсөн оны 7 дугаар сарын 1-нд болсон үйл явдал дээр хийсэн дүгнэлттэй холбогдуулан хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа улам бүр боловсронгуй болгох, гарсан зөрчил дутагдлыг арилгах үүднээс дараахь санал, зөвлөмжийг гаргаж байна.

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, иргэд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд жагсаал цуглаан хийх замаар үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрийн буюу орон нутгийн засаг захиргааны удирдлагаас бүртгэл нэрийн дор зөвшөөрөл авдаг тогтолцоог өөрчлөх, нийтийг хамарсан үймээн самуун, хууль бус жагсаал цуглааныг таслан зогсоох, зэвсэг хэрэглэх зохицуулалтыг боловсронгуй болгож, энэ үйл ажиллагаанд хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүйгээр хүний эрхийг хүндэтгэж ажилладаг арга барилд сургах;

2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийг судлан үзэж, цагдаагийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангаж, ажиллах нөхцөл бололцоог нь хангаж өгөх;

3. Төрийн бодлого, төрийн албан тушаалтны үйл ажиллагааны талаар иргэдийн санал хүсэлтэнд хүндэтгэлтэй хандаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд судлан үзэж хариу өгч, ойлголцдог болох талаар холбогдох хууль журмуудад тусгах, иргэдийг жагсаал, цуглаан зохион байгуулах зэргээр үзэл бодлоо илэрхийлэхдээ улс орны

<sup>21</sup> Тайлбар: Судалгаанд хамрагдсан 244 хүний 23-нь насанд хүрээгүй хүн байв. 1-2 насанд хүрээгүй хүний хэргийн насанд хүрсэн 1-9 хүний хэрэгтэй хамтатган хаалттай шийдсэн байна.

<sup>22</sup> Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17-р зүйлийн 17.3 дахь хэсэг.

<sup>23</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль, 3, 4-р зүйл, 2008 он.



аюулгүй байдал, нийгмийн хэв журам, бусдын эрх, эрх чөлөө, хууль журмыг хүндэтгэн биелүүлдэг болгох талаар ухуулга сурталчилгааны ажлыг эрчимтэй, үр дүнтэй зохион байгуулах;

4. 2008 онд болсон үймээн самууны үеэр амь насаа алдсан иргэдийн ар гэр, үр хүүхдэд болон эрүүл мэндэд хөрөнгөөрөө хохирсон цагдаагийн ажилтнууд, иргэдэд төрөөс хохирлыг нь барагдуулж, нөхөн төлбөр олгох ажлыг шуурхай зохион байгуулах;

5. Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй, ойлгомжтой, хүнлэг болгох талаар нийгэмээс гарч буй санал шүүмжлэл, хуулийн болон шүүхийн практикт судалгаа хийж, холбогдох өөрчлөлтийг хийх;

6. 2008 оны үймээн самууны хэргийн талаар Хүний Эрхийн үндэсний Комиссоос хийсэн үнэлэлт, дүгнэлтэнд хүндэтгэлтэй хандаж, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах үндсэн хуулийнхаа зорилгыг эрхэмлэж, үймээн самууны хэрэгт холбогдсон олон зуун иргэд нэн ялангуяа, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, анх удаа гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн хүмүүст өршөөл үзүүлэх асуудлыг хуулийн хүрээнд даруй шийдвэрлэх;

7. Онц байдал болон хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой онцгой үйл явдлыг зохицуулах ажлыг төрөөс зохион байгуулахдаа хүний эрхийн болон иргэний нийгмийн, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж, санал, дүгнэлтийг нь сонсож, тэдний зүгээс хяналт тавих боломжоор хангадаг болох.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ХҮНИЙ ЭРХ

Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн 2-т "Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхах үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна", арванзургадугаар зүйлийн 11-д "...Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж тунхаглан заасан билээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйлийн 113.1 дэх хэсэгт "Ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, оргнуулсан, хүлээн авсан бол..." гэмт хэрэг гэж үзэж ял шийтгэл оноохоор тусгасан байна.

Түүнчлэн, Монгол Улс нь 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан "Үндэстэн дамнансан зохион

байгуулалттай гэмт хэргийн эсрэг НӨБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-д (цаашид нэмэлт протокол гэнэ) нэгдэн орсон билээ. Эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг зйрчиж болох үйлдлүүдийг дотоодын хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенцээр хориглосон заалт хэдийгээр байгаа боловч энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгааг иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудаас хийсэн судалгааны баримтуудаас харж болохоор байна.

Иймд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор Хүний эрхийн үндэсний Комиссоос "Хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх нь" сэдэвт сургалт, судалгааны ажлыг Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн захялгаар "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний дагуу 2008-2009 онуудад зохион байгуулан ажиллаж байна. Комисс нь энэхүү судалгааны ажлын хүрээнд дотоодын хуулийн заалт нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хэр хөшүүрэг болж байгаад дүн шинжилгээ хийх, хүний эрхийн дээрх ноцтой зөрчил гарахад ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг практик дээр судлан тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд чухам ямар арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх болон түүнд тавих зорилтуудыг дэвшүүлэхийг зорьсон юм.

Сургалт, судалгааны явцад цуглуулсан мэдээлэл, шүүх, хууль хяналтын байгууллагуудаас ирүүлсэн баримт, төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаанд тулгуурлан хүн худалдаалахыг хориглосон болон түүнтэй уялдаатай хууль тогтоомжийн заалтуудад судалгааны дүгнэлт хийв.

**Нэг. Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай олон улсын гэрээ, конвенц ба үндэсний хууль тогтоомж**

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж, гадаад харилцаа өргөжин тэлж, иргэд гадаад улс орнуудад чөлөөтэй зорчиж, ажил эрхлэх, аялж жуулчлах боломж бүрдсэн нь иргэдэд үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө эдлэх сайн талтай ч Монгол орны өнөөгийн нөхцөл байдал, ялангуяа ажилгүйдэл, ядуурлаас болж гадагшаа гарч ажил, хөдөлмөр эрхэлж, орлого олох, амьдралаа дээшлүүлэх, виз гаргуулах гэдсэн иргэдийн хүсэл, хэрэгцээ, шаардлагыг гадаад, дотоодын зарим иргэд, аж ахуйн нэгж байгууллага сөргөөр ашиглаж, тэднийг худалдаалах, ашиг хонжоо олох хэрэгсэл болгох явдал шинээр гарах болжээ.

<sup>1</sup> Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 55:22 тоот тогтоолоор батлав.



Манай улсад хүн худалдаалсан тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр удаа дараа мэдээлж, ийм төрлийн хэрэг бага бус шалгагдах болсон. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд дотоодын хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эдгээр гэмт хэрэг гарч буй шалтгаан, түүнд боломж олгож буй нөхцөл байдлыг тогтоож, тэдгээрийг хуулиар хориглох, арилгах явдал чухал юм. Энэхүү зорилгоор хүн худалдаалах болон эмэгтэйчүүд, хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт үйлдэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчинд судалгаа хийв.

Үндсэн хуулийн аравдугаар зүйлд "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогч дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэж заасан. Түүнчлэн, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хуулиудад Монгол Улсын олон улсын гэрээ дотоодын хууль тогтоомжтой зөрчилдөөл олон улсын гэрээг баримтлахаар зохицуулсан байдаг. Хэдийгээр Монгол Улс өнөөдрийн байдлаар олон улсын хүний эрхийн 50 орчим гэрээ конвенцид нэгдэн орсон ч тэдгээрийн зүйл, заалтууд дотоодын хууль тогтоомжид бүрэн хэмжээгээр тусгагдаж чадаагүйн зэрэгцээ уг гэрээ конвенцийн зүйл, заалтууд ч мйн адил амьдралд төдийлөн хэрэгжиж тусгалаа олоогүй байна.

1.1. "Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай" 1979 оны НҮБ-ын конвенцийг Монгол Улс 1981 онд соёрхон баталжээ. Конвенцийн 6 дугаар зүйлд зааснаар оролцогч улсууд эмэгтэйчүүдийг худалдах, тэднийг биеийг нь үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоохын тулд зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээ авах үүргийг хүлээсэн байдаг. Түүнчлэн, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаагаараас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-д 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсныг өмнө дурдсан билээ.

Манай улсын Эрүүгийн хуульд олон улсын гэрээ, конвенцийн эдгээр заалтуудаас зөвхөн биеийг нь үнэлүүлж, ашиг олохыг хориглох талаарх заалтыг хуульчилж, хүн худалдаалах, тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалах гэсэн гэмт хэргийн ойлголтыг орхигдуулсан хуулийн зүйл ангийг хэрэглэж ирсэн.

2000 онд Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр "Биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор хууран мэхэлж, хүмүүсийг элсүүлсэн бол 4 жил хүртэл хугацаагаар

хорих ялаар шийтгэнэ. Энэ хэргийг урьдчилан тохирсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг элсүүлсэн, буюу биеийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан бол 3-8 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэнэ" гэсэн заалтыг шинээр оруулсан нь хүний биеийг үнэлүүлж ашиг олохоор хууран мэхэлж, гадаадад гаргаж байгаа гэмт хэргийг шийдвэрлэх анхны заалт байв.

2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйлд хүн худалдах, худалдан авах гэсэн гэмт хэргийг 3 хэсэгтэй байхаар тодорхойлж, түүнд хүндрүүлэн үзэх бүрэлдэхүүнгүйгээр хүн худалдсан, худалдан авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох, 300-500 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тогтоож байжээ. Энэ зүйл заалтыг анх удаа хүн худалдаалахыг хориглосон хуулийн заалт гэж үздэг.

2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оноох торгуулийн ялыг хэвээр үлдээж, албадан ажил хийлгэх ялыг хасаж, хорих ялыг таван жил хүртэл хугацаатай болгон тогтоосон байна. Үүнээс харвал энгийн бүрэлдэхүүнтэй (хүндрүүлэн үзэх шалтгаангүй) хүн худалдаалах гэмт хэрэг нь хүндэвтэр гэмт хэргийн ангилалд багтаж байсныг хэвээр үлдээж, зөвхөн хорих ялын хэмжээг бага зэрэг нэмэгдүүлсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлж байсан хуулийн заалтуудыг харьцуулж үзэхэд 2002 оны Эрүүгийн хуулиар 113 дугаар зүйл гурван хэсэгтэй байсан, үүнээс нэг дэх хэсэг нь хүндэвтэр, хоёр дахь хэсэг нь хүнд, гурав дахь хэсэг нь онц хүнд гэмт хэргийн ангилалд хэвээр хадгалагдаж үлдсэн бөгөөд харин хэсэг тус бүрт заасан ялын хувьд (хүнд ангилалд буюу 2 дахь хэсэгт) хөнгөрсөн гэж үзэж болохоор байна.

2000 оны Эрүүгийн хуулиар хүн худалдаалсан хэрэг үйлдсэн этгээдэд оноох ял шийтгэл нь сонгон хэрэглэх боломжгүй, зөвхөн 8 хүртэлх жилийн хугацаатай хорих ялтай байсан. Харин одоо дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулиар (113.1, 113.2) хорих, торгох, 113.3 дугаар зүйлээр зөвхөн хорих ял оногдуулахаар болсон байна. Түүнчлэн, 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.2 дахь хэсгээр буюу хүндрүүлэн үзэх бүрэлдэхүүнтэйгээр хүн худалдаалсан бол 5-10 жилийн хорих ялаар шийтгэхээр тогтоосон байсан бол 2008 оны хуулиар сонгон хэрэглэх ялын төрөлтэй болгож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 251-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл 5-10 жил хорих ял шийтгэхээр тогтоосон байна. Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүн худалдаалсан этгээд нэгэнт зүйл ангид нь заасан учир торгох ял авах бүрэн боломжтой байгаагаас үзэхэд энэ нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн



этгээдэд оноох ялыг хорихоос өөр төрлийн сонгон хэрэглэх ялтай болгож хөнгөрүүлсэн байна.

Одоо мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийг өөрчилж, хүндрүүлэх нөхцөл байдлууд болон ял шийтгэлийн зохицолдоог зөв тодорхойлж, энэ төрлийн хэрэг үйлдэгчдэд зөвхөн хорих ял оноож байхаар өөрчлөх шаардлагатай байна. Бусад улс орны хуулийг судлан үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүст зөвхөн хорих ял оноож, харин ялын хэмжээ нь харилцан адилгүй байдаг байна.

1.2. Эрүүгийн хуулиар (нэмэлт өөрчлөлт) хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлоходоо Нэмэлт протоколын заалтад нийцүүлэхийг зорьсон хэдий ч утга агуулгын хувьд алдаатай зөвхөн тодорхой нөхцөлд хүн худалдаалах нь гэмт хэрэг болно гэсэн агуулгатай болгожээ.

Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.1 дэх хэсгийн "Ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол...шийтгэнэ" гэсэн диспозиц нь найрлага, утга, агуулга, хэллэгийн хувьд ойлгомжгүй байна. Хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан нөхцөлд эрүүгийн хэрэг болохоор байна. Эдгээр нөхцөлүүд нь гэмт этгээд хүн худалдаалах хэргийг үйлдэж буй арга нь юм. Энэ зүйлд "...түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол..." гэж тодорхойлсон нь ч алдаатай болжээ. Дээрх үйлдлүүд нь гэмт хэргийг үйлдэж буй үе шатууд, үйлдлүүдэд хамаарна. Гэтэл энэ зүйлийн диспозицод гэмт хэрэг үйлдэх арга, гэмт үйлдлүүдийг тус тусад нь гэмт хэргийн бүрэлдэхүүн болгож авч үзсэн нь буруу юм.

Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.1, дэх хэсгийн "...эмзэг байдлыг нь далимдуулсан..." гэсний дараа "...түүнчлэн..." гэдэг үг орсноос утга агуулга нь алдагдсан байна. Мөн "...бусдыг..." гэж бичсэнээс хүн худалдаалах гэмт хэрэгт өөр бусад хүнийг элсүүлэх, хулгайлагдсан хүнийг тээвэрлэх, дамжуулах, орогнуулах үйлдэл хийсэн хоёрдахь этгээд гэсэн утгаар ойлгогдохоор байна.

Улсын Дээд Шүүх "тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан" гэдгийг "хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг тээвэрлэх, дамжуулахад туслалцаа дэмжлэг үзүүлэх, хүлээн авах этгээдэд нь шилжүүлэх хүртэл орон байрандаа байлгахыг хэлнэ" гэж тайлбарлажээ. Гэмт хэргийн тодорхой үе шатууд буюу тээвэрлэх, зуучлах, дамжуулах, хүлээн авахад оролцсон хүн бүр гэмт хэргийн хамтран оролцогч болж, бүлэг, эсвэл урьдчилан тохиролцсон бүлэг гэдгээрээ хариуцлага хүлээх ёстой. Иймд дээрх нөхцөл

байдлыг олон улсын гэрээ конвенцийн заалтад нийцүүлэн энэ гэмт хэргийн шинжийг зөв томъёолж, Эрүүгийн хуулинд тусгах нь зүйтэй юм.

"Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай" УДШ-ийн 2008 оны 12 дугаар тогтоолоор "хүн худалдаалах" гэдгийг "тодорхой төлбөртэйгээр (мөнгө, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусдын мэдэлд бүрмөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно" гэж тайлбарлажээ. Энэхүү тайлбар нь: 1. аль нэгэн этгээд, 2. хэн нэнийг (худалдагдаж байгаа хүн), 3. нөгөө этгээд (худалдан авагч)-ийн мэдэлд шилжүүлэн өгсөн байхыг л хүн худалдаалах гэмт хэрэг гэж тодорхойлсон нь Нэмэлт протоколын 3 дугаар зүйлийн "а"-д хүн худалдаалах гэмт хэргийг зорилго, арга, үйлдлээр нь тодорхойлсон заалттай харшилж байна.

УДШ-ийн энэхүү тайлбар нь 2002 оны Эрүүгийн хуулийн хүн худалдах, худалдан авах гэдэгтэй адил утгатай байна. Хүн худалдаалах гэмт хэрэг нь ашиг олох, буюу мөлжих зорилго агуулж, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, өөр этгээдийг хяналтандаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх, хахуульдах зэрэг арга хэрэглэж хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах, орогнуулах, хүлээн авах зэрэг үйлдлүүдийн аль нэгийг хийснээр төгс үйлдэгдсэнд тооцогдоно. Хүмүүг гэдэгт худалдаалагдаж байгаа буюу хохирогч этгээдийг хэлэх бөгөөд заавал нэг нь хүлээн авч, нөгөөдөх нь хүлээлэн өгсөн байхыг шаардахгүй юм.

1.3. Нэмэлт протоколын 6 дугаар зүйлд "оролцогч улс бүр хүн худалдаалах хэргийн хохирогчийн хувийн амьдралыг ба тэдгээрийг бие хүний хувьд, тухайлбал, хүн худалдаалахтай холбогдох тухайн хэргийн шүүн таслах ажиллагааг нууц байлгах арга замаар, дотоодын хууль тогтоомжоор байх болох хэмжээнд хамгаална" гэж заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хүн худалдаалах, хүнийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах, түүнчлэн хохирогчийг хамгаалах чиглэлээр тусгайлан зохицуулалтгүй байна. Нэмэлт протоколын 6 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улс нь хохирогчдын бие бялдар, сэтгэл зүй, нийгэмд эзлэх байр суурийн хувьд нөхөн сэргээх арга хэмжээг, тухайлбал орон байраар хангах, ойлгогдох эхлээр эрхийнх нь талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, эмнэлгийн болон сэтгэл зүйн материаллаг туслалцаа үзүүлэх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших, суралцах бололцоогоор

хангах, нөхөн төлбөр авах боломж олгох хууль зүйн тогтолцоог бий болгох зүй ёсны шаардлага байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28 дугаар зүйлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн эрх, үүргийг тодорхойлохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь хохирогчийг тогтоох, гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд зайлшгүй хийвэл зохих гүйцэтгэх ажлыг эрх бүхий байгууллагад даалгавар бичиж гүйцэтгүүлэх гэнэсээ өөрөөр хохирогчийн эрхийг, тэр бүү хэл байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангахад чиглэсэн ямар ч заалт байхгүй. Харин 187 дугаар зүйлд "Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, түүнчлэн хэрэг бүртгээлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогч бусад этгээдэд тэдгээрийн эрх, үүрэг болон үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг тайлбарлан өгч, байцаан шийтгэх ажиллагааны явцад эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй" гэжээ.

Эдгээр заалтууд нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид эрхээ эдлэх боломжоор хангах гэнэсээ өөрөөр хохирогч, гэрчийн эрхийг хангах, хамгаалах, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээгээгүй гэж хэлж болохоор байна. Иймд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогч, гэрчийн эрхийг хангах, хамгаалах талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээлгэхийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар, харин хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, түүнд тусалцаа үзүүлэх тухай Нэмэлт протоколд заасан асуудлуудыг "Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хохирогчийг хамгаалах тухай" бие даасан хууль гаргаж, түүнд тусгаж өгөх нь зүйтэй гэж үзэж байна. Түүнчлэн, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагуудын хийх ажил, түүний зохион байгуулалт, санхүүжилт, хохирогчийн нэр төр, алдар хүнд, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хохирогчид эрүүл мэндийн, сэтгэл зүйн, хууль зүйн тусалцаа үзүүлэх, хохирол нөхөн төлбөр олгох, эх оронд буцааж авчрах, мэргэжлийн сургалтанд хамруулах, ажлын байраар хангах зэрэг асуудлуудыг цогцоор нь тус хуульд тусгах шаардлагатай юм.

**1.4.** Нэмэлт протоколын 6 дугаар зүйлийн 6.1-т зааснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувийн амьдрал, нэр төрийг нь хамгаалах үүднээс шүүн таслах үйл ажиллагааг хаалттай байдлаар явуулах ёстой байдаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 235 дугаар зүйлд "Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах болон насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхээс бусад бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна" гэж заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн энэхүү заалтыг хэрэглэхэд хувь хүний нууцын талаарх асуудал зайлшгүй хөндөгдөж байна. Хувь хүний нууцын тухай (1995) хуульд зааснаар хувийн нууцад захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг (захидал харилцааны нууц), тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг (эрүүл мэндийн нууц); эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг (хөрөнгийн нууцад); бусад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг (гэр бүлийн нууцад) хамааруулж, хувь хүн өөрөө хувьсвал хувь хүний өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болохоор байна.

Дээр дурдсан хуулийн заалтаас үзэхэд хүн худалдаалахтай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах үйл ажиллагааг хаалттай явуулахаар хуульчлаагүй байна. Харин Шүүхийн тухай (2002) хуулийн 11 дүгээр зүйлд "Хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэг, маргааныг шүүх хуралдаанаар хаалттай хэлэлцэнэ", "Шүүх тухайн хэрэг маргааны онцлогоос шалтгаалж шүүх хуралдааныг хаалттай явуулж болно" гэж заасны дагуу УДШ-ээс тайлбар, зөвлөмж гаргаж энэ төрлийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг хаалттай явуулж байхаар журамлаж болохоор байна. Энэхүү нөхцөл байдлыг харгалзан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувийн амьдралыг нууцлах, хохирогчийн талаарх мэдээллийг хаалттай байлгах, шүүх хуралдааныг хаалттай явуулах зэрэг зохицуулалтыг Эрүүгийн байцаан шийтгэх болон бусад хуульд нэмж оруулах шаардлагатай юм.

**1.5.** Нэмэлт протоколын 9 дүгээр зүйлд "Оролцогч улсууд бүрэн цогц бодлого хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээг тодорхойлно" хэмээгээд "хүн худалдаалах хэрэгээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх, хүн худалдаалах хэргийн хохирогчид, ялангуяа эмэгтэйчүүд ба хүүхдүүдийг дахин хэлмэгдэхээс хамгаалах" гэж заасан заалтыг хэрэгжүүлэх талаар манай улс энэ конвенцид нэгдэн орсноос хойш өнөөдрийг хүртэл ямар нэгэн дорвитой ажил хийгдээгүй байна. 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын 234 дүгээр тогтоолоор "Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг батлан гаргасан бөгөөд харамсалтай нь энэ хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ёстой ХЗДХЯ, ГХЯ, НХХЯ, БСШУЯ зэрэг байгууллагуудаас





дорвитуй хийсэн ажил бараг байхгүй гэж хэлж болохоор байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл 2008 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайдын 54 дүгээр тушаалаар байгуулагдан, анхны хуралдаанаа 2008 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр хийсэн нь, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой яам, түүний албан тушаалтнууд хэр зэрэг хойрго ажиллаж байгааг харуулж байна.

1.6. Нэмэлт протоколын 10 дугаар зүйлийн 10.2-т "Оролцогч улсууд хууль сахиулах, цагаачлалын буюу бусад холбогдох байгууллагын ажилтнуудад хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх асуудлаар сургалт явуулах буюу эрчимжүүлэх болно. Сургалтыг хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, худалдаа хийгчдийг мөрдөн мөшгих, хохирогчдын эрхийг хамгаалах, түүнчлэн тэднийг худалдаа хийгчдээс хамгаалах арга хэлбэрийн асуудалд төвлөрүүлэх нь зохиистой болно..." гэж заасан. Монгол Улсын хэмжээнд эрх зүйн боловсрол олгож буй их дээд сургуулиуд, хууль хяналтын байгууллагууд, ХХЕГ болон ГИХАЭГ-ын хилийн сургалтын төлөвлөгөөнд энэ талаар ямар нэгэн тусгайлан гаргасан сургалтын хөтөлбөр байхгүй байна. Хүний эрхийн үндэсний Комисс, төрийн бус байгууллагууд дангаар болон олон улсын донор байгууллагуудын тусламжтайгаар энэ сургалтыг явуулж байна.

Монгол Улс нь "үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-ын оролцогч улсын хувьд гэрээнд нэгдэн орноосоо эхлэн, конвенцийн заалтуудыг салаа утгагүйгээр дотоодын хууль тогтоомжид тусгах, олон нийтэд мэдээлэн сурталчлах, хууль хяналтын байгууллагууд, ХХЕГ болон ГИХАЭГ-ын албан хаагчдад сургалт зохион байгуулах, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тодорхой төрлийн арга хэмжээнүүдийг төр засгийн бодлогын түвшинд авч хэрэгжүүлж эхлэх ёстой билээ.

1.7. Нэмэлт протоколын 11 дүгээр зүйлийн 11.1-д "Хүмүүс чөлөөтэй шилжин явах талаар олон улсын хэмжээнд хүлээсэн үүргийн хувьд хохирол учруулахгүйгээр оролцогч улсууд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэхэд шаардлагатай байж болох байдлаар хилийн хяналтыг боломжийн хэрээр бэхжүүлнэ" гэж заажээ.

Хилийн тухай (1993) хуулиар Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хил хамгаалах байгууллагын тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлох, хил хамгаалалтанд иргэн, байгууллагыг

оролцуулах, хилийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцагатай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан байдаг. Манай улсын хэмжээнд хилийн 44 боомт ажиллаж ёстойгоос одоогийн байдлаар 25 боомт ажиллаж байгаагийн 10 боомт байнгын ажиллагаатай, бусад нь түр хугацаагаар ажилладаг байна. Хилийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.11-д "улсын хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомтоор нэвтрүүлэх журмыг сахиулахад хяналт тавихын тулд зайлшгүй шаардлагатай бүртгэл хөтөлж энэ зорилгоор үндсэн хуульд харшлахгүй мэдээллийн тогтолцоог ашиглах" талаар заасныг баримтлан өнөөдрийн байдлаар хил нэвтрэх, орох зорчигчдын асуудлыг зохицуулах тухай хувь хүнтэй холбоотой мэдээлэл, хөдөлгөөний талаар нэгдсэн сүлжээг бүрдүүлэн ажилладаг. Монгол Улс нь хил хамгаалах талаар хойд, урд хоёр хөрштэй Засгийн газар хоорондын "Хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай" хэлэлцээрийг 1994 онд ОХУ-тай, 2004 онд БНХАУ-тай тус тус байгуулжээ. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаарх гэрээ, хэлэлцээрийг ГХЯ дагнан байгуулж, тухайн гэрээ, хэлэлцээрийг ХХЕГ мөрдөн ажиллах тогтолцоотой билээ.

Жил бүр хойд, урд хөршийн холбогдох байгууллагуудтай "Хилийн байгууллагуудын хэмжээнд хамтран ажиллах протокол"-ыг тодотгон байгуулж үзэглэн, хамтран ажилладаг байна. Гэвч өнөөдрийн байдлаар хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг эх оронд нь эргүүлэн авч ирэхэд хамтран ажиллах, түүнийг таслан зогсооход чиглэсэн ямар нэгэн гэрээ хэлэлцээр, протоколын заалт байхгүй байна. Чингис хаан нисэх онгоцны буудал, Замын-Үүдийн авто болон төмөр замын боомт, Сүхбаатар, Алтанбулагийн боомтууд нь мэдээллийн нэгдсэн сүлжээгээр хил нэвтрэх, буцаж орж ирсэн иргэдийн мэдээллийг дэлгэрэнгүй хэлбэрээр баталгаажуулдаг боловч хяналтын хувьд анхаарал татсан зарим асуудал байгааг дурдах нь зүйтэй юм. Тухайлбал, байнгын зорчигчийн хөдөлгөөнтэй боомтуудын хувьд зорчигч хувь хүний иргэний бичиг баримтын талаарх мэдээллээс гадна эцэг эх нь хүүхэдтэйгээ хилээр нэвтрэх байгаа эсэх, хүүхэд нь өөрийн хүүхэд мөн эсэх, бусдын хүүхэд дагуулж явж байгаа бол холбогдох баримт бичиг нь бүрэн бөгөөд үнэн зөв эсэх, эргээд буцаж ирэхдээ тухайн хүүхдийг хаана, хэнд ямар үндэслэл, шалтгаанаар орхиж үлдээсэн талаарх баримт байгаа эсэхэд тавих цогц бодлого, хяналтын тогтолцоо байхгүйгээс энэ нь зөвхөн хяналт нэрийн дор ор төдий явагдаж байна гэж үзэх үндэстэй. Мөн хилээр жигэмсэн эмэгтэй гарсан тохиолдолд хийх тусгай тэмдэглэл байхгүй бөгөөд тухайн эмэгтэй дараа нь ганцаар орж ирэх тохиолдолд төрсөн хүүхдийн талаарх асуудалд анхаарал хандуулах шаардлагатай боловч янах, бүртгэх журам байхгүй байна.

## Хоёр. Хүн худалдаалах гэмт хэргийн илрэлүүд

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ээлжит энэхүү илтгэлийг бэлтгэх ажлын хүрээнд хууль хяналт, цагдаагийн байгууллагуудаас хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгасан болон шүүхэд хянан хэлэлцсэн хэрэг, тус Комисст ирсэн өргөдөл, гомдлуудад дүн шинжилгээ хийж судлав.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар хуульчид харилцан адилгүй санал бодолтой, тухайн гэмт хэргийн талаарх байцаан шийтгэх ажиллагааны туршлага болон энэ шинэ төрлийн гэмт хэргийн тухай мэдлэг, мэдээлэл дутмаг зэргээс нэлээдгүй хэргийн зүйлд анги өөр төсөөтэй төрлийн гэмт хэргийн зүйлчлэлээр зүйлчлэгдэн шийдвэрлэгдэж байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал, Комиссоос хөдөө орон нутгийн хууль хяналтын байгууллагын ажилтнуудад "Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг бүслэн зохион байгуулж, сургалтанд оролцогчдоос хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг мэдээллийн талаар 143 хүнээс санал асуулга авахад оролцогчдын 60.8 хувь нь мэдээлэл дунд зэрэг, 12.6 хувь нь мэдээлэл хангалтгүй, 32.9 хувь нь мэдээлэл хангалттай гэж үзжээ.

ЭЦГ-аас ирүүлсэн тоо баримтаар 2006-2008 онуудад улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан "Хүн худалдаалах" гэмт хэрэг 29, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан "Биеэ үнэлэхийг зохион байгуулах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах" гэмт хэрэг 35 тохиолдол бүртгэгдсэн байна.<sup>2</sup>

Харин Цагдаагийн байгууллагаас 2006-2008 онуудын хооронд Эрүүгийн хуулийн "Хүн худалдаалах" зүйл ангиар 18 хэрэг, "Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" зүйл ангиар 39 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан дүн мэдээг гаргажээ.<sup>3</sup>

Нийслэлийн Прокурорын Газраас дээрх 3 жилийн хугацаанд "Хүн худалдаалах" зүйл ангиар 6 хэрэгт, "Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" зүйл ангиар 27 хэрэгт яллах дүгээлт үйлдэн шүүхэд шилжүүлжээ. Нийслэлийн Прокурорын Газраас шүүхэд шилжүүлсэн хүн худалдаалах хэрэгт судалгаа хийж үзвэл дүүргийн шүүхүүд "Хүн худалдаалах" 6 хэрэгээ 4 хэргийн 5 хүнийг тус бүр 10 жилийн хорих ялаар шийтгэн, 1 хэргийн 2 хүнийг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй хэмээн СБД-ийн шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан, харин 1 хэргийн зүйл ангийг "Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" зүйл анги болгон өөрчилж, 3 жилийн хорих ялыг 2 жилээр

хойшлуулсан<sup>4</sup> байна. Эдгээр тоо баримт, үнэмдээ, судалгаануудаас үзэхэд хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулахтай холбоотой хүний эрхийн зөрчил, тэр дундаа эмэгтэйчүүдийн эрхийг ноцтойгоор зөрчих тохиолдол цөөнгүй гарч байгаа гэж үзэх үндэстэй байна.

2.1. Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулахтай холбоотой хүний эрхийн ноцтой зөрчлүүдийн дараахь илрэлүүд онцгой анхаарал татаж байна.

2.1.1. Эмэгтэйчүүдэд өндөр цалин амлаж, зүс царай сайтай байх, мэргэжил огт хамаарахгүй хэмээн хууран мэхэлж, зохион байгуулалттайгаар элсүүлэн, баг болгон хил давуулан худалдаалах хэрэг гарч байна.

Иргэн "Д" гэгч эмэгтэй Япон Улсад явуулж өндөр цалинтай ажилд оруулна хэмээн хууран мэхэлж, эхний ээлжинд 7 эмэгтэйг тус бүр 3,500 ам доллараар 2004 оны 9 сард худалдаж, үүний дараа 2004 оны 10 сард нэр бүхий 10 эмэгтэйг Макао руу худалдахыг завджээ. Дээрх эмэгтэйчүүдийг Макаоод аваачин Макао зочид буудалд массажист нэрийн дор массааж хийлгэн, бэлгийн харьцаанд оруулах, биеэ үнэлэх ажил хийлгэх шалгаруулалт зохион байгуулах, тэнцсэн эмэгтэйчүүдийн заримыг нь хөх томруулах мэс ажилбарт оруулах, хөхөө томруулах шаардлага тавьж, улмаар тэдгээр эмэгтэйчүүдийг үйлчлүүлэгч нарт хөхөөрөө массааж хийх, бэлгийн харьцаанд орж байх болзлыг тулгадаг байна. (СБД-ийн шүүхийн шийтгэх тогтоол, 2006.01.10, №17)

2.1.2. Төвийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевизийн чат, зар сурталчилгааны сонин дээрх булангуудыг ашиглан охид, эмэгтэйчүүдийг хууран мэхэлж өөрсдийн бизнесийн эх сурвалж болгож байна.

Их Британи Улсын иргэн "Ж", Монгол Улсын иргэн "С" нар бүлэглэн өөрсдөө санаачлан төвийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зар гарган, эмэгтэйчүүдийн санхүүгийн хүндрэлтэй байдлыг далимдуулан хуурч мэхлэн 2000-3000 ам-долларын цалин хөлстэй массажист, үйлчлэгчийн ажилд оруулна хэмээн 2 эмэгтэйг хил давуулан Макаоод аваачиж худалдсан байна. (УДШ-ийн хяналтын шатны шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2007.10.19, №430)

2.1.3. Хүн худалдах гэмт хэрэг үйлдэгсдийн зарим нь өөрийнхөө бусдад тавьсан ер төлбөрийг дарах, өөртөө ашиг олохын тулд худал нөхцөл, сайн цалин амлан хууран мэхэлж хүчээр бэлгийн мөлжлөгт татан оруулах явдал гаргаж байна.

<sup>1</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн тоо баримтын талаарх ЭЦГ-ын 2009 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 90/121 дугаар албан бичиг

<sup>2</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн тоо баримтын талаарх ЭЦГ-ын 2009 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 90/121 дугаар албан бичиг

<sup>3</sup> "2006-2008 онд хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн судалгаа" ЦЕГ-ын 2009 оны 1 дүгээр сарын 12-ний өдрийн 4/99 дугаар албан бичиг



Иргэн "М" нь өндөр цалинтай ажилд оруулна хэмээн 5 эмэгтэйд хуурч мэхлэн биеийг нь үнэлүүлэх, мөлжих зорилгоор Сингапур Улсад аваачин хил давуулан худалдаалсан байна. Ингэхдээ Сингапурт аваачсаны дараа гадаад паспорт болон нислэгийн тийжийг хураан авч биеийг нь 150 сингапур долларар үнэлүүлж, "та нарыг энд авч ирэхэд 1000 ам.доллар болсон, одоо 1500 болж авна. Та нар хоол идсэн" гэх зэргээр дарамтлан бүх мөнгийг нь өөртөө авч байснаас хохирогч нар нь хоосон ирсэн талаар шүүхийн шатанд мэдүүлжээ. (УДШ-ийн хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдааны тогтоол, 2008.10.15, №378)

**2.1.4.** Мөн тэвэрийн хэрэгсэл ашиглан, хүч хэрэглэн бусдыг хулгайлан, зодож дарамтлан, бүлэглэн хүчиндэж, ёс бусаар бэлгийн дур хүслээ хангах үйлдлийг хүн худалдах гэмт хэрэг үйлдэхдээ давхар үйлдсэн хэрэг шийдвэрлэгдсэн байна.

"М, П" нар нь 2006 оны 2 дугаар сарын 5-ны өдөр "С.Д.Т" нарын 3 эмэгтэйд гудамжинд явж байхад нь барьж авч машиндаа хүчээр суулган Толгойтод аваачин зодож, шалан дээр зүү зоож түүн дээр сунналгах, шил мод, төмөр хувцасны өлгүүрээр зодож танхайрсан, мөн "А, М" нарын 2 эмэгтэйд гудамжинд машинд сууж байхад нь татаж гарган өөрийнхөө машинд хүчээр суулган авч явж гэр хороололд аваачин дарамталж бүлэглэн хүчиндсэн, ёс бусаар бэлгийн дур хүслээ хангасан гэх мэт 16 охид, эмэгтэйчүүдийг зохион байгуулалттайгаар биеэ үнэлэхэд татан оролцуулан, биеэ үнэлэхийг зохион байгуулж, орон байр, тэвэрийн хэрэгсэл, бусад зүйлээр үйлчилж ашиг олсон байна. Нэр бүхий 5 охиныг өөрийнхөө машинаар хүргэж өгнө гэж хууран мэхлэлт бааранд дагуулан орж үл таних залуучуудад 40.000-60.000 төгрөгөөр худалдаж буудалд орогнуулан хонуулаад өглөө нь өөрсдөө очиж аван, гэрийн хорионд, хатуу чанга хяналтын дор удаан хугацаагаар байлган биеийг нь үнэлүүлэн худалдаж ашиг олж байсан байна.<sup>5</sup>

**2.1.5.** Бусдыг хил дамнуулан худалдаалахдаа насны дээд доод хязгаарыг зааж, мөнгөний аятай нөхцөл санал болгон хуурч мэхлэх, энэ үйлдлийг хийхдээ хүч хэрэглэхээр заналхийлж биеийг нь үнэлүүлж ашиг олох хэрэг гарч байна. Иргэн "Т" нь 18-22 насны охид, эмэгтэйчүүдийг 1500 долларын цалинтай ажилд БНСУ-д явуулж өгнө, тэнд очоод баар, ресторанд зөөгч хийх учраас царай, биеийг нь харж авч байна, зардлаа төлж чадахгүй хүн байвал мөнгө авахгүй, зардлыг нь компаниас гаргаад сунд нь цалингаас нь суутгал хийх замаар төлүүлнэ хэмээн худал амлан 5 эмэгтэйд БНХАУ-ын Макаоод аваачиж очин зочид буудалд биеийг нь үнэлүүлэх зорилгоор

худалдсан байна. Тэгэхдээ биеэ үнэлэх ажлыг хийхгүй бол Монгол буцаахгүй, дургүй хүргээд байвал хил гаргаад хаячихна, чамайг хэн олдог юм бэ? гэх зэргээр хүч хэрэглэхээр заналхийлж биеийг нь үнэлүүлж худалдсан байна.

**2.1.6.** Үүний зэрэгцээ хүн худалдаалах гэмт хэрэгтэй төстэй гэж үзэж болохор биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг, түүнд ял шийтгүүлэгчдийн тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгааг анхаарах шаардлагатай байна.

Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдэхдээ эмэгтэйчүүд, охидыг худалдсан байхад үйлдэл тус бүрийг нарийн шалгаж тогтоолгүйгээр хүн худалдаалах хэргийг орхигдуулан хавтгайруулж, хөнгөн зүйл ангиар буюу Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр зүйлчилж гэмт этгээдүүдэд ял завшуулах боломж олгож байна.

2008 оны Нийслэл, дүүргүүдийн шүүхийн бүтэн жилийн тайлан мэдээнээс харахад "Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" гэмт хэрэгт нийт 19 хэргийн 37 хүнд ял шийтгэл оногдуулжээ. Ял оногдуулсан 37 хүний 32 нь хорих ялаар шийтгэгдэж, 11 хүний хорих ялыг биечлэн эдлүүлж, 19 хүний хорих ялыг тэнсэж, 2 хүнд оногдуулсан хорих ялтай шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулж, 3 хүнийг торгох, 1 хүнийг албадан ажил хийлгэх, 1 хүнийг баривчлах ялаар шийтгэсэн байна. Ял оногдуулсан байдлаас үзэхэд нийт ял шийтгүүлэгчдийн 70.2 хувьд нь хорихоос өөр төрлийн ял оногдуулсан байна.

Насанд хүрээгүй "Н"-ийг 2006 оны 7 дугаар сарын 16-ны өдөр гэр руугаа явж байхад нь найз охиных нь танил залуу "А" гэгч гэрт чинь хүргэж өгнө хэмээн хуурч машиндаа суулган авч явж, ХУД-ийн нутаг дэвсгэрт байрлах ХААИС-ийн урьд талын гэр хороололд үл таних айлд аваачиж, тэр айлын "М" гэгч ах, эгч нар зодож хүчээр биеийг нь үнэлүүлж, мөнгийг нь өөрсдөө авдаг байсан талаар насанд хүрээгүй хохирогч мэдүүлжээ. Прокурор хэргийг Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл ангиар "Биеийг нь үнэлүүлэхэд зуучилсан" гэж яллах дүгнэлт үйлдэж, БЗД-ийн шүүхэд шилжүүлснийг анхан шатны шүүх хүн худалдах гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаа эсэхийг шалгуулахаар нэмэлт мөрдөн байцаалтанд буцаасан байна. Гэтэл тухайн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байсан цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч нь энэ хэргийг огт шалгалгүйгээр прокурор, шүүхэд шилжүүлснийг Нийслэлийн давж залдах шатны шүүх зөвтгөн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож хэргийн зүйлчлэлийг өөрчлүүлэхээр буцаасан баримт байна.

**2.1.7.** Бусдын иргэний баримт бичгийг барьцаанд авч, түүгээрээ шахалтанд оруулан

<sup>5</sup> Б.Сарантуяа. "Хүн худалдаалах ба биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал" 2009 он, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь-Зүүн бүсийн сургалт, семинар



бусдад биеийг нь хүчээр үнэлүүлэн худалдан, мөнгө ихэж дарамталсан хэрэг гарсан байна.

Иргэн "Э" гэгч хохирогч "А"-г БНХАУ-ын Эрээн хотод 1500 юанийн цалинтай зөөгчийн ажилд оруулж өгнө гэж хуур мэхлэх аргаар Эрээн хотод аваачин биеийг нь үнэлүүлэх зорилгоор хил давуулан худалдсан бөгөөд гадаад паспорт болон иргэний бичиг баримтыг өөрсдөө хариуцан гаргуулж хилээр гаргасны дараа иргэний бичиг баримтыг нь хураан авч, чамайг энд мөнгөөр авчирсан, мөнгөө төлсний дараа бичиг баримтаа ав, биеэ үнэлж мөнгөө төл, төлөхгүй бол гадаад паспортыг чинь урна гэж айлган сүрдүүлж биеийг нь үнэлүүлж, өвөрмонгол хүнд худалдан ашиг олж байсан байна.

**2.1.8.** Хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргүүдийг эмэгтэйчүүд болон Монгол Улсад түр буюу удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд ихэвчлэн үйлдэж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

"Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл ангиар ял шийтгүүлэгчдийн 65 хувь нь эмэгтэйчүүд байна. Түүнчлэн, энэ зүйл ангиар ял шийтгүүлэгчдийн насны байдлыг судлахад 19-30 насныхан 9; 31-35 насныхан 18; 36-аас дээш настай болон 18 настай ч хүн байна. Боловсролын хувьд дээд боловсролтой 8; тусгай дунд боловсролтой 4; бүрэн дунд 16; суурь боловсролтой 7; бага боловсролтой 2; гадаадын иргэн 3 хүн, түүнчлэн ажил сургуульгүй хүн 19 хувийг эзэлж байна.

**2.1.9** Манай улсад "Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" гэмт хэргийг нь урьдчилан үгсэн тохирох, тогтвортой үйл ажиллагаа явуулах, зохион байгуулалттай бүлэг үйлддэг болж байгаагийн зэрэгцээ хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдэхдээ танхайрах, бусдын бие махбодид санаатайгаар гэмтэл учруулах, хүнд хор уршиг бий болгох, хүчиндэх, дээрэмдэх гэмт хэрэг давхар үйлдэгдэж байгаад анхаарал хандуулах шаардлагатай болжээ.

"49" гэгч хочтой "М" нь насанд хүрээгүй анхаарал тавих хүнгүй, биеэ хамгаалж чадахгүй "Б" нарын 2 охиныг гудамжинд явж байхад нь айлган сүрдүүлж, зодож, хүч хэрэглэж, цаашид хүч хэрэглэхээр заналхийлж өдөрт дундаар 4-5 удаа биеийг нь үнэлүүлж, олсон орлогыг бүгдийг нь хураан авч, олон хоноогоор гэрийн хорионд байлган дарамталж байжээ.

**Гурав. Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсүүд**

"үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан

зогсоох, шийтгэх тухай протокол"-д нэгдэн орсон улс орон бүр хүн худалдаалагдах тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалагдахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үүргийг хүлээсэн.

Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгт оруулах, биеийг нь зохион байгуулалттайгаар үнэлүүлэх, ашиг олох зэрэг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гол нөхцөл нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад тухайн хэрэг үйлдэгчийг бүрэн илрүүлэх, ялангуяа хохирогч болон гэрчийг хамгаалах явдал чухал байдаг.

Энэ гэмт хэрэг анх бүртгэгдсэнээс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд манай улсад гэмт хэргийн хохирогч хамгаалал, түүний дотор тухайлан хувь хүний нэр төр, алдар хүндтэй холбоотой мэдээллийг нууцлах талаар хийгдсэн дорвитой ажил байхгүй байна. Ер нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон хүмүүсийн хувьд бусад төрлийн гэмт хэргийн хохирогчдоос эрх зүйн байдал (статус) нь өөр байхаар олон улсын гэрээ, конвенциудад заасан байдгийг анхаарах хэрэгтэй байна.

### 3.1. Хохирогч хамгааллын байдал

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь бусад төрлийн гэмт хэргийн хохирогчдоос ихээхэн онцлогтой байдаг. Энэ гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох нь тэдний эрхийг хамгаалах эхний алхам болохыг олон улсын гэрээ, конвенциудад тодорхой тусгаж өгсөн. Хохирогч гэмт хэргийн газраас оргон зугтаж ирсэн, гуравдагч этгээдээс мэдээлэл авсны дагуу илрүүлсэн зэрэг аль ч тохиолдолд хууль хяналтын байгууллагын ажилтнууд тухайн мэдээллийн дагуу түргэн шуурхай арга хэмжээг авах ёстой. Энэ гэмт хэргийн хохирогчдын дийлэнх нь амьдралын боломж муу, орлого хомс, хялбар аргаар мөнгө олох хүсэлтэй, боловсрол нимгэн, бусдад өртэй охид, эмэгтэйчүүд байдаг байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг ямар ч тохиолдолд шийтгэх явдал байх ёсгүй бөгөөд тэдгээрийг хууль бусаар хил нэвтэрч орж ирсэн, бичиг баримтгүй цагаачид гэж үзэн, хууль бусаар оршин суусан хэмээн буруутган, эрүүгийн хариуцлагад татан, давхар хохироох явдал гаргаж болохгүйг анхаарах шаардлагатай байдаг. Хохирогчид ихэнхдээ залилагдсан, хүчиндүүлсэн, зовж тарчилсан, амь нас нь хохирсон, хууль бусаар үр хөндүүлсэн, биеийг нь хүчээр үнэлүүлсэн зэрэг үр дагавруудыг байнга амсдаг байна. Энэ нь алсдаа тухайн хохирогчийн сэтгэл зүй, бие махбодид бодитойгоор нөлөөлж эхэлдэг. Байнгын сэтгэл санааны дарамтанд орох, бусдаас ичих, айх, итгэлгүй болох зэрэг нь тухайн хохирогчийг хар тамхи, мансуурах бодис хэрэглэхэд хүргэх, бие махбодь, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцэд удаан хугацаанд муу нөлөө үзүүлэх, олон төрлийн

өвчинд давхар нэрвэгдэх, зарим тохиолдолд амиа хорлоход хүргэх нөхцөлийг бий болгодог байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд "Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохиргогч гэнэ" гэж тодорхойлон, хохирогчийн байцаан шийтгэх ажиллагааны явцад эдлэх эрх, хүлээх үүргийн талаар зохицуулсан байна. Гэтэл энэ гэмт хэргийн хохирогчид ихэвчлэн айж эмээсний улмаас худал мэдүүлэг өгөх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсноо үгүйсгэх, сэтгэн бодох чадвараа алдаж үнэн зөв мэдүүлэг өгөх чадваргүй болох, болсон явдлын талаар ой санамжаа алдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Хохирогчид эдгээр шинж тэмдгүүд илэрсэн үед мөрдөн байцаалтын ажиллагааг явуулбал Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-д "Хохирогч мэдүүлэг өгөхөөс санаатайгаар татгалзсан, зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заасны дагуу эрүүгийн хариуцлагад татах боломж нээлттэй байна.

Зүй нь сэтгэл зүйн хүнд дарамтанд орсон хохирогчийг байцаахад мэргэжилтний туслалцааг авч хохирогчийг нөхөн сэргээх, түүнийг хэвийн байдалд орсны дараа мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах хэрэгтэй юм. Гэвч байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогчийг хэрхэн хамгаалах, сэтгэл зүйн болон нөхөн сэргээх талаар ямар ч зохицуулалт байхгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдыг байцаан шийтгэх ажиллагаанд оролцохоос зугтах, татгалзахад хүргэж байна.

ЭЦГ, УМБГ, "Хүйсийн тэгш эрхийн төв" ТББ хамтран 2007 онд 26; 2008 онд 41 хохирогчийг БНСУ, БНХАУ (Макао), Малайз, Турк, Швейцарь, Украин зэрэг улсуудаас эх оронд нь буцаан авчирсан байна. Эдгээр хохирогчдоос одоогийн байдлаар 4 хохирогчийг "Хүйсийн тэгш эрхийн төв" ТББ-ын хамгаалах байранд байрлуулсан, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулж, сэтгэл зүйн туслалцаа болон хууль зүйн зөвлөгөө зэрэг нөхөн сэргээлтийн үйлчилгээгээр хангаж байна.

Түүнчлэн, Хүний Эрхийн үндэсний Комисс БНХАУ-ын Эрээн хотоос энэ төрлийн гэмт хэргийн хохирогч 5 эмэгтэйг бүх зардлыг нь хариуцан 2007 оны 5 дугаар сард эх оронд нь авч ирж байв.

Манай улсад өнөөдрийн байдлаар хил орчим болон Нийслэл, дүүргүүдэд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдыг байршуулан хамгаалах байр байхгүй, эмнэлгийн болон нөхөн сэргээх үйлчилгээ явуулдаг эмч, сэтгэл зүйч, хуульчид бэлтгэгдээгүй зэрэг нь хохирогч хамгааллын үйл ажиллагааг цогц хэлбэрээр, нөхөн сэргээх, хийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэхэд хүндрэлтэй байна. Төр засгийн зүгээс тусгай бодлогын дагуу хийвэл зохих эдгээр ажлуудыг төрийн бус

байгууллагууд өөрсдийн санаачлагаар олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр одоогийн түвшинд зохион байгуулж байна.

"Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц"-ийн нэмэлт болох "Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-д зааснаар оролцогч улс бүр хүн худалдаалах хэргийн хохирогчдын хувийн амьдралыг ба тэдгээрийг бие хүний хувьд, тухайлбал, хүн худалдаалахтай холбогдох тухайн хэргийн шүүн таслах ажиллагааг нууц тухайгаар арга замаар, дотоодын хууль тогтоомжоор байж болох хэмжээнд хамгаалахаас гадна зохих орон байраар хангах, хүн худалдаалах хэргийн хохирогчдод ойлгогдох хэлээр, ялангуяа хуулиар тогтоосон эрхийн талаар зөвлөгөө ба мэдээлэл өгөх, эмнэлгийн, сэтгэл зүйн ба материаллаг туслалцаа үзүүлэх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон суралцах бололцоогоор хангах үүргүүдийг Засгийн газруудад үүрэг болгосныг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### 3.2. Гадаад улсын иргэдтэй гэрлэсэн эмэгтэйчүүдийн байдал

Монгол эмэгтэйчүүд гадаадын иргэдтэй гэр бүл болох явдал сүүлийн жилүүдэд анхаарал татах асуудал болоод байна. Ялангуяа, зуучлах товчоо буюу хэн нэгний тусламжтайгаар тодорхой мөнгө төлж гадаадын иргэнтэй гэр бүл болж, харин нутагт очиж хүчирхийлэл дарамтанд өртөж, байнгын боолчлолын байдалд байж, эрх ашиг нь зөрчигдөж байгаа нь хүн худалдаалагдахтай адил төстэй байгаагаас гадна энэ төрлийн гэмт эсрэг гарахад ихээхэн нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болж байна.

Өндөр хөгжилтэй орны иргэдтэй гэр бүл болоход нөхөр нь тэдний хувьд "тэжээгч, хамгаалагч" мэт санагддаг энэхүү зөрүүтэй бодолдоо хөтлөгдөн чинээлэг гадаад хүнтэй гэрлэж амьдрах, мөн ажил хийж их мөнгө олох хүсэлдээ автан "хуурамч гэрлэлт"-ийг хүлээн зөвшөөрч, тухайн улс орныг зорьсноор тэд очсон газрынхаа алслагдсан хөдөө тосгонд хөдөө аж ахуй, гол төлөв газар тариалангийн салбарт ажил эрхлэн "боол"-ын мэт нөхцөлд ажиллаж амьдрах болдог байна.

Иймээс хоёр хүний хоорондын хүсэл зориг, сайн дурын харилцааны үндсэн дээр гэрлэх хүнээ чөлөөтэй сонгон гэр бүл болох эрхийг хэн нэгний ашиг хонжоо олох арга хэрэгсэл болгож байгааг хуулиар хориглох шаардлагатай болжээ. Энэ нь манай улсын иргэд гадаадын иргэдтэй гэр бүл болох, эхнэр нөхрөө өөрөө чөлөөтэй сонгох эрхийг нь хязгаарласан, хориглосон асуудал болохгүй бөгөөд харин тэдний гэр бүл болох эрхийг уруулан ашиглаж, хэн нэгний оролцоотойгоор, төлбөртэйгөөр хийгдэж байгаа ашиг хонжоо ологчдын хуурамч гэрлэлтээс охид, эмэгтэйчүүдийг хилийн чанадад худалдаалагдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ болох юм.





Өнөөдрийн байдлаар гадаад улсын иргэдтэй гэр бүл болж буй нөхцөл байдлыг судлахад гэрлэлт нь дотроо бодитой гэрлэлт, хуурамч гэрлэлт гэсэн 2 төрөлд хуваагдаж байна. Бодитой гэрлэлтийн шалтгаан тодорхой байдаг. Сайн дурын, тэгш эрхийн харилцаанд үндэслэгдэн, элдэв муу зууршил, сэтгэлийн болон ахуйн дарамт, бүхмидал, хөрөнгө санхүүгийн эрхшээл, цалин орлогын хүрэлцээгүй байдлаас дайжиж, түүнээс ангид байх хүсэл сонирхолдоо хөтлөгдөн, гадаад,

байнгын сольсон, нууцлагдмал байдлаар үйл ажиллагаагаа явуулж, ихэвчлэн эрүүл, царайлаг, гэр бүлгүй, ганц бие (салсан, өмнө нь гэрлэж байгаагүй), хагас өнчин гэр бүлд өссөн хидыг сонгодог байна. Зуучлуулагч эмэгтэйчүүдтэй байнга холбоо, харилцаатай байдаг гэх боловч үнэндээ тийм байдаггүйг зуучлалын захиралгат гэрлэлтээс хохирогч болсон охид, эмэгтэйчүүдийн яриа нотлож байна.

Монгол Улсын иргэдийн гадаадын иргэдтэй гэр бүл болсон гэрлэгсдийн 2003-2008 оны түүвэрлэсэн судалгаа<sup>7</sup>

Иргэний харьяалал	Гэрлэгсдийн тоо	Хүйс		Боловсролын байдал		
		эм	эр	бага	дунд	дээд
БНСУ	3204	3220	18	52	2750	269
Япон Улс	231	206	7		187	35
БНХАУ	209	172	27	5	168	29

дотоодод ажиллаж сурч байхдаа гадаад улсын харьяат иргэнтэй танилцан дотно харилцаатай болж дасч гэр бүл болох явдал байна. Хуурамч гэрлэлт нь тухайн оронд байнга оршин суух виз авах, гадаадад гарч ямар ч хамаагүй ажил хөдөлмөр эрхэлж мөнгө олохын тулд, хөрөнгө мөнгөний хувьд боломжийн хүнтэй гэрлэх сонирхолдоо автагдах, мөнгө олох хүслээ биелүүлэхийн тулд гэрлэлтийг хүлээн зөвшөөрдөг боловч гэрлэгч нөгөө тал нь сайхан амлалтаар хуурч нутагтаа аваачин бэлгийн хүчирхийлэл, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт оруулах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгон ашиг хонжлооны хэрэгсэл болгож байж болошгүй байдаг. Гадаадын иргэдтэй гэр бүл болсон манай улсын иргэдийн тоо сүүлийн 10 жилийн дотор 21 дахин нэмэгдэж, тэдгээрийн дийлэнх (90-95 хувь) хувийг эмэгтэйчүүд эзэлж, үүнээс солонгос иргэдтэй гэр бүл болох нь хамгийн өндөр (70 хувь) хувьтай байна. Насны байдлаар нь авч үзвэл зуучлуулагч эмэгтэйчүүдийн 80 хувь нь 18-25 настай, 20 хувь нь 30-35 настай байхад тэдгээрийн нөхөр болж буй гадаадын иргэд нь 35-60 насны хооронд байгаа нь манай эмэгтэйчүүд өөрөөсөө 1 дахин илүү насны зөрүүтэй хүнтэй гэр бүл болж байна.

Тухайлбал, 2006 онд 821, 2007 онд 976, 2008 онд 812 монгол иргэд 79 улс орны иргэдтэй гэр бүлээ батлуулжээ. Дээрх гэр бүлээ батлуулсан 2609 иргэнээс 1827 буюу 70 хувь нь БНСУ, 144 буюу 5,5 хувь нь Япон Улс, 135 буюу 5,1 хувь нь БНХАУ, үлдсэн 13,4 хувь нь бусад улсын иргэд байна<sup>8</sup>. Дээрх БНСУ, Япон Улс, БНХАУ-ын иргэдтэй гэр бүл болсон гэрлэгсдийн тоо жил ирэх тусам өсөж байгаад анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсад гэр бүлийн зуучлалын үйл ажиллагааг эрхэлдэг хувь хүмүүс, компани нь тодорхой хаг, тогтмол байршилгүй, ажилтнаа

...Зуучлалын компани намайг "И" гэгч солонгос иргэнтэй танилцуулахдаа баян чинээлэг, хувьдаа хаустай, олон газар эзэмшдэг, урьд нь гэрлэж байгаагүй зэргээр магтсан, харин энэ бүхэн эсрэгээрээ байсан. Солонгостоо ядуу гэх амьдралтай, хөдөө амьдардаг, жижигхэн байшинтай, бас ногоо тарьдаг талбайтай, урьд нь гэрлээд салсан, маш хэргийн, их архи уудаг, ааш зан муутай. Очсон өдрөөсөө л намайг загнаж харааж, өглөө 6 цагт босгон хоол, цайгаа хийлгэж, ногооны талбай дээрээ өглөөнөөс орой болтол ажиллуулж байсан. Ингээд гадаадын иргэдийг хамгаалах төвд бүх учраа хэлээд 4 хонссон. Гэтэл тус төв нөхөр рүү маань утасдаад таны эхнэр энд байна, их сэтгэл санааны дарамтанд орсон байдалтай, бас 3 сартай жирэмсэн байна гэж хэлсэн. Тэр намайг ирж аваад шууд эмнэлэгт аваачсан. Эмч хүүхэд нь эрүүл өсч байна авахгүй гэж хэлж байхыг сонссон. Харин "И" эмчид хэдэн төгрөг өгсөн. Тэгээд намайг нархозонд оруулсан, сэрсэн чинь 3 сартай хүүхдийг маань авчихсан байсан. Ингээд тэнд би ажил хийж байж Монгол руу ирэх зардлаа олсон. Намайг зуучилсан компани одоо болтол олдохгүй байна...

Гэр бүл-зуучлалын нэгэн компаниар зуучлуулсан хохирогч "С" гэгч охины ярианаас<sup>9</sup>... "А" гэх охин 2007 оны 10 сард солонгос улсын иргэн К гэгчтэй зуучлуулан гэр бүл болоод Солонгос руу явжээ. Солонгост ирснээс хойш нөхөр болох хүн нь эрүүл, согтуу аль ч үедээ элдвээр харааж, зодож, харанхуй хонгилд хонуулах зэргээр дарамталдаг байжээ. Охин угсаар ярих бүртээ "ээж ээ намайг аваач ээ, энд үнэхээр хэцүү байна, намайг Монголоос 12 мянган долларээр худалдаж авсан юм чинь гээд явуулахгүй байна" гэж ярьж байжээ. Энэ талаар ээж нь тус зуучлах товчоонд удаа дараа хандахад "Танай охин өөрөө буруутай, ааш муутайдаа тэгж байгаа, тэгээд ч өөрөө дуртайдаа яваа биз дээ, бидэнд хамаагүй" гээд огт

<sup>7</sup> ИБМУТ-ийн Гадаадын иргэдтэй гэр бүл болсон гэрлэгсдийн 2006-2008 оны судалгааны мэдээ, 2009 оны 1 дүгээр сарын 9-ны өдөр

<sup>8</sup> Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн Гадаадын иргэдтэй гэр бүл болсон гэрлэгсдийн 2003-2008 оны судалгааны мэдээ, 2009 оны 1 дүгээр сарын 9-ны өдөр

<sup>9</sup> Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх<sup>10</sup> илтгэлүүдийн эмхтгэл, 30-р тал, 2009 он



халгаадаггүй, харин ч цаад талд мэдэгдсэнээр охин ээжтэйгээ тусгаар ярих боломжгүй болж, хэсэг хугацаанд сураг тасарчээ. 2008 оны 1 сард охин гэрээсээ зугтсан бөгөөд арай гэж Монголд оржээ. Ээж нь уг асуудлаар хөөцөлдөж явахад тус зуучлах товчоогоор зуучлуулж очоод хүнд нөхцөлд байж байгааг орж ирсэн охидууд тааралдаж байсан тухай хэлсэн<sup>9</sup> байна...

Өөр нэг Гэр бүл-зуучлалын компаниар зуучлуулсан охины ярианаа...<sup>9</sup>

Зуучлалаар дамжуулан гэрлэж, гэр бүл болж байгаа иргэд ихэвчлэн гэрээнд заасан нөхцөлийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй, нэг талын хүсэл зоригийг илэрхийлсэн гэрээнд гарын үсэг зурдаг байна. Гэрээнд тусгасан болзол нь тухайлбал, хуурамчаар гэрлэсэн буюу тодорхой шалтгаангүйгээр салах бол нөгөө талдаа 10.000 ам.доллар, Монголд байхдаа шийдвэр гаргаад нэг оронд орох юм уу сүй тавих ёслол хийсний дараа гэр бүл болохоос татгалзвал нөгөө талдаа 2.000 ам.доллар, гэрлэх өргөдлөө өгсний дараа гэр бүл болохоос татгалзвал 4.000 ам.доллар төлнө, гэрлэхээр сонгогдсон эмэгтэй Солонгост очсон хойноо зугтаж орговол эцэг эх нь зуучлах товчоонд 4.500.000 төгрөг төлөхийг шаардсан байдаг гэжээ.<sup>10</sup> Ийм гэрээнд гарын үсэг зурсан, зуучлагчийн тусламжтайгаар гэр бүл болсон эмэгтэй харийн нутагт очоод эрх ашиг нь зөрчигдөхгүй гэсэн баталгаа байхгүй юм.

Гадаадын иргэдтэй гэр бүлээ батлуулж буй гэрлэгсдийн тоо есөхийн зэрэгцээ гэр бүлээ цуцлуулсан гэрлэгсдийн тоо мөн нэмэгдсэн байна. Тухайлбал, 2006 онд 54; 2007 онд 80; 2008 онд 101 иргэд гэрлэлтээ албан ёсоор цуцлуулснаас солонгос иргэдтэй гэр бүлээ цуцлуулсан гэрлэгсэд 81 хувь буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Дээрх тоо өсөж байгаа нь манай улсад зуучлалын товчооны үйл ажиллагааг явуулж буй иргэд, компаниудтай шууд холбоотой.

....Тус Комисст хандаж иргэн "Г" ирүүлсэн гомдолдоо түүний ганц охин нь "Батхолбоо" гэх гэр бүл зуучлалын компанийн зуучлалаар Солонгос Улсын иргэн Ким гэгчтэй танилцжээ. Охиных нь ирээдүйн нөхөр болох хүн сардаа 3.000.000 төгрөгийн орлоготой, 2 давхар байшин, жимс ногооны том эдлэн газартай, хэрвээ бид гэр бүл болвол эцэг эхэд нь мөнгөн тусламж үзүүлнэ, Солонгост аваачна гэж амласны дагуу 3 сарын дараа охиноо өгч явуулсан байна. Сарын дараа хуримын ёслол эцэг эхийн оролцоогүйгээр хийгдэж, улмаар ямар нэг холбоо, харилцаагүй 2 жил болсон байна. Зуучлалын компанийн захиралтай энд үлдсэн эх нь уулзаж, эцэг нь хүнд өвчтэй хэвтэрт байгаа охиноо уулзуулахыг хүсэж байгаагаа хэлэхэд бидэнд энэ хамаагүй гэсэн тайлбарыг тус компанийн зүгээс өгөн, төд удалгүй ажлын байр, утас хаягаа сольж олдохгүй болсон. Энэ охины эцэг нас барсан бөгөөд эхийнх нь зүгээс охиныхоо

хадмуудтай холбогдоход харин танай охинд манай гэр бүл зуучлалын компанид 20.000.000 төгрөг төлж Солонгост ирүүлсэн, хэрвээ охиноо авмаар байвал бидний мөнгийг төлөх хэрэгтэй гэж үүний дараа охиных нь байнгын дарамтанд байлган, Монгол руу холбогдохгүй байх, мөнгөө төлж байж явах болзлыг тулган паспортыг нь хураасан байна. Гэнц охиноо сайхан амьдраасай гэж хүсэж зуучлалаар танилцсан нөхөр болох хүнд итгээд явуулсан нь ийм байдалд хүргэлээ. Иймд охиныхыг минь эргүүлэн авчирч өгнө үү гэжээ...

ХЭҮК-т ирүүлсэн гомдол, № 2008/41

Хохирогч болсон охид, эмэгтэжүүдийн цөөн хувь нь хүний эрхийн байгууллага болон шүүхэд ханддаг бол дийлэнх нь энэ талаар хэн нэгэнд мэдэгдэхийг хүсдэггүй, улмаар бие болоод сэтгэл санааныхаа гүн хямралд орох, ямар ч мөнгөөд гэрээ ирсэндээ гутрах, найз нөхдөөсөө нуун ичжэ зовдог зэргээс энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал, илрүүлэлт нь үр дүнгүй байна.

Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 11 дэх хэсэг, Гэр бүлийн тухай (1999) хуулийн 3, 6 дугаар зүйлүүдэд "Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаанд дээр үндэслэнэ. Хуульд заасан харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр Монгол Улсад гэрлэж болно. Монгол Улсын иргэд хоорондоо, эсхүл Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гадаад улсад тухайн улсын хуулийн дагуу гэрлэсэн бол Монгол Улсад хүчинтэй тооцогдоно" гэж тус тус заасан байна.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 16 дугаар зүйлд "Эрэгтэй, эмэгтэй хүн чөлөөтэй, бүрэн харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрлэж болно" гэж баталгаажуулсан байдаг.

"Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай" конвенцид<sup>11</sup> Монгол Улс 1991 онд нэгдэн орсон. Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Хуульд заасны дагуу гэрлэлтийг эрх бүхий төлөөлөгчөөр бүртгүүлээгүй, гэрчийг байлцуулаагүй болон хоёр тал гэрлэлтийг чөлөөтэй, бүрэн хүлээн зөвшөөрч байгаагаа өөрийн биеэр илэрхийлээгүй нөхцөлд ямар ч гэрлэлт хууль ёсны хэмээн тооцогдохгүй" гэж заажээ. Иймээс бусдын зуучлал, хэн нэгний оролцоотойгоор, төлбөртэй гэрлэж, гэр бүл болох нь конвенцийн дээрх заалттай харшилж байна.

Олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжийн эдгээр заалтаас үзвэл гэрлэх, гэр бүл болох эрх нь насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэгдсэн, хэн нэгний оролцоогүйгээр, чөлөөтэй, бие биенийгээ танин мэдэж ойлгосноор үүсэх харилцаа юм. Гэтэл нөхөр, эхнэр болох хоёр хүний хань ижлээ чөлөөтэй сонгон гэр бүл болох,

<sup>9</sup> Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх илтгэлүүдийн эмхтгэл, 30-р тал, 2009 он

<sup>10</sup> Зууны мэдээ сонин, "Хүсээгүй гэрлэлт ба Солонгос диваажин", 2008 он

<sup>11</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1962 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

хамтран амьдрах, үр удмаа үлдээх, эрхэм нандин харицааг өөр бусдын ашиг хонжоо олох арга хэрэгсэл болгож байгааг яаж ч зөвтгөх боломжгүй юм.

Гэрлэлтийг зуучлагчид болох албан ёсны зөвшөөрөлгүй хувь хүмүүс, компани нь охид, эмэгтэйчүүдийг элсүүлэхийн тулд хүссэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр "Дундаас дээш амьдралтай, санхүүгийн боломжтой гадаадын иргэдтэй гэрлүүлнэ" гэсэн боломж амласан зарыг тасралтгүй явуулж, ийнхүү зарын дагуу хандсан охид, эмэгтэйчүүдийг зуучлах товчоонд хандсанаас хойш 1-3 сарын хугацаатай байхаар, гэрлэх гэж буй хүнтэйгээ (нөхөр) 1-2 удаагийн уулзалт хийлгэх байдлаар, эсхүл огт уулзуулахгүйгээр гэр бүлийг нь батлуулдаг байна.<sup>12</sup> Энэ төрлийн үйл ажиллагааг эрхлэгчдэд ашиг олох нь чухал болохоос тухайн хүний эрх ашиг төдийлөн чухал бус байдаг.

Гадаадын иргэнтэй гэрлэх, гэр бүл болоход зуучлах үйлчилгээ үзүүлэхийг хориглосон, зөвшөөрсөн тухай хууль одоогоор манай улсад байхгүй бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай (2001) хуульд ч гадаадын иргэдтэй гэр бүл болоход зуучлах үйлчилгээг манай нэгэн байгууллага олгохоор тусгайлсан зохицуулалтгүй билээ. Иймээс гадаадын иргэдтэй гэрлэх, гэр бүл болоход нь зуучлах үйлчилгээ үзүүлсэн нэрийн дор ашиг олох үйл ажиллагааг эрхлэн олон охид, эмэгтэйчүүдийн эрх ашгийг зөрчиж, хохироож байгаад дүгнэлт хийж, энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулсан эсхүл хориглосон хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

### 3.3. Гадаад улсын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлж буй байдал

Монгол Улс нь "Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай" НҮБ-ын конвенцид<sup>13</sup> (Гаагийн конвенц) 1998 онд нэгдэн орсон. Гаагийн конвенц нь улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхол, үндсэн эрхийг олон улсын эрх зүйд нийцүүлэх, хүүхэд хулгайлах, худалдах, хил дамжуулан худалдахаас сэргийлж, тэдгээр баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсууд хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох, хүүхэд үрчлэхийг хүлээн зөвшөөрөх явдлыг хангах үндсэн зорилготой юм.

Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх тухай дотоодын хууль тогтоомжийг конвенцид нийцүүлэн, оролцогч улсын хувьд биелүүлбэл зохих үүргийг манай улс бүрэн биелүүлэх ёстой. Хүүхэд үрчлүүлэх тухай асуудлыг Гэр бүлийн тухай хууль, Хууль зүй дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 дугаар тусгаар бичиг "Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам" зэрэг

эрх зүйн актаар зохицуулж байна. Дотоодын хууль тогтоомжоор хүүхэд үрчлүүлэх, түүнд хяналт тавих, хүүхэд үрчлүүлэхэд хүүхдийн ашиг сонирхлыг хангах асуудлыг хэр зохицуулснаас хүүхдийг худалдаалагдах, бэлгийн мөлжлөгт ашиглагдах, гэмт хэргийн золиос болгохоос урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөө шууд хамаарна.

Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар бүлгээр зохицуулсан хүүхэд үрчлүүлэх асуудлын ихэнх заалт нь дотоодын үрчлэлтийн асуудлыг нарийвчлан, хуулийн 58 дугаар зүйлийн 1-10 дахь заалтуудаар гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авахыг тус тус зохицуулж байна. Эдгээр заалт нь хэтэрхий ерөнхий утга, агуулгатайгаас гадна зөвхөн тухайн гадаадын иргэн өргөдлөө хэрхэн хаана гаргах, өргөдөлдөө ямар баримт бичиг хавсаргах, ямар байгууллага (яам) хүүхэд үрчлүүлэх асуудлыг хариуцахыг л тогтоож өгснөөс өөр тусгайлсан, нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Манай улс 1999-2007 онуудын хооронд гадаадын 13 улсын иргэнд 171 хүүхэд үрчлүүлсэнээс 151 хүүхэд нь 2001-2007 онд үрчлүүлсэн байна. Үүнээс үзэхэд жил тутам 20 гаруй Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэгдэн гадаадад гарч байгаа нь бага бус тоо юм. Гадаадын иргэд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргах ба хүүхэд үрчлэн авахыг эсэцэгийн (нөхөр, эхнэртэй бол хамтарч гаргасан) хүсэлт, түүний нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны орчуулга, үрчлэгч нь сурьез, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэх талаарх эмнэлгийн магадлагаа, өргөдөл гаргагчийн гэрлэлтийн гэрчилгээний хуулбар (гэр бүлтэй бол); өргөдөл гаргагчийн байнга оршин суугаа газрын талаар холбогдох байгууллагын тодорхойлолт (цагдаагийн байгууллагын тодорхойлолт); өргөдөл гаргагчийн амьдралын болон санхүүгийн боломжийн тухай холбогдох байгууллагын тодорхойлолт зэргийг бүрдүүлдэг байна. Эдгээр баримт бичгүүд нь агуулгын хувьд тухайн гадаадын иргэн түүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч нь хүүхэд үрчлэн авах хүсэлтэй байгаа болон тэд хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, ахуй, амьдрал, санхүү, ёс зүй, эрүүл мэндийн бүрэн боломжтой гэдгийг давхар нотлох ёстой билээ.

Эдгээр заалтаас үзэхэд үрчлэлтийн журам нь Гаагийн конвенцийн заалтад нийцэж байгаа ч зарим асуудлыг бүрэн, тодорхой тусгаж зохицуулаагүй нь учир дутагдалтай байна. Тухайлбал, эмнэлгийн байгууллага нь үрчлэгчийн зөвхөн сурьез, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэхийг тодорхойлохоор заасан байна. Зүй нь эмнэлгийн байгууллага эдгээр өвчний зэрэгцээ мансуурах,

<sup>12</sup> Хүн худалдаалах гэмт хэргэ ба охид эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөг" судалгааны тайлан, НҮБ-ын Хүүхдийн сан-Монгол, Хүйсийн тэгш эрхийн төв, Дэлхийн Зөв-Монгол байгууллага, 2007 он

<sup>13</sup> Нэгдсэн үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1995 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

согтуурах донтой эсэх, биеийн эрүүл мэндийн байдал нь ямар болох, түүнчлэн тухайн хүүхдийг зөв өсгөж хүмүүжүүлэхэд биеийн эрүүл мэндийн хувьд харшлах зүйлгүй, бие, сэтгэхүйн хувьд эрүүл гэдгийг эмнэлгийн байгууллагын тодорхойлолтод заах нь чухал юм.

Өргөдөл гаргагчийн амьдралын болон санхүүгийн боломжийн тухай холбогдох байгууллагын тодорхойлолт бүрдүүлэх тухай Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3.5 дахь заалтыг тодруулах шаардлагатай байна. Өргөдөл гаргагч ажил хөдөлмөр эрхэлдэг эсэх, ямар хэмжээний цалин орлоготой болох, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөтэй эсэх, орон байрны нөхцөл зэргийг нь холбогдох байгууллагуудын тодорхойлсноор, өөрөөр хэлбэл, өргөдөл гаргагчийн хувийн байдлыг нарийн тодруулснаар үрчлэлт хүүхдийн дээд эрх ашгт нийцэх эсэх нь тодорхой болох юм.

Удаа дараа ял шийтгүүлж байсан хүнд хүүхэд үрчлүүлж болохгүй гэсэн заалтыг ч эргэж харах шаардлага бий болж байна. Удаа дараа ял шийтгүүлнэ гэдэг ойлголт нь 3 ба түүнээс дээш удаа ял шийтгүүлсэн, онц аюултай гэмт хэрэгтэн гэсэн ойлголтыг илэрхийлдэг. Ер нь эрүүгийн гэмт хэрэгт ял шийтгүүлнэ гэдэг нь тухайн хүний хувийн байдлыг илтгэх том үзүүлэлт мөн. Энэ журмаар бол 1 болон 2 удаа ял шийтгүүлж байсан гадаад улсын иргэнд хүүхэд үрчлүүлж болохоор байна. Нэг, хоёр удаа ял шийтгүүлж байсан хүнд хүүхэд өргүүлнэ гэдэг нь эрсдэл дагуулсан суудал болох юм.

"Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам"-ын 12 дугаар зүйлд заасны дагуу хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүүхэд үрчлэн авах тухай материалыг судлан үзэж боломжтой гэж үзвэл үрчлүүлж болох хүүхдийг сонгож, хүүхдийн эцэг, эхийн болон асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн газрын зөвшөөрлийг бусад бичиг баримтын хамт хүүхэд үрчлэхийг хүссэн хүнд илгээж болохоор байна. Сүүлийн жилүүдэд манай улсад гадаадын голдуу байгууллага, иргэдийн санаачлага, хөрөнгөөр олон тооны хүүхдийн асрамжийн газар үйл ажиллагаа явуулж, зарим асрамжийн газар хүмүүжиж байсан хүүхэд алга болсон тухай хэвлэл мэдээллийн хэргислээр гарах болсныг мөн л анзаарахгүй байх аргагүй юм.

Манай улсын хэмжээгээр 2008 оны байдлаар<sup>14</sup> албан ёсны зөвшөөрөл бүхий хүүхэд асрамж халамжийн 44 төв үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үүний 19-ийг нь гадаад улсын 9 иргэн удирдан ажиллуулж байна. Эдгээрт 1364 хүүхэд амьдарч байгаагаас эрэгтэй 666, эмэгтэй 698 хүүхэд гэсэн мэдээ байна. Ийм нөхцөлд асрамжийн газар амьдарч буй эцэг, эхгүй хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэхдээ зөвхөн асрамжийн газрын зөвшөөрлийг авах нь хангалттай биш байна. Асрамжийн газар амьдарч буй хүүхдийг үрчлүүлэхдээ асрамжийн газрын зөвшөөрлөөс гадна орон нутгийн засаг захиргааны болон

Цагдаагийн байгууллагын зөвшөөрлийг авах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

...Тус Комисст иргэн "А" нь 4 жилийн өмнө оюутан ахуй цагтаа жирэмсэн болж, ар гэрийн гачигдал, эцэг эхдээ хэлэхээс айсан, хөдөөнөөс ирсэн байсан зэрэг нөхцөл байдлаас болж өөрийн төрүүлсэн хүүхдээ аргагүйн эрхэнд хүүхэд асрамжийн төвд шилжүүлсэн. Ингээд сургуулиа төгсөн нөхөртэй болж, дахин хүүхэд төрүүлэн асрамжийн төвд шилжүүлсэн хүүхдээ буцааж авахаар шийдэн нөхөртэйгөө хамт хөөцөлдөн, Улаанбаатар хотын бүх асрамжийн төвүүдээр хайсны үр дүнд охиноо шилжүүлсэн асрамжийн төвийг олсон. Ингээд учир байрлаа хэлэн охиноо харах гэтэл уулзуулахгүй, нууц гээд мэдээлэл өгөхгүй байгаа тул хүүхдийн талаарх мэдээллийг олж өгөхөд тусална уу гэж хандсан. Өргөдлийн дагуу хүүхдийн мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч танилцахад хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсэн байсан.

ХЭҮК-т ирүүлсэн өргөдөл, № 2007/68

Энэхүү үрчлэлт хийгдсэн нөхцөл байдлыг судлахад гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэх журамд заасан хүүхдийн эцэг эх сураггүй алга болсон буюу нас барсанд тооцогдсон, эсхүл эцэг эх байх эрхээ хасуулсан бол энэ тухай шүүхийн шийдвэр болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэд үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл, (энэ шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа хүүхдийг үрчлүүлнэ) түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасныг үндэслэн эцэг эх байх эрхийг нь шүүхээр шийдвэрлүүлсний дараа хүүхдийг үрчлүүлэхээр байна. Гэтэл энэ талаар хийгдсэн ямар нэг тодорхой ажиллагаа байхгүй, харин хүүхдийн эцэг эхийг эрэн сурвалжлах ажиллагаа хийгдсэн боловч тогтоогдоогүй, хүүхдийг үрчлүүлэхэд манай зүгээс татгалзах зүйлгүй гэсэн Цагдаагийн хэлтсийн албан бичгийг үндэслэж, хүүхэд үрчлүүлэх тухай дүгнэлтийг гарган гадаад ирчлэлтийг хийж байгаад холбогдох байгууллагууд анхаарах хэрэгтэй байна.

Журмын 15 дугаар зүйлд хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэний хүлээх үүргийг тодорхойлсон боловч энэ нь хэт ерөнхий, үүргийг хэрхэн, яаж биелүүлэхийг тодорхой заагаагүй байна. Тухайлбал, хүүхдийн эх орон, шаардлагатай бол эцэг, эхийг мэдүүлэх, хүүхдийн талаар 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл 2 жил тутам ГИХАЭГ-т мэдээлэл ирүүлж байх, шаардлагатай бол Монгол Улсын эрх бүхий байгууллагаас тухайн хүүхдийн аж байдалтай танилцах, түүнтэй ярилцах боломжоор хангахыг үүрэг болгосон. Журмын энэхүү заалт нь тухайн хүүхдийг эрүүл саруул, эсэн мэнд бойжиж байгааг илтгэх, аливаа хууль бус үйл ажиллагаанд өртөөгүйг харуулж байх ёстой байтал нэгэнт газар дээр нь тэр болгон очиж, танилцах боломжгүй байдлаас шалтгаалан Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авсан гадаадын

<sup>14</sup> "Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдийн талаарх бэлч мэдээлэл", Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2009 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 1/48 дугаар албан бичиг



иргэний өгч буй мэдээллийн үнэн худлыг шалгах боломж хязгаарлагдмал байна.

Зарим улс орон гадаадад үрчлэгдсэн хүүхдийг тодорхой хугацаанд эх оронд нь авчирч, танилцуулж, үрчлэх зөвшөөрөл олгосон байгууллагад хүүхдийн ашиг сонирхол зөрчигдөөгүй болохыг бодитоор харуулахыг үүрэг болгодог тогтолцоотой байдаг. Хүүхдийн аж байдалтай газар дээр нь очиж танилцах эрх үүрэг ГИХАЭГ-т байдаг хэдий ч хөрөнгийн бололцооноос шалтгаалан тэр болгон очиж танилцах боломж олддоггүй тухай мэдээллийг өгч байна. Ер нь гадаадад хүүхэд үрчлүүлэхэд тавигдах гол шаардлага бол үрчлэлт нь хүүхдийн дээд эрх ашигт нийцэж байгаа эсэх, хүүхэд худалдаалагдах, бэлгийн мөлжлөгт ашиглагдахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийг үрчлүүлэх болон үрчилсний дараах хяналт чухал болохыг анхаарах шаардлагатай юм.

Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх журмаар хуульд тусгагдаагүй зарим хязгаарлалтыг тогтоосны дээр журмыг батлахад Эрүүл мэндийн сайд оролцоогүй нь үрчлэгчид тавигдах эрүүл мэндийн шаардлагыг биелүүлэхэд бэрхшээл учруулж, улмаар Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7 дахь заалтыг зөрчиж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д зааснаар "Монгол Улсын харьяат болох харьяатаас гарах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ" гэсэн заалт үрчлэгдэж байгаа хүүхдийн хувьд хэрхэн хэрэгждэг вэ гэдэг асуудал зүй ёсоор тавигдаж байна. Дээрх хоёр сайдын баталсан журмаар энэ асуудал Ерөнхийлөгчид огт хамаарахгүйгээр зөвхөн хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон ГИХАЭГ-ын хооронд шийдвэрлэгдэхээр зохицуулсан нь иргэн, харьяатдаа ялгаавартайгаар хандаж байгаагийн нэг илрэл юм. Мөн гадаадын иргэнд Монгол Улсын харьяатын хүүхэд үрчлэн авах тухай материалыг судлан үзэж, хангалттай гэж үзвэл 30 хоногийн дотор үрчлэгдэх хүүхдийн судалгааг гарган, тухайн гадаадын иргэнд холбогдох байгууллагаар дамжуулан хүүхдийн судалгааг хүргүүлэхээр зохицуулж байгаагаас үзэхэд хугацааны хувьд тийм ч хангалттай бус байгааг дурдаж байна.

Гэр бүлийн тухай хуулийн 56 дугаар зүйлд "Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн хэмжээн дэх хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн судалгаа гаргаж, бүртгэл хөтөлнө. Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн нэгдсэн бүртгэл хөтөлж, хяналт тавина" гэж заажээ. Харин хуульд үрчлүүлэх шаардлагатай хүүхэд гэдэгт ямар хүүхэд орох, ямар шаардлага тавигдах нь тодорхой бус байна. Үрчлүүлэх шаардлагатай хүүхэд гэдэгт эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч үрчлүүлэх хүсэлтэй байгаа хүүхдүүд, эцэг, эх нь тодорхойгүй, эсхүл

эцэг, эх нь байсан ч гэсэн хүүхдээ асран хүмүүжүүлэх үүргээ биелүүлдэггүйгээс тэнэмэл амьдралд шилжсэн хүүхдүүд, хүүхдийн асрамж халамжийн газар, хүүхдийн албадан саатуулах газарт байгаа хүүхдүүдийг хамруулж болох юм. Өөрөөр хэлбэл, эдгээр хүүхдүүд нь худалдаалагдах, бэлгийн мөлжлөгт ашиглагдах, гэмт хэргийн хохирогч болох өндөр эрсдэлийг дагуулж байдаг. Сум, дүүрэг бүр ийм хүүхдийн бүртгэлтэй болж, хөдөлгөөнд нь байнга хяналт тавьж ажилласнаар тухайн хүүхдийг худалдаалагдах, гэмт хэргийн хохирогч болох, сураггүй алга болохоос урьдчилан сэргийлэх анхдагч нөхцлийг бүрдүүлнэ.

Гэр бүлийн тухай хууль, Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх журам зэргийг хянан үзэж, гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхдээ үрчлэгчид ямар шаардлага, болзол тавигдахыг хуулиар нарийвчлан тогтоож, үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдал хяналт тавих, эх оронд нь тодорхой хугацаанд зочлуулж, хүүхдийг эцэг эхтэй нь уулзуулах, эх оронтой нь болон хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад танилцуулах үүрэг зэргийг хуульчлах шаардлагатай байна.

### 3.4. Хүүхдийг бэлгийн мйлжлэгт болон садар самуунд ашиглахыг хориглосон хууль тогтоомж түүний хэрэгжилтийн талаар

Монгол Улс нь "Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцэд оруулах нэмэлт протокол"<sup>15</sup>-д 2001 онд гарын үсэг зурж, 2002 онд нэгдэн орсон. Протокол нь хүүхдийг худалдах, бэлгийн мөлжлөгт ашиглах, хүүхдийг садар самуунд ашиглах явдлыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, эдгээр гэмт хэргэ үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлагыг сайжруулах үндсэн зорилготой. Түүнчлэн, хүүхэд худалдаалах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлах гэдгийг тодорхойлохын сацуу, эдгээрийг гэмт хэргэ гэж үзэх, Эрүүгийн хуульдаа тусгах, эдгээр гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол түүнд хүлээлгэх хариуцлага нь эрүүгийн, иргэний, захиргааныг байж болохыг заажээ.

Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд уруу татах, садар самууны сурталчилгаанд ашиглах нь тэднийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг дагуулдаг учир энэ төрлийн гэмт хэргэтийг тэмцэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай.

Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлд "Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлал болон биеэ үнэлэхэд татан оруулсан бол..." гэмт хэргэ болохыг тодорхойлсон. Энэхүү зүйл анги нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд "Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлалд, биеэ үнэлэхэд татан оруулсан бол

<sup>15</sup> Нэгдсэн үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 200 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 тоот тогтоолоор баталж, 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.





хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-50 дахин нэмэгдүүллэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 100-250 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 1-3 сарын хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”, 115 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хэргийг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-100 дахин нугалж торгох, 3-6 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”, 115 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хэргийг давтан, эсхүл хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-250 дахин нугалж торгох, эсхүл 3-5 жил хүртэл хугацаагаар торгох ял шийтгэнэ” гэж тус тус заасан.

Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэх, согтууран мансууралд татан оролцуулах нь хүүхдийн эрүүл энх амьдрах, эсэн мэнд өсөж хөгжих, хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалуулах эрхийг ноцтой зөрчсөн хүүхдийн эсрэг гэмт хэрэг мөн. Тэр тусмаа хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан, энэ хэргийг давтан үйлдсэн нь бүр ч илүү хор аюултай ёс суртахууны хувьд ноцтой хэрэг юм. Гэтэл Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь хөнгөн гэмт хэргийн, сүүлийн хоёр хэсэг нь хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарч, торгох, албадан ажил хийлгэх, баривчлах ял оноо х ял шийтгэлтэй байна. Ялангуяа, хүч хэрэглэж үйлдсэн ийм төрлийн хэрэг хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарч байгааг эргэж харах цаг болсон байна.

Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлэд заасны дагуу насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж садар самууны сурталчилгаанд татан оролцуулсан бол зөвхөн таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр байхад хүч хэрэглэж биеийг нь үнэлүүлсэн бол торгох ял оноож болохоор байна. Хүч хэрэглэж биеийг нь үнэлүүлнэ гэдэг түүнээс илүү хор аюултай үйлдэл мөн.

Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд зохион байгуулдаг нэгдсэн арга хэмжээний үеэр биеэ үнэлдэг нь тогтоогдсон. Цагдаагийн хэлтсүүдийн хүүхдийн байцаагч нарын хяналтанд байдаг насанд хүрээгүй охидын тоо 2006 онд 156, 2007 онд 93, 2008 онд 90 гэсэн дүн мэдээтэй байхад Нийслэл Улаанбаатар хотод насанд хүрээгүй биеэ үнэлдэг охидын тоо 2006 онд 59, 2007 онд 47, 2008 онд 48 байсан байна. Улсын хэмжээнд биеэ үнэлсэн гэсэн үндэслэлээр захиргааны арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй хүүхдийн тоо 2006 онд 156, 2007 онд 93, 2008 онд 90 байна.<sup>16</sup> Эдгээр тоон үзүүлэлтээс үзвэл биеэ үнэлдэг насанд хүрээгүй хүүхдүүдийн тоо сүүлийн жилүүдэд буурах

хандлага байгаа боловч зарим нь насанд хүрснээс тоо нь өөрчлөгдсөн байна.

УМБГ-аас Нийслэл, дүүргүүдэд байнгын үйл ажиллагаа явуулдаг гадаад болон Монгол эзэнтэй саун, массажны газруудад хийсэн шалгалтын мэдээллээр насанд хүрээгүй охидыг биеэ үнэлэхэд татан оролцуулсан, зохион байгуулсан гэмт хэрэгт 2008 онд нийт 12 хүүхэд хохирсон байна.<sup>17</sup>

Хэдийгээр насанд хүрээгүй охид биеэ үнэлэгч болж арга хэмжээ авагдаж байгаа боловч цаана нь насанд хүрсэн хүмүүс зохион байгуулж байгаа нь ойлгомжтой. Насанд хүрээгүй охид өөрийн хүсэл сонирхлоор биеэ үнэлдэг гэхээсээ илүүтэйгээр олон жил тэнэмэл амьдралаар амьдарсан, айлд амьдардаг, халамжийн төв дамжин амьдардаг, орон нутгийн шилжилт хөдөлгөөнөөр хөдөө орон нутгаас нийслэл хотод нүүн амьдарч буй өрхийн, ядуу өрхийн, сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, зах дээр хөдөлмөр эрхэлдэг, эцэг, эх нь салсан, хойд эцэг эхтэй гэр бүлийн охид биеэ үнэлэх болон бэлгийн бусад мөлжлөгт илүү их өртдөг байна.

Насанд хүрээгүй хүүхдүүдийг садар самуунд уруу татах, бэлгийн мөлжлөгт оруулах, бэлгийн дур хүслээ хангах зорилгоор ашиглагчдын хүрээнд бүх насны эрэгтэйчүүд, зах дээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, гудамжны тэнэмэл амьдралтай насанд хүрсэн эрэгтэйчүүд, гудамжны үе тэнгийн хөвгүүд, архинд донтогсод, бэлгийн гаж донтой хүмүүс, хөдөө орон нутгаас бизнес эрхлэгчид, Монголд гэрээгээр ажиллаж буй зарим ажилчид илүүтэйгээр хамрагддаг байна.

### 3.5. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, түүний хэрэгжилтийн талаар

Садар самуун явдалтай тэмцэх тухай (1998) хуулиар садар самуун явдал, садар самууныг сурталчлах гэсэн хоёр ойлголтыг тодорхойлсон. “Садар самуун явдал” гэж биеэ үнэлж явалдах, түүнд бусдыг уруу татах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах, түүнчлэн садар самууныг сурталчлахыг, “садар самууныг сурталчлах” гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсох, үзүүлэхийг хэлнэ гээд садар самуун явдал, түүнийг сурталчлахыг хориглох тухай заажээ. Хуулийн энэ зохицуулалт нь биеэ үнэлж бусадтай хурьцал үйлдэх, биеэ үнэлэхэд бусдыг уруу татах, биеэ үнэлэхэд нь бусдыг зуучлах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хурьцал үйлдэхийг болон бэлэг эрхтнийг илээр үзүүлэх, сонсох, уншуулахыг хуулиар хориглоосон, хариуцлага хүлээлгэхээр байна.

Харин биеэ үнэлж явалдах гэдэг нь хоёр хүний хоорондын тохиролцооны асуудал бөгөөд нэгэнт биеэ үнэлж мөнгө, эд зүйл авч явалдсан этгээдийнх нь үйлдлийг хориглосон байхад бусдын биеийг нь үнэлж мөнгө, эд зүйл өгч явалдсан

<sup>16</sup> Нийслэлийн цагдаагийн газрын судалгаанаас, 2009 он

<sup>17</sup> ЦЕГ-ын УМБГ-ын Онц хүнд зохион байгуулалтай, гэмт хэрэг мөрдөх хэлтсийн албан бичиг, 2009.02.18.№102-1058



этгээдийн үйлдлийг хориглоогүй байгаа нь шүүх хуулийн өмнө эрх тэгш байх зарчимд үл нийцэж байна. Биеэ үнэлж байгаа хүн нь санхүүгийн хувьд хөрөнгө мөнгөний хэрэгцээтэй, ажилгүй эсвэл эд хөрөнгийн хувьд хэмсэдолтой, амьдралын боломжгүй эмгэгтэйчүүд голдуу байдаг. Нэгэнт л биеэ үнэлж явалдахгүй нийгэмд хор хөнөөлтэй үйлдэл гэж үзэж хориглосон бол ийм үйлдлийг хийсэн хоёр тал хоёулаа буруутайд тооцогдох ба ая алиных нь үйлдлийг хориглох ёстой. Энэ асуудлыг нийгэмд хор хөнөөлтэй, ёс суртахуунд сөрөг нөлөөтэй гэж үзэж хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул бусдын биеийг үнэлж явалдсан этгээдийг торгох буюу баривчлах зэргээр захиргааны хариуцлага хүлээлгэх нь шударга ёсонд нийцнэ.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулиар биеэ үнэлж явалдсан этгээдийг Цагдаагийн байгууллага, оршин сууж буй засаг захиргааны байгууллага, ажиллаж, суралцаж байгаа газрын захиргаанд болон ялангуяа, нийтэд мэдээлнэ гэж заасан нь хувь хүний нэр төрд халдсан, нэр төрийг гутаан доромжлох шинжийг агуулсан байх тул хуулийн энэ заалтыг хүчингүй болгох шаардлагатай байна.

Бусдын биеийг үнэлж явалдсан этгээдэд хариуцлага хүлээлгэдэггүй байхад бусдын биеийг үнэлэхэд зуучилсан буюу биеэ үнэлэх гэж байгаа этгээдэд үйлчлүүлэгч олж өгсөн бол Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэгт зааснаар торгох, албадан ажил хийлгэх, 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэж байна.

Садар самуунтай тэмцэх тухай хуулиар биеэ үнэлж явалдсан этгээдийг олсон орлогыг нь хурааж, 14-30 хоног баривчлахаар тогтоожээ. 2002 оны өмнөх хуулиар биеэ үнэлж явалдсан бол Эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан, үүнээс харвал ийм төрлийн зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сүүлийн жилүүдэд зөвлөсөн гэж үзэж болохоор байна. Одоогийн мөрдөж буй хууль тогтоомжоор биеэ үнэлэгчид болон биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах, садар самууныг сурталчлахад хүлээлгэж буй хариуцлагын тогтолцоо дараах байдалтай байна. Садар самуунтай тэмцэх тухай хуульд "Биеэ үнэлж явалдсан бол олсон орлогыг нь хурааж, 14-30 хоног баривчлах (ажиллаж суралцаж байгаа газрын захиргаанд эсвэл баг хорооны засаг даргад, эсвэл нийтэд мэдээлнэ)", "Биеэ үнэлж явалдах нөхцлөөр хангаж зочид буудлын өрөө, гэр, орон сууц, тусгай байр, тээврийн хэрэгслээр зориуд үйлчилсэн, зуучилсан гэм буруутай иргэнийг 35000-50000 төгрөгөөр торгох, эсхүл 7-15 хоногийн хугацаагаар баривчлах, аж ахуйн нэгж байгууллагыг 100000-250000 хүртэл төгрөгөөр торгох буюу биеэ үнэлэх газрын зориулалтаар ашигласан зочид буудал, цэнгээний газрыг хаах, биеэ үнэлж явалдахад тээврийн хэрэгслээр зориуд үйлчилсэн бол тээврийн хэрэгслийг хураана" гэж заажээ.

Биеэ үнэлэгчид хэдэн удаа ч энэ хуулийн заалтыг зөрчсөн зөвхөн 14-30 хоногоор баривчлах

захиргааны арга хэмжээ авагдсаар л байхаар байна. Гэтэл Эрүүгийн хуулийн 124 дугаар зүйлийн 124.2 дахь хэсэгт "Биеэ үнэлэх газар зохион байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байр бусад зүйлээр үйлчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 201-250 дахин нугалж торгох, 100-400 цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ", 124.1 дэх хэсэгт "күч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх замаар бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-200 дахин нугалж торгох, 3-6 сар баривчлах ял шийтгэнэ" гэж тус тус заасан. Эдгээр заалтуудаас харвал биеэ үнэлэхэд зуучилсан, орон байр, тээврийн хэрэгслээр үйлчилсэн этгээдэд ямар захиргааны хариуцлага хүлээлгэх, ямар тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд "Биеэ үнэлэхэд зочид буудал, тээврийн хэрэгслээр зориуд үйлчилсэн бол тээврийн хэрэгслийг хураана, зочид буудлыг хаана" гэж байхад Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэгт тээврийн хэрэгслийг хураах, зочид буудлыг хаах тухай асуудал тавигдаагүй байна. Харин Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн эд зүйл, унаа хөсөг болон бусад зүйлсийг эд хөрөнгө хураах алаас гадуур заавал хураана гэж заасан байх боловч шүүх Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд энэ заалтыг хэрэглэдэг эсэх нь тодорхойгүй байна.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самуун явдлыг сурталчилсан бол олсон орлогыг хурааж гэм буруутай албан тушаалтныг 40000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгож, энэ зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсооно гэжээ.

Үүний зэрэгцээгээр Захиргааны хариуцлагын тухай (1992) хуулийн 41 дүгээр зүйлд садар самууныг сурталчилсан бол 10000 хүртэл төгрөгөөр торгоно гэж заасан. Эдгээр зөрчлийг гаргасан иргэд, байгууллагад хүлээлгэж буй торгуулийн арга хэмжээ бага байна. Сүүлийн жилүүдэд төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдыг садар самуунд уруу татсан нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаануудыг ихээр гаргах болсныг дурдах хэрэгтэй.

Жишээлбэл, Монгол Улсын хэмжээнд 50 гаруй "FM радио" үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 18 нь нэвтрүүлэг цацадаг байна. Үүнээс 2 радиогийн (Life-104, Инээмсэглэл 99.3) үйл ажиллагаа явуулж байгаа нэвтрүүлэгт судалгаа хийхэд Life-104 –ийн нэвтрүүлгүүд садар самууныг сурталчилсан мэдээллийг үлэмж ихээр цацаж байна. 15 өдрийн туршид садар самууныг сурталчилсан нийт 39 мэдээллийг давтамжгүйгээр цацаж байгааг

тэмдэглэжээ. үүнээс гадна тухайн нэвтрүүлгийн хөтөлгчийн садар самуун, ёс суртахуунгүй үг хэллэг байнга хэрэглэж байгаа нь өсвөр насны залуучуудын хүмүүжилд муугаар нөлөөлөх хүчин зүйл болж байна.<sup>18</sup>

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд заасны дагуу садар самууныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг болон садар самууныг сурталчилсан зүйл бэлтгэх, тараах, борлуулахыг хориглосон заалтыг нэг жилийн дотор хоёр удаа зөрчөөл эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглосон заалтыг нэг жилийн дотор дахин зөрчөөл хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоохоор байна. Нэг жилийн дотор дээрх заалтыг 2 удаа зөрчөөл эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гээд заасан учраас захиргааны хариуцлага хүлээлгэх журмаар хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох ямар ч боломжгүй байна. Энэ зөрчлийг эрүүгийн хэрэг гэж үзэн, Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлд заасны дагуу гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага тооцож болох ч харин ах ахуйн нэгж, байгууллагад өнөөдрийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулиар ямар нэгэн хариуцлага тооцох нь тодорхойгүй байна.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулиар садар самуун явдлыг сурталчилсан хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсооно гэж заасан нь учир дутагдалтай байна. Тухайлбал, бүх төрлийн радио, телевиз, суурин болон үүрэн телефоны үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг учир эдгээр байгууллагуудын тухайд тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох, сонин сэтгүүлийн хувьд бүртгэлийг нь хүчингүй болгох асуудал давхар яригдах ёстой.

Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт "Садар самуун явдлыг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, энэ зорилгоор хадгалсан бол олсон орлогыг хурааж, захиргааны журмаар торгох, нэг жилийн дотор давтан үйлдвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ, хэвлэл мэдээллийн байгууллага нэг жилийн дотор давтан үйлдвэл үйл ажиллагааг нь зогсооно" гэж заасан нь дээр дурдсантай адил байна.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт садар самууныг зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг хориглоно гэсэн 5.2 дахь хэсэгт нь садар самууныг сурталчилсан зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, хадгалахыг хориглоно гэж заасан. Харин садар самууны зүйлийг бусдад үзүүлэхийг хориглоогүй орхигдуулсан байна. Иймээс садар самууныг сурталчилсан зүйлийг бусдаас авч бусдад үзүүлбэл энэ хуулиар хариуцлага хүлээхээргүй байна.

### 3.6. Монгол Улсын иргэд гадаадад зорчих цагаачлах тухай хуулийн зохицуулалт болон хэрэгжилт

"Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-ын 11 дугаар зүйлд заасны дагуу хүмүүсийн чөлөөтэй зорчих эрхийг нь зөрчихгүйгээр оролцогч улсууд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх шаардлагад нийцэхүйц байдлаар хилийн хяналтыг боломжийн хэрээр бэхжүүлэх ёстой байна. Энэхүү заалт нь 2 хэсгээс бүрдэж, үүнд нэгдүгээрт, хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгсэлд тавих хяналт, хоёрдугаарт, хил нэвтрэх баримт бичгийн хяналт, баталгаа гэсэн хоёр хяналтын асуудлыг хамруулсан байдаг.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай (1993) хуулийн 8 дугаар зүйлд "Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах бол түүнд үндэсний гадаад паспорт олгоно". "Насанд хурээгүй хүн гадаадад зорчих, цагаачлах бол дор дурдсан баримт бичгийн аль нэгийг олгоно" гэж тус тус заажээ, үүнд:

- үндэсний гадаад паспорт;
- Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн үндэсний гадаад паспортонд зургийг нь нааж баталгаажуулах;
- Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн хамт түр хугацаагаар гадаадад зорчих хүүхдэд үндэсний гадаад паспортонд нь хавсаргагдах үнэмлэх олгох;
- Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдэд үндэсний энгийн гадаад паспорт эзрэг болно.

Гадаадад хувийн хэргээр зорчих иргэдэд олгож буй үндэсний гадаад паспортын нууцлалын хувьд орчин үеийн техник технологи ашиглан хийсэн тул хуурамчаар үйлдэх боломж муутай нууцлалын шаардлагыг хангасан гэсэн тайлбарыг холбогдох байгууллагууд өгч байна. Харин гадаад паспортыг үйлдвэрлэж байгаа болон олгож байгаа ажилтнуудын үйл ажиллагаанаас шалтгаалан өөр хүний нэрээр гадаадын иргэнд паспорт гаргуулах зөрчил нэг бус удаа гарч ИБМУТ-ийн зарим ажилтнууд эрүүгийн хариуцлагад татагдаж байсан. Энэ нь ямар ч хүнд ямар ч нэрээр гадаад паспорт гаргах боломж байгааг харуулж байна.

Иймээс гадаад паспорт олгоход тавих захиргааны хяналтыг улам боловсронгуй болгох шаардлага, хэрэгцээ байгааг харуулж байна. Үндэсний гадаад паспорт авах баримт бичгийг хянан үзэж зөрчилгүй байна гэж үзвэл ИБМУТ зохих баримт бичгийг бүрдүүлж, паспортыг хэвлүүлэхээр хувийн хэвлэлийн компанид материалыг нь шилжүүлэн паспортыг хэвлүүлж, паспорт хэвлэгдсэний дараа ИБМУТ хянан үзэж тамга дарж, эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулдаг. Харин паспорт хэвлэж буй байгууллагын ажилтнууд

<sup>18</sup> "Хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилж буй өнөөгийн байдал, тандалтын судалгааны хураангуй" 10 дугаар хууцаас.

МОНОС болон МПУС-ийн НШУС-ийн судлаачдын багийн тайлангаас, 2007 он





хуурамч паспорт үйлдвэрлэж гаргахаас сэргийлэх, тийм боломж олгохгүй байх үүднээс төрийн зүгээс зохих хяналт тавих шаардлагатай байна. Ер нь иргэндээ олгож буй ийм чухал баримт бичгийг хувийн байгууллага үйлдвэрлэж байгаа нь зөв эсэхэд дүгнэлт хийх хэрэгтэй. Иргэний бичиг баримтыг эвлэлх байгууллага нь (үйлдвэр) төрийн мэдэлд иргэний бүртгэл мэдээллийн асуудал хариуцсан байгууллагын харьяанд тусгай хамгаалалтын дор байх ёстой гэж үзэж байна.

Гадаадад зорчиж буй насанд хүрээгүй хүмүүст тавих хяналтыг ялангуяа, тэдэнд олгож буй гадаадад зорчих баримт бичигт тавих хяналтыг сайжруулах нь хүүхэд худалдаалагдахаас сэргийлэх нэг нөхцөл учир хүүхдэд олгож буй баримт бичигт дүнлэлт хийх хэрэгтэй байна. Тэдэнд дээр дурдсан 3 төрлийн баримт бичиг олгодог бөгөөд эдгээрээс эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийнх нь паспортонд зургийг нь нааж баталгаажуулах, эсвэл паспортонд нь хавсралт үнэмлэх олгох гэсэн баримт бичгүүд нь хуурамчаар үйлдэгдэхгүй гэх нууцлалын баталгаатай эсэх нь эргэлзээтэй байна.

Гадаадад зорчиж буй хүүхдүүд эцэг, эхтэйгээ зорчихын зоргоор зорчих үед бусад хүмүүсийн (асран хамгаалагч) паспортонд нь хавсралт авч зорчих тохиолдол бага бус байдаг.

Монгол Улсад олгож буй иргэний төрсний гэрчилгээ зураггүй байдаг учраас төрсний гэрчилгээнд бичигдсэн хүүхэд гадаадад зорчих гэж буй хүүхэд мөн эсэхийг хянах боломжгүй байдаг. Энэ нь бусдын төрсний гэрчилгээг ашиглан гадаадад зорчих хавсралт үнэмлэх авах боломжтой байна. Иймд энэ дутагдлыг арилгах, хүүхдэд төрсөн цагаас нь иргэний үнэмлэх олгох, хүүхэд хууль бусаар гадагш гарахаас сэргийлэх үүднээс гадагшаа түр хугацаагаар зорчих хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчийн паспортонд нь зургийг нааж баталгаажуулан, тухайн хүнийг буцаж ирэхэд нь хяналт тавьдаг, удаан хугацаагаар зорчих тохиолдолд хүүхдэд үндэсний гадаад паспорт олгодог журам тогтоож, хавсралт үнэмлэх олгохыг хориглож, хуулийн энэ заалтыг хүчингүй болгох шаардлагатай.

ХХЕГ, Чингис хаан нисэх онгоцны буудал, Сэлэнгэ, Алтанбулаг-Сүхбаатар, Замын-үүдийн авто зам болон төмөр зам зэрэг 5 боомт ИБМУТ-тэй холбогдсон байна. Иймээс эдгээр 5 боомтоор нэвтрэж байгаа хүний тухайд л иргэний бүртгэлийн асуудлаар лавлагаа хийх, хяналт тавих боломжтой байдаг байна.<sup>19</sup> Иймээс иргэний бүртгэл мэдээллийн сүлжээнд бүх шалган нэвтрүүлэх боомтыг хамруулах, насанд хүрээгүй хүүхдийг нэвтрүүлэх, шаардлага хангасан боомтуудыг зориуд тогтоож өгөх хэрэгтэй юм.

Гадаадад зорчсон хүүхэд буцаж ирсэн эсэхийг хянах, хамт явсан эцэг, эх, асран хамгаалагчтай нь эргэж тооцох, тухайн хүүхэд эргэж орж ирсэн эсэхийг хянах нарийн зохицуулалт байхгүй, түүнийг хариуцах байгууллага байхгүй байна. Харин ХХЕГ-аас тухайн жилд хэдэн хүүхэд гадагшаа гарч, хэд нь буцаж ирвэ гэдэг тоон үзүүлэлтийг гаргадаг байна. 2006 онд 26118 хүүхэд гадагш зорчсоноос 22523 хүүхэд буцаж ирсэн, 2007 онд 40392 хүүхдээс 39112 хүүхэд буцаж ирсэн байна.<sup>20</sup> 2008 онд 41979 хүүхэд гадагшаа зорчсоноос 44674 хүүхэд буцаж ирсэн, Монгол Улсын хилээр сүүлийн 3 жилийн байдлаар нийт 108307 хүүхэд гарч, 106309 хүүхэд буцаж ирсэн тоон мэдээг ХХЕГ гаргаж өгсөн.<sup>21</sup> Харин эдгээр хүүхдүүд яагаад буцаж ирээгүй болохыг хянадаг, хариуцлага тооцдог тогтолцоог бий болгох нь чухал байна.

Насанд хүрээгүй хүнийг гадаадад авч гарсан хүмүүстэй тухайн хүүхэд эргэж орж ирсэн эсэхийг тооцдог болох, ийм үүргийг тэдгээр хүмүүст хуулиар хүлээлгэх, гадаад паспорт олгох, хугацааг нь сунгах, гадаадад зорчиход нь өмнө авч гарсан хүүхдийн талаарх бодит мэдээллийг шаардах, хянах эрхийг ХХЕГ, ИБМУТ-ийн бүрэн эрхэд хамааруулж, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай, Иргэний бүртгэлийн (1999) тухай болон холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж үзэж байна.

### 3.7. Хараа хяналтгүй хүүхдүүдийн талаархи өнөөгийн нөхцөл байдал

Манай улсын нийслэл Улаанбаатар хот болон бусад төв суурин газарт хараа хяналтгүй тэнэмэл амьдралтай хүүхдүүд багагүй байдаг. Эдгээр хүүхдүүд нь хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлийг дагуулж байна.

НЦГ-ын харьяа Хүүхдийн халамж үйлчилгээний төвд 2006 онд 1128, 2007 онд 1158, 2008 онд 1041 хараа хяналтгүй хүүхэд давхардсан тоогоор албадан саатуулагдсанаас эрэгтэй хүүхэд сүүлийн 2 жилийн байдлаар 1862, эмэгтэй хүүхэд 237 саатуулагдсан. Жил жилийн эдгээр тоон үзүүлэлтээс харахад зуу орчмоор хүүхдийн тоо бууралттай байгаа мэт боловч 2008 онд гэхэд л 155 хүүхэд 504 дэж удаагаа уг байранд ирсэн бөгөөд гэр орноосоо төөрсөн гэх хүүхэд 65, анх удаагаа уг төвд хүргэгдэн ирж байгаа хүүхэд 472 байна. Өнөөдрийн байдлаар 9-17 насны 121 хүүхэд тогтмол тэнэмэл амьдралаар траншейнд амьдарч байгаа бөгөөд үүнээс 1-3 жил тэнэсэн 46, 3-9 жил тэнэсэн 53 хүүхэд, үлдсэн нь үе үе гэр орноосоо дайжин амьдарч байна.<sup>22</sup> Эдгээр хараа хяналтгүй хүүхдүүдийг бүртгэлд хамруулах, худалдаалагдах бэлгийн мөлжлөгт ашиглагдахаас сэргийлэх талаар хууль, эрх зүйн харилцааг зөв зохицуулах,

<sup>19</sup> Олон улсын 5 боомтоос бусад жилийн боомтууд мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй одоогийн нөхцөлд тоон мэдээллийн хувьд бодитой гэх үзэхэд үндэслэл мутай бөгөөд хилээр нэвтрэгдэхийн хөдөлгөөн нь хонг, цаг тутам өөрчлөгдөж байдаг тул албан ёсны мэдээлэл болгохдоо хүндэтгэж байдаг. ХХЕГ-ын 2009 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн № 1-61497 дугаар албан ёсоор

<sup>20</sup> Хил хамгаалах Ерөнхий Газрын статистик мэдээнээс

<sup>21</sup> Хил хамгаалах Ерөнхий Газрын 2009 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн № 1-61497 дугаар албан ёсоор

<sup>22</sup> НЦГ-ын Халамж үйлчилгээний төвийн тоон мэдээнээс, 2008 он.





байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй байна.

Хараа хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, ашгийг хамгаалах талаар дараахь хуулиудад тусгагдсан байна.

**3.7.1. Цагдаагийн байгууллагын тухай (1993) хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Цагдаагийн байгууллага нь хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх ажил зохиож, эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж, шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх захиргааны үүрэг гүйцэтгэх ёстой.**

**3.7.2. Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай (1997) хуульд "Хараа, хяналтгүйгээс амь нас, эрүүл мэнд нь хохирч болзошгүй 16 хүртэл насны хаг, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тодорхойгүй хүүхдийг цагдаагийн эрх бүхий ажилтан 14 хүртэл хоног түр саатуулж болно", "Цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан заасан хугацааны дотор хараа хяналтгүй хүүхдийг хүүхдийн буюу харгалзан дэмжих байгууллагад шилжүүлж болно", "Түр саатуулах байрны дэглэм журмыг Засгийн газар батална" гэж тус тус заасан байна.**

Эдгээр хуулийн заалтаас үзвэл хараа хяналтгүй хүүхдийг судлан бүртгэх, тэднийг хэрэг зөрчилд холбогдохос урьдчилан сэргийлэх гол үүргийг Цагдаагийн байгууллага гүйцэтгэхээр байна. Хуулийн энэ заалтыг үндэслэн НЦГ-ын харьяанд хүүхдийн Халамж үйлчилгээний төв байгуулсан байна.

Засгийн Газрын 1996 оны 91 дүгээр тогтоолоор хараа хяналтгүй хүүхдийг албадан саатуулах байрны дэглэмийн тухай журмыг баталж, уг журмаар түр саатуулах байрны нөхцөл (байрны болон хоолонд тавигдах шаардлага), түр саатуулах байрны дэглэм, түр саатуулах байранд хүүхдийг хүлээн авах, хүүхдийг хүлээлгэн өгөх зэргийг зохицуулсан. Тус халамжийн төвд хараа хяналтгүйгээс амь нас, эрүүл мэнд нь хохирч болзошгүй 6-аас дээш насны хүүхдийг хүлээн авдаг ба сургуулийн өмнөх буюу 6-аас доош насны хүүхдийг асрамж, халамжийн төвд шууд хүлээлгэн өгөх, тэдний эцэг, эх, асран хамгаалагчийг Цагдаагийн байгууллага тогтоон ажилладаг байна.

Цагдаагийн байгууллага халамжийн төвд ирсэн хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг тогтоож, тухайн хүүхдийг тэдэнд хүлээлгэн өгдөг ба эцэг, эх, асран хамгаалагч нь тодорхойгүй хүүхдийг холбогдох байгууллагын шийдвэрээр асрамжийн газарт шилжүүлдэг байна. Тус төв зөвхөн 5 асрамжийн байгууллагад хараа хяналтгүй хүүхдийг шилжүүлдэг. Гэсэн хэдий ч хөрөнгө санхүүгийн хүндрэлтэй байдал нь уг байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж байна гэдгийг анхаарах хэрэгтэй байна. Жишээлбэл, дотуур байрандаа 56-60 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай бөгөөд сард зөвхөн хоолонд 1.300.000 төгрөг төсөвлөн хуваарилдаг нь ямар ч хүрэлцээгүй, эмнэлгийн үйлчилгээнд зориулж сард 25.000 төгрөг жилдээ

300.000 төгрөгийн төсөв баталдаг нь гаднаас орж ирж байгаа өвчтэй хүүхдүүдийн эм тарианд ямар ч тус дэм болж чаддаггүй байна. Бэлгийн замын халдварт өвчтэй нэг хүүхдийн нэг удаагийн эмчилгээнд 18000-25000 төгрөгийн тариа хийх зайлшгүй шаардлага гардаг байна.

Иймд баталсан төсөв нь хүүхдэдээ хүрдэггүй, хүүхдийн хувцасны талаар ямар нэгэн төсөв байдаггүйгээс уг төвийн дарга нар нь гадны байгууллага, хүмүүсээс "бадар барьж" хүүхдүүдээ өвлийн хүйтэнд дулаан, зуны халуунд нимгэн хувцастай байлгадаг байна. Эдгээр хараа хяналтгүй хүүхдүүдийг Цагдаагийн байгууллага хууль, журамд заасан хугацааныхаа дотор байрлуулсны эцэст эцэг, эхэд нь, мөн гэр оронгүй зарим хүүхдүүдийг асрамжийн төвүүдэд хүлээлгэн өгдөг. Тэдгээр байгууллагууд өөр хоорондоо нэгдсэн мэдээллийн сүлжээгүйгээс уг төвүүдэд хэдэн хүүхэд ирсэн, тэд хаашаа явсан, шилжсэн талаар хяналт тавих тогтолцоогүй байна. Иймээс хараа хяналтгүй хүүхдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих нэгдсэн тогтолцоог бий болгох хэрэгтэй байна.

НЦГ-ын харьяанд ажиллаж буй Хүүхдийн халамжийн төвд нийслэл хотод хараа хяналтгүй байгаа хүүхдүүдийг бүртгэх, хөдөлгөөнд нь хяналт тавих эрх, үүргийг хариуцуулж, асрамж халамжийн төвөөр дамжиж байгаа хүүхдүүдийг заавал энэ төвийн бүртгэлд хамруулснаар тус төв нь төрийн захиргааны төв байгууллага, Нийслэл, дүүргийн засаг захиргааны байгууллагуудыг мэдээллээр хангаж, тэдгээр байгууллагууд хараа хяналтгүй хүүхдийн нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах ажлыг хариуцдаг байхаар зохицуулах шаардлагатай байна.

**3.7.3 Хүүхдийн эрхийг хамгаалах тухай (1996) хуулийн 11, 15 дугаар зүйлүүдэд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхэд дараахь асуудлуудыг хамруулсан байна.**

- бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ.

- хүнд нөхцөлд байгаа хүүхдэд боловсрол, мэргэжил эзэмшихэд нь туслалцаа үзүүлэх, эрүүл мэндийг нь нөхөн сэргээх, сувилах, хиймэл эрхтнийг үнэ төлбөргүй олгох, ийм хүүхдэд үрчлсэн гэр бүлд төрөөс тэтгэмж олгох, хүүхдийг асран хамгаалах байгууллагад шилжүүлж, халамжийн үйлчилгээнд хамруулах үйлчилгээ үзүүлэх;

- онцгой болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг судлан тогтоож, тэдний эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах;

- Төөрсөн, орон гэрээсээ дайжсан, бусад шалтгаанаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сургууль, цагдаагийн болон аж ахуйн нэгж, иргэнийг оролцуулах;

- онцгой болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн нийгмийн хамгааллын холбогдолтой мэдээллийг үндэсний статистикийн газраас баталсан аргачлалын дагуу гаргаж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгөх;

Мөн хуулийн 15 дугаар зүйлд "Онцгой болон хүнд нөхцөлд байгаа хүүхдэд дараахь халамж хөнгөлөлт, тусламж үзүүлнэ", үүнд:

- боловсрол, мэргэжил эзэмшихэд нь тусалцаа үзүүлэх;

- эрүүл мэндийг нь нөхөн сэргээх, сувилах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хиймэл эрхтэн болон бусад зүйлийг үнэ төлбөргүй олгох, хүүхдийг асран хамгаалах байгууллагад шилжүүлж, халамжийн үйлчилгээнд хамруулах, хүүхдийг сайн дурын үндсэн дээр асран хүмүүжүүлэх гэр бүлд дэмжлэг үзүүлэх;

- хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах, халамжлах болон хөдөлмөр, хүмүүжлийн байгууллагад сурган хүмүүжүүлэх зардлыг төрөөс санхүүжүүлнэ гэж заажээ.

Хууль тогтоомжийн дээрх заалтаас үзвэл хүнд нөхцөлд байгаа хараа хяналтгүй хүүхэд гэж хэнийг хэлэх, түүнд ямар төрлийн нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх тухай асуудал хууль тогтоомжид боломжийн хэмжээнд тусгагдсан байна. Гэсэн хэдий ч онцгой хүнд болон хүнд нөхцөлд байгаа хүүхдийг судлан бүртгэх, тэдэнд халамж үйлчилгээ үзүүлэх асуудлыг хоёр шатны Засаг даргын эрх мэдэл дөвхр хариуцуулсан нь хэрэгжилтэнд муугаар нөлөөлж болзошгүй байна. Аймаг, Нийслэлийн Засаг дарга болон сум, дүүргийн Засаг дарга нар чухам аль асуудлыг нь хариуцахыг тодорхой ялган зааглаж, зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хуулийн 11 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт онцгой болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн нийгмийн хамгааллын холбогдолтой мэдээллийг үндэсний статистикийн Хорооноос баталсан аргачлалын дагуу гаргаж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгөхийг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргад үүрэг болгосон боловч яг ийм чиглэлийн мэдээлэл цуглуулах аргачлал нэвтрээгүй байна. ҮСХ-ны даргын 2003 оны 228 дугаар тушаалаар "өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн тайлан" гаргах үзүүлэлт журмыг баталсан байна. Энэ тайланг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар гаргаж, 12 дугаар сарын 5-ны дотор аймаг, нийслэлийн статистикийн хэлтэст, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс 12 дугаар сарын 21-ний дотор ҮСХ-т хүргүүлэхээр тогтоожээ.

Энэ тайлангийн маягтанд зөвхөн бүтэн болон хагас өнчин хүүхдийн тоог хүйсээр нь ангилж, онц хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тоог байгалийн гамшигт өртсөн хүүхдийн тоо, зам тээврийн болон ахуйн осолд өртсөн хүүхдийн тоо, халдварт өвчин тахалд нэрвэгдсэн хүүхдийн тоо, амиа хорлох оролдлого хийсэн хүүхдийн тоо, 0-15 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо гэсэн

ангиллаар авч байхаар орсон байна. Энэ нь хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэсэн тодорхойлолтонд заасан хүүхдүүдийг бүрэн хамарч чадахгүй байна. Иймээс хуульд заасны дагуу онц хүнд болон хүнд нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээлэл, тэдгээрт үзүүлж буй халамж үйлчилгээний байдлын талаарх статистик мэдээлэл цуглуулах тогтолцоо, аргачлалыг нэвтрүүлж, хуулийн заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай юм. Шат шатандаа эдгээр хуулиудын заалтыг биелүүлж чадвал хараа хяналтгүй хүүхдийн асуудал төрийн байгууллагуудын хяналтад бүрэн хэмжээгээр орж хүүхдийг дагасан олон эрсдэлээс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.

### 3.8. Гадаадад ажиллах хүч гаргах болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн зохицуулалтын талаар

Монгол Улсын иргэдийн гадаадад гарч ажиллаж амьдрал ахуйгаа дээшлүүлэх хүсэл сонирхол нь ашиг хонжоо хайсан хүмүүсийн олз болж, худалдаалагдах нэг нөхцөл нь болсоор байна. Манай иргэд өндөр цалинтай ажилд оруулж өгнө гэсэн хуурамч зард итгэж хохирсон тохиолдол багагүй байна. Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд нь зуучлах тухай асуудлыг Гадаадад ажиллах хүч гаргах болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (2001) хуулиар зохицуулж байна. Энэ хуулиар гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг иргэд, байгууллагад хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож байхаар тогтоосон байна. Байгууллага, иргэн нь гадаадад ажиллах хүч гаргах талаар гадаадын байгууллагатай гэрээ байгуулсны дараа тусгай зөвшөөрөл хүсэх бөгөөд ингэхдээ ямар баримт бичиг бүрдүүлэхийг уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заажээ. Энэ хэсэгт 6 зүйлийн баримт бичиг шаардсан баях бөгөөд эдгээр нь зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай зүйлүүд байна. Ийм төрлийн тусгай зөвшөөрөл хүссэн иргэнд ямар болзол шаардлага тавигдахыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Практикаас харахад гадаадад ажилд зуучилна гэсэн хуурамч зард итгэсэн иргэд хүний наймааны золиос болох, эрх нь зөрчигдөх нь илүүтэй байна. Иймээс иргэдэд энэхүү тусгай зөвшөөрлийг олгох нь зөв эсэхийг шийдвэрлэх шаардлагатай байна. Зөвшөөрөл олгох ёстой гэж үзвэл ямар болзол, шаардлага тавигдахыг хуулиар нарийвчлан зохицуулах нь зүйтэй юм. Хувь хүн болон хуулийн этгээд нь хоорондоо эрс ялгаатай субъект учир нэг болзол шалгуур тавигдах нь зохимжгүй байна.

Нэгэнт иргэн, байгууллагад энэхүү тусгай зөвшөөрлийг олгохоор хуульчлагдсан тул энэ чиглэлийн аливаа зар мэдээлэлд иргэд мэхлэгдсээр байна. Зар сурталчилгааны тухай хуульд тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулахыг хориглосон хэдий ч ажилд зуучлах зар

сурталчилгаа явсаар байна. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (2001) хуулиар энэ төрлийн зар сурталчилгааны талаар нарийвчилсан зохицуулалт хийх нь зүйтэй. Тухайлбал, Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэхэд зуучлах тухай зарыг зөвхөн төрийн захиргааны төв байгууллагын хүсэлтээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад аргаар нийтэд зарлан мэдэгдэнэ гэсэн зохицуулалтыг хийснээр гадаадад ажилд зуучлах тухай хууль бус зар тарах боломжгүй болно гэж үзэж байна.

Өнөөдрийн байдлаар БНСУ, Япон, Чех улсуудад хуулийн дагуу ажиллах хүч гаргах эрх бүхий зөвшөөрөлт<sup>23</sup> 17 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн байдлаар эдгээр байгууллагуудаар зуучлуулан Монгол Улсын 25 000 иргэн<sup>24</sup> хөдөлмөрийн гэрээ болон үйлдвэрлэлийн дадлагажигчаар БНСУ, Чех, Унгар, Япон улсуудад ажиллаж амьдарч байна гэсэн албан ёсны тоон мэдээ байна. Мөн гадаадын улс орнуудаас Монгол Улсад 2007 онд 180504 иргэн, 2008 онд 84 орны 37507 иргэнд агентлаг зөвшөөрөл олгосон байна. Үүнээс БНХАУ-ын иргэн 32500, ОХУ-ын 1178 иргэн байгаа бөгөөд бусад нь Вьетнам зэрэг улсын иргэд барилга, замын, уул уурхайн салбарт ажиллаж байна гэсэн тоо мэдээ байна.

### 3.9. Зар сурталчилгааны тухай хууль болон түүний хэрэгжилтийн талаар

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч нь гадаадад өндөр чөлөөтэй ажилд оруулна, виз гаргаж өгнө, суралцуулна, гадаадын хүнтэй гэр бүл болоход нь зуучилна гэсэн зар гаргаж, худалдаалах, бэлгийн мөлжлөгт ашиглах хүнээ сонгож авдаг нь удаа дараагийн судалгаагаар тогтоогдсон байна. Иймээс зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль бус зар сурталчилгааг хязгаарлах, хууль бус зар сурталчилгаа хийсэн байгууллага, иргэдтэй хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох нь хүн худалдаалах гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Зар сурталчилгааны тухай хуулийн (2002) зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга бус өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төвөгшөөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино. Хуулийн 3 дугаар зүйлд "зар сурталчилгаа" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа (цаашид бүтээгдэхүүн гэх)-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг хэлнэ гэж тодорхойлжээ. Зар

сурталчилгааны тодорхойлолт нь зөвхөн бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээгээ таниулах, эрэлт, хэрэгцээг өсгөх, ашиг орлогоо нэмэгдүүлэх арилжааны шинжтэй гэдэг утгаар илэрхийлэгджээ. Жишээлбэл, Оросын Холбооны Улсын хуулиар сурталчилгаа (реклам)-г 3 хувааж авч үзжээ.

- арилжааны зар сурталчилгаа (бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний сурталчилгаа);
- төрийн ашиг сонирхлыг хангах, сайн үйлс бүтээх, нийтийн ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн нийгмийн зар сурталчилгаа;
- улс төрийн зар сурталчилгаа (сонгуулийн өмнөх);

Харин арилжааны болон нийгмийн шинжтэй сурталчилгааг Зар сурталчилгааны тухай хуулиар, улс төрийн сурталчилгааг Улс төрийн намын тухай болон төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулдаг байна. Харин худалдаа арилжааны үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоогүй хувь хүн, хуулийн этгээдийн хувийн зарыг зар сурталчилгаа гэж үздэггүй байна.

Манай улсын Зар сурталчилгааны тухай хуулиар зар сурталчилгаанд дараахь үндсэн шаардлагууд тавигдсан байна.

- үнэн бодитой, хэрэглэгчийг төвөгшүүлээгүй байх;
  - бусдын нэр төр, алдар хүндэд харшлаагүй байх;
  - хуулиар хориглосон бараа, ажил үйлчилгээг сурталчлахгүй байх;
  - Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэхээргүй байх;
  - Тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд тухайн ажил, үйлчилгээний талаар зар сурталчилгаа явуулахгүй байх;
  - хүнлэг ёс, ёс суртахуун, Монгол хүний эрхэмлэн дээдэлдэг зан заншлын ёс горимыг зөрчөөгүй байх;
  - айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэхээргүй байх хуулиар хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчлахгүй байх;
  - үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил, боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашиглаагүй байх;
  - аливаа улсын төрийн бэлэг тэмдэг, түүхэн алдарт хүн, мөнгөн тэмдэгт, дүрэмт хувцас, билэгдлийг гутаан доромжлоогүй, гаж хэлбэрээр ашиглаагүй байх;
  - бусдын бүтээгдэхүүнийг гутаан доромжлоогүй байх.
- Эдгээр зүйлүүдийг зар сурталчилгаанд тавигдах шаардлага, хориглох зар сурталчилгаа, хууль бус зар сурталчилгаа гэсэн зүйл хэсгүүдэд

<sup>23</sup> 2009 оны эхний 3 сарын байдлаар, НОХЯ-ны судалгаанаас

<sup>24</sup> 2001 оны "Гадаадад ажиллах хүч гаргах болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай" хууль үйлчилгээ эхэлснээс хойшхи тоон мэдээ



тусгасан байна. Зар сурталчилгаанд тавигдаж буй ерөнхий шаардлага, хориглож буй хориглолтууд нь эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий шаардлагад ерөнхийдөө нийцэж байна. Энэ төрлийн гэмт хэргэ гарахад гадаадад ажил эрхлэхэд зуучилна, өндөр цалинтай ажилд оруулна, виз гаргаж өгнө, гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучилна, сургууль, дамжаанд суралцуулна, жуулчуулна гэсэн зар сурталчилгаанууд охид эмэгтэйчүүдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгт ашиглахад нөлөөлдөг. Иймэрхүү зараар ажилд орон эсвэл гадагш зуучлуулан явж тодорхой хэмжээний хохирол амсч байгаа нь нууц биш юм. Өөрийн хүсэл сонирхлоор уг ажилд орон ажил хийсэн, хэн ч түүнийг албадаагүй, миний нөхцөлийг өөрийн дүрээр зөвшөөрсөн гэсэн ажил олгогчдын байр суурь нь тэдний эрх ашгийг хамгаалахад саад болдог.

Дээрх зар сурталчилгаанаас гадаадад хөдөлмөр эрхлэхэд нь зуучлах, аялал жуулчлал эрхлэхээс бусад нь тусгай зөвшөөрөл шаарддаггүй байна. Гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах, хувь хүн гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах зэргийг хуулиар хориглож, хөдөлмөр эрхлэхэд зуучлах эрхийг хуулийн этгээдэд өгснөөр эдгээр хууль бус зарууд нийтэд түгэх боломжгүй болно.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаатай холбоотой бичмэл зар сурталчилгаанд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын нэр, зөвшөөрлийн дугаарыг тусгасан байна" гэж заасныг илүү нарийвчлан, ийм төрлийн зар сурталчилгааг зөвхөн тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын зөвшөөрлийг үндэслэн нийтэд түгээдэг болгохоор өөрчлөх нь зүйтэй. Зөвхөн тусгай зөвшөөрөл олгодог байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаарыг дурдах нь хангалттай биш байна.

Зарим тодорхой хууль тогтоомжоор зарим төрлийн мэдээлэл, сурталчилгааг хориглосон байдаг. Тухайлбал, Садар самуунтай тэмцэх тухай хуулиар садар самууныг сурталчлах, Архидан согтуурахтай тэмцэх тухай (2000) хуулиар архи, согтууруулах ундааг сурталчлахыг хориглосон.

Өнөөгийн дагаж мөрдөж буй Зар сурталчилгааны тухай хуулийн системчлэл хангалтгүй байгаад дүгнэлт хийж, ямар зар сурталчилгааг хориглох вэ, ямар нь ерөнхий шаардлага тавигдах ёстой вэ гэдгийг сайтар ангилж зохицуулах хэрэгтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, арилжааны зар сурталчилгаа, нийгмийн шинжтэй зар сурталчилгааны ангилалт, тус тусад нь тавигдах шаардлага зэргийг ялгарвартай тогтоох хэрэгтэй байна.

Зар сурталчилгааны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих эрх бүхий байгууллагыг зөв тогтоох хэрэгтэй байна. Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг

Оюуны өмчийн улсын хяналтын алба хэрэгжүүлэхээр тогтоожээ.

Зар сурталчилгаа бол нийгмийн олон харилцаатай холбоотой арилжааны шинжтэй зар сурталчилгаанаас гадна банк, санхүү, хөрөнгө оруулалт, даатгал, үнэт цаас, байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн шинжтэй зар сурталчилгаа гэсэн маш олон салбарын мэдээлэл хамрагдаж байна. Энэ олон салбарын харилцаанд Оюуны өмчийн улсын хяналтын алба хяналт тавих боломж ч байхгүй, тэдний эрхлэх ажлын хүрээнд ч багтахгүй.

Оюуны өмчийн улсын хяналтын албаны хэлтсийн даргын мэдээлснээр "Манай байгууллага зард хяналт тавьдаггүй, зар нь хүний бусдад дамжуулж буй мэдээлэл учир Зар сурталчилгааны тухай хуулийн 2.2-т зааснаар улс төр, шашин, сүм хийд, түүнчлэн худалдаа, арилжаа, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл манайд хамаарахгүй, хяналт тавих ёсгүй. Манай байгууллага зөвхөн реклам, сурталчилгааны зохиогчдын эрх, патентийн эрхийн асуудлаар ажилладаг. Хуурамч зар сурталчилгааг хууль шүүхийн байгууллага нь хянадаг байлгүй, бидэнд хамаагүй" гэсэн байна.

Зар сурталчилгааны зохицуулж байгаа харилцаа, чиглэлийг харгалзан төрийн хяналтын байгууллагууд чиглэл чиглэсээрээ хяналт тавьдаг болгож өөрчлөх нь зүйтэй байна. Тухайлбал, зах зээлийн харилцаанд шударга бусаар өрсөлдсөн, бусдын бараа, ажил үйлчилгээг сөргөөр сурталчилсан тохиолдолд Шударга бус өрсөлдсөн, хэрэглэгчийн төлөө газар, эрүүл мэндийн шинжтэй зар сурталчилгаанд эрүүл мэндийн, байгаль орчны шинжтэй зар сурталчилгаанд байгаль орчны хяналтын алба, банк, санхүүгийн холбогдолтой зар сурталчилгаанд СЗХ, нийгмийн шинжтэй зар сурталчилгаанд ХЗДХЯ, зохиогчийн болон патентийн эрхтэй холбоотой асуудлаар ОӨГ зэргээр чиглэл чиглэсээрээ хяналт тавих өөрчлөлтүүдийг хуульд нэмж оруулах нь зүйтэй байна. Зар сурталчилгаа нь маш олон чиглээр, олон янзын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд олон нийтэд түгээгддэг тул нэг байгууллага энэ хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх бололцоогүй юм.

"Монголын Эмэгтэйчүүдийн сан" ТББ, МУИС-ийн Нийгмийн Шинжлэх Ухааны Сургуулийн хамтарсан судлаач нарын багаас 2007 онд хэвлэл мэдээллийн хэрэгслээр "Садар самууныг сурталчилж буй өнөөгийн байдал" сэдвээр тандалтын судалгаа хийсэн байна. Судалгааны хураангуй тайлангаас үзэхэд Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацаж байгаа 15 телевизийн 7 нь ТВ-ийн "ЧАТ" сүвгийг 2007 оноос эхлэн ажиллуулж байгаа бөгөөд үүний нэг суваг нь нийт 226 цаг буюу өөрийн сувагар цацаж байгаа бүх мэдээллийн 88.9 хувийг бусдыг садар самуунд уруу татсан мэдээллийг түгээсэн байна. Судалгааны баг ажилгалтын хугацаанд сонгон авсан ТВ-ийн "ЧАТ" сувагар хамгийн их садар самууныг сурталчилсан

<sup>21</sup> Зар сурталчилгааны эрх зүйн орчинд хийсэн хуулийн анализ, Хүний эрх, хөгжил төв.



нийт 96 илгээгдсэн мессэжийг хүйсийн хувьд ангилахад үүнээс эрэгтэйчүүд давамгайлсан буюу 77.1 хувийг, эмэгтэйчүүд 19.8 хувийг эзэлсэн байна. Мессж илгээж байгаа оролцогчдыг насны хувьд ангилахад ихэнх нь 14-24 насныхан байсан<sup>26</sup> гэсэн мэдээг гаргажээ.

### 3.10. Донор болон эд эрхтэн шилжүүлэн суулгаж буй талаар

Хүн худалдаалах гэмт хэргийн нэг гол зорилго нь хүний цус, эд, эрхтнийг авч худалдааж ашиг олох явдал байдаг. Манай улсад анагаах ухааны орчин үеийн хөгжил, дэвшил нэвтэрч, Монголын эмч нар хүний эд эрхтнийг шилжүүлэн суулгах мэт ажилбарыг дотооддоо хийх явдал өргөжиж байна. Үүнтэй холбоотойгоор хүн хулгайлах замаар бусдын эд эрхтнийг худалдаалах гэмт хэрэг гарахыг үгүйсгэх аргагүй. Манай улс ч энэ төрлийн зохицуулалтыг хуулиар тодорхойлсон. Донорын тухай хуулиар (2000) шилжүүлэн суулгах эд эрхтэнг аль болох амьгүй донороос авбал зохино, амьд донороос эрхтнийг авахдаа ихрүүд, ах, дүү, ураг, төрлийн бусад эрүүл хүнийг сонгохоор зохицуулсан байна. Түүнчлэн, амьгүй донор болохыг тархины үхлийн эмнэл зүйн шалгуурыг баримтлан мэргэжлийн эмч нарын комисс тогтоодог байна. Амьгүй донороос эд эрхтэн авахдаа түүний өөрийн гэрээслэл, эсхүл түүний төрөл садангийн зөвшөөрлийг бичгээр авах буюу шаардлагатай бол хуулийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэх ёстой байдаг. Хуулийн төрөл садан гэсэн нэр томъёог Гэр бүлийн тухай хуулин 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6-д зааснаар ойлгохыг тусгах, түүнчлэн хуулийн байгууллага гэж ямар байгууллагыг хэлж байгааг нь тодорхойлох нь чухал байна. Хуулиар донорын үйл ажиллагаа цэвэр сайн дурын үндсэн дээр, бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахад зориулан ураг төрлийн хооронд явагдах бөгөөд донорын үйл ажиллагааг ашиг орлогын эх үүсвэр болгохыг хориглохоор заасан нь бусдын эд эрхтнийг хууль бусаар зарах, ашиг орлого олох эх үүсвэр болгохыг хориглосон. Энэ утгаараа хүний эд эрхтний хууль бус наймаанаас сэргийлэхэд сайтар чиглэгдсэн байна.

Анагаахын шинжлэх ухааны үсрэнгүй хөгжил, техник, технологийн дэвшилтэй уялдан эд эрхтэн<sup>27</sup> шилжүүлэн суулгах мэт засал сүүлийн жилүүдэд ихээр хийгдэх болсон учраас дэлхийн зах зээл дээр хүний эд эрхтний донорын эрэлт, үнэ ханш эрс нэмэгдсэн бөгөөд энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн нэг хэлбэр болох эд эрхтнийг нь авч дамлан худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болж байна. Тухайлбал,

Тяньжиний нэгдүгээр төв эмнэлэг 2005 онд эрхтэн шилжүүлэн суулгах 600 мэт засал хийсэн байна.<sup>28</sup> Дэлхийд хамгийн анх эрхтэн шилжүүлэн суулгах мэт заслыг 1957 онд бөөрөнд хийснээс хойш тавь орчим жилийн турш амжилттай хөгжиж ирсэн. Одоогоор бөөр шилжүүлэн суулгах хагалгааны ихэнх хувийг буюу эрхтэн шилжүүлэн суулгах шаардлагатай хүмүүсийн гуравны хоёрыг эзэлж байна. Тиймээс бөөр шилжүүлэн суулгах хагалгаа нь дэлхийд хамгийн их хийгддэг бөгөөд бусад эрхтнийг бодвол харьцангуй хялбар байдаг. Дэлхийд бөөрнөөс гадна зүрх, уушиг, элэг, нойр булчирхай, нарийн, будуун гэдэс зэрэг эрхтэнг шилжүүлэн суулгах мэт засал хийж байна.<sup>29</sup>

Дэлхийд хамгийн их эрхтэн шилжүүлэн суулгаж байгаа улс орны талаар 2002 онд судалгаа явуулахад БНХАУ уушигны хагалгаагаар тэргүүлсэн байна. Тус улсад жилд уушигны 174 хагалгаа хийгдсэн байхад Канадад 112 хагалгаа хийгдсэнээрээ удаалж, үүний дараа Австри Улс орсон байна. Харин манай хоёр хөрш эхний арагт багтжээ. Дэлхий нийтэд эрхтэн шилжүүлэн суулгуулахаар хүлээж буй хүмүүс их байдаг. Жишээ нь, бөөр шилжүүлэн суулгах хагалгаа хүлээж буй 56490, элэгний 17000 гаруй, нойр булчирхай 1500 орчим хүн байна. Гэтэл энэ мэт заслыг хүлээх хугацаандаа нас барах тохиолдол их гардаг.<sup>30</sup>

Дээрх тоо баримтаас үзэхэд дэлхий нийтэд эрхтэн шилжүүлэн суулгуулахаар хүлээж буй хүмүүс асар их байгаатай уялдан дэлхийн зах зээл дээр эд эрхтний эрэлт эхрэгцээ тэр хэмжээгээр өссөн нэмэгдэж, дэлхий дахинд хүний эд эрхтнийг дамлан худалдаалах бизнес цэцэглэн хөгжиж байна. БНХАУ-ын нэгэн эмнэлэг хүний элгийг 94 400 ам доллараар худалдан авч байсан байна.<sup>31</sup>

БНХАУ-ын Эрүүл мэндийн дэд сайдын мэдээлснээр тус улсад жил бүр 1.5 сая хүн эрхтэн шилжүүлэн суулгах мэт засал хийлгэх шаардлагатай байдагас зөвхөн 10000 нь л мэт засалд орж чаддаг гэжээ.<sup>32</sup> Энэ нь донорын эд эрхтний худалдаа дэлхий дахинд маш том бизнес болон хувирсны илтгэж байна.

2006 оны 10 дугаар сарын 3-ны өдөр УКТЭ-ээс ЭМШУИС-д зохион байгуулсан "Тархины үхэл ба эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ" сэдэвт зөвлөгөөний үеэр ДЭМБ-аас донорын талаар баримталж байгаа өнөөгийн бодлогын талаар ярилцсан байна. Дэлхий нийтэд амьд ба кадавер (цогцосны) гэж донорыг хоёр төрөлд ангилдаг байна. Өнөө цагт ах дүү, төрөл садангийн амьд донорыг

<sup>26</sup> Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр садар самууныг сурталчилж буй өнөөгийн байдал" гандалтын судалгааны хураангуй, 13-14 р тал, 2007 он, МОНХС, МБҮС-ийн НШУСургууль.

<sup>27</sup> Донорын тухай хуулийн 3.1.1-т "хүний эд, эрхтэн" гэж хүний цус, нөхөн уржикхуйн эд/өндөгөн, төмсөг, өндөгөн эс, сүм, ураг/экс бусад эд, эрхтэн; <sup>28</sup> "Хятадуудын хүний наймаа Монголд дэлгэрлээ", //Өнөөгийн төрх сонин, 2006 оны 10 дугаар сарын 27-ны өдөр, мэдээний дугаар #38534

<sup>29</sup> 2005 оны 6 дугаар сарын 14-ний өдөр //Зууны мэдээ сонин, ЭМШУИС-ийн мэт заслын тээхлийн багш Г. Баярагийн өгсөн ярилцлагаас [http://www.mongolmedia.com/printversion.php?ns\\_id=92062](http://www.mongolmedia.com/printversion.php?ns_id=92062)

<sup>30</sup> 2005 оны 6 дугаар сарын 14-ний өдөр, //Зууны мэдээ сонинд ЭМШУИС-ийн мэт заслын тээхлийн багш Г. Баярагийн өгсөн ярилцлагаас [http://www.mongolmedia.com/printversion.php?ns\\_id=92062](http://www.mongolmedia.com/printversion.php?ns_id=92062)

<sup>31</sup> "Хятадуудын хүний наймаа Монголд дэлгэрлээ", //Өнөөгийн төрх сонин, 2006 оны 10 дугаар сарын 27-ны өдөр, мэдээний дугаар #38534

<sup>32</sup> "Эрхтэн хандивлагчдыг бүртгэнэ", //Монголын мэдээ сонин, 2006 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, № 227 /2003/ <http://www.0300.mv/modules.php?name=News&file=article&sid=40577>

эзэнгшихдээ хялбар гэж үздэг учраас эд эрхтэн дамлан худалдах гэмт хэрэг хурдацтай өсөх хандлагатай болсныг, түүнчлэн ДЭМБ-аас энэ талаар онцгойлон анхаарч амьд хүн доор болох явдлыг аль болох хөхиүлэн дэмжихгүй байх бодлого барьдаг болсноо мэдэгдсэн байна. Үнэхээр амьд хүнийг донор болгох явдлыг хорих боломжгүй гэдэг нь амьдрал дээр нэгэнт нотлогдоод байгаа билээ. Тиймээс дэлхийн улс орнууд хууль, эрх зүйн орчин нөхцөлөө бүрдүүлэхэд голлон анхаарал тавин ажиллаж байна.<sup>33</sup>

ДЭМБ хүний эд эрхтний худалдаалах гэмт хэргийг нэгэнт хүлээн зөвшөөрч, амьд хүн донор болгон худалдаалахтай дэлхий нийтээр тэмцэхийг уриалж байгаа, дэлхийн зах зээл дээр эд эрхтний эрэлт хэрэгцээ их, үнэ ханш өндөр байгаа өнөө үед Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулж ажиллах шаардлагатай болжээ.

Манай улсад эрхтэн шилжүүлэн суулгах мэт заслыг анх 1997 онд хийсэн бөгөөд 2005 оны байдлаар манайд эрхтэн шилжүүлэн суулгасан 2 тохиолдол бүртгэгдсэн. Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлгийн эмч Цогт, Лхагвасүрэн, Цэцэгэ нар тухайн өвчний өөрийх нь хоёр бөөрний байрыг сольж суулгах, мэт заслыг эрхтэн шилжүүлэн суулгах техникийн дагуу амжилттай хийж байсан. Өөрийх нь бөөрийг эргүүлээд суулгасан учир хүнийрхэхгүй, бөөр мултарч унах асуудал байхгүй амжилттай болсон. Харин хоёр дахь тохиолдол эгчээс нь дүүд нь бөөр шилжүүлэн суулгах байсан боловч амжилтгүй болсон байна. Манай улсад бөөрний архаг дутагдалд орж буй хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа болохыг статистик тоо баримтаас харж болно. Жилд дунджаар 150 орчим бөөрний архаг дутагдалтай өвчтөн шинээр оношлогддог.<sup>34</sup> Бөөрний архаг дутагдал өвчнөөр өвчлөх тохиолдол ихсэх хандлагатай байгаад дараах хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж байна. Үүнд, хоол тэжээл, тэжээлийн хомсдол дутагдал, ядуурал, сэтгэл санааны хямрал, гутрал, архидалт, эм бэлдмэл их хэрэглэж байгаа зэрэг нь хамаарч байна. Бөөрний архаг дутагдлууд дотор голлож бөөрний өөрийх нь, эсвэл дараахь шалтгаантай дутагдал элбэг тохиолддог. Дараахь шалтгаантай гэдэг нь шээсний сүв бөглөрөх, шээсний хил нарийсах, янз бүрийн гажиг хөгжлүүдээс болж үүсч

болно. Бөөрний өөрийн шалтгаантай архаг дутагдалд түүдгэнцрүүдийн үрвэсэл, бөөр хатингарших, бөөрний архаг үрвэсэл багтдаг бөгөөд энэ нь манай улсад байдаг элбэг тохиолдлууд юм. Мөн бөөр уйланхайга, бөөр чулуужих зэрэг өвчлөл нь архаг дутагдалд оруулах үндсэн шалтгаан болдог. Бөөр хуримтлагдсан хамаг хорт бодогсыг гадагшлуулж чадахаа болихоор л уг бөөрний дутагдал үүсдэг байна. Бөөрний архаг дутагдалд орсон тохиолдолд бөөр шилжүүлэн суулгах мэт засал хийлгэх шаардлагатай байдаг.<sup>35</sup> Ингэж эд эрхтэн зайлшгүй шилжүүлэн суулгуулах шаардлагатай хүнийг "реципиент" гэдэг байна.<sup>36</sup>

Монгол Улс эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний багтай болоод тун удаагүй байгаа хэдий ч 2007 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 10 хүнд бөөр амжилттай шилжүүлэн суулгасан<sup>37</sup> бөгөөд ДЭМБ-аас манай эмч нарт баяр хүргэсэн захидал ирүүлж байжээ.<sup>38</sup>

Монгол Улсаас БНХАУ, АНУ, Япон болон бусад улсууд руу 60 гаруй хүн явж, эрхтэн шилжүүлэн суулгах мэт засал 1.2 сая ам.доллараар хийлгэжээ.<sup>39</sup> Эрхтэн шилжүүлэн суулгах багийн зөвлөх эмч ноён М.Слапак "Монгол Улсын эмчилгээний техник технологи, эм зэрэг нь хөрш хоёр орноосоо нэг анхам дээгүүр түвшинд болсон. Бид 2007 оноос элэг, цаашдаа зурх шилжүүлэн суулгах мэт засалд бэлтгэж байна"<sup>40</sup> хэмээн мэдэгдсэн.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр бидний траншейны тэнэмэл гэж нэрлэдэг хүүхэд өдрөөс өдөрт цөөрсөөр байгаа<sup>41</sup>, Монгол эмэгтэй 12 настай төрсөн охиноо 4 ханатай гэрээр БНХАУ-ын иргэн Ли-д худалдсан<sup>42</sup>, улсын хилээр БНХАУ-ын иргэн бага насны 2 хүүг авч гарах гэж байхад нь эцэг, эхийнх нь нэрийг хэлүүлэн шалгаснаар Хятадын иргэн шалгалтанд бүдэрч, хүүхэд кулгайлан хил давуулах гэж байсныг илрүүлэн саатуулсан<sup>43</sup>, Хятадад найзуудтайгаа архидаж байгаад өрөөсөн бөөрөө авахуулаад өөрөө ч мэдэлгүй Монголдоо ирсэн наймаачин залуугийн явдал<sup>44</sup>, мөн жирэмсэн хил гараад хүүхэдгүй эргэж ирдэг эмэгтэйчүүд<sup>45</sup>, БНСУ-ын иргэн Чан Инг Сон 17 настай Монгол охинтой гэрлэж, шан харамжинд нь охины хойд хэдэд 500,000 төгрөг өгсөн<sup>46</sup> гэх мэт хуурамч гэрлэлт, үрчлэлтээр хүүхэд, охид, эмэгтэйчүүдийг хил давуулан эд эрхтэн наймаалагчдын гарт амиа алдаж

<sup>33</sup> 2006 оны 10 дугаар сарын 03-нд УКТ-ээс ЭМЦУУИС-д зохион байгуулсан "Тарины ухал ба эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ" сэдвэд зөвлөлийн үеэр УКТ-ийн захирал Н.Оюундэргийн тавьсан илтгэл

<sup>34</sup> 2006.11.04-ны Өглөмний сонинд Монгол Улсын гавьяат эмч, төрийн шагналт, доктор, профессор, эрхтэн шилжүүлэн суулгах багийн ахлагч Д.Нямсүрэнгийн өгсөн ярицлагаас

<sup>35</sup> 2006.11.04-ны Өглөмний сонинд Монгол Улсын гавьяат эмч, төрийн шагналт, доктор, профессор, эрхтэн шилжүүлэн суулгах багийн ахлагч Д.Нямсүрэнгийн өгсөн ярицлагаас

<sup>36</sup> Доторын гуай хуулийн 3.1.6 "реципиент" гэх амьс намыг нь аврах, зүүн мөнд, гоо сайхныг нь сайжруулах зорилгоор донорын цус санбуулах, эд, эрхтэн шилжүүлэн суулгуулах зайлшгүй шаардлагатай хүнийг.

<sup>37</sup> 2007.04.13-ны MNS TV MM агентлаг 19.10 Мэдээллийн каталогор

<sup>38</sup> 2006.10.03-нд УКТ-ээс ЭМЦУУИС дээр "Тарины ухал ба эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ" сэдвэд зөвлөлийн үеэр УКТ-ийн захирал Н.Оюундэргийн хийсэн мэдэгдэл

<sup>39</sup> Ойго <http://www.galaxy.mn/modules.php?name=news&file=article&id=10139>

<sup>40</sup> 2006 оны 10 дугаар сарын 03-нд УКТ-ээс ЭМЦУУИС дээр "Тарины ухал ба эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ" сэдвэд зөвлөлийн үеэр хийсэн мэдэгдэл

<sup>41</sup> Түүн, "Сургууль болгоод ба хүний наймаа", 10-өндөр сонин, 2006 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн №239/2893 дугаар

<sup>42</sup> Ц.Эрдэнэ, "Хүнийг эд бараа мэт наймаалцаж байжээ", 10-Ардын эрх сонин, 2006 оны 11 дугаар сарын 23-ны өдрийн дугаарт прокурор Т.Жадамбаагийн өгсөн ярицлагаас

<sup>43</sup> С.Түүл, "Сургууль болгоод ба хүний наймаа", 10-өндөр сонин, 2006 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн №239/ 2893 дугаар

<sup>44</sup> П.Ганаа, "Наймаачин эр түрчүүдэйгээ найрлагад өрсөөр бөөрөө алдсанаа мэдэлгүй нутагтаа ирлээ", 10-Сонин явдал сонин, 2006 он, №19-20 дугаар

<sup>45</sup> МУИС-ийн "Аах" студийн захирал Шарыбуй, 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдөр, Eagle TV "Хүний наймаа" News talk нэвтрүүлэгт хийсэн мэдээлэл

<sup>46</sup> Ц.Эрдэнэ, "Хүнийг эд бараа мэт наймаалцаж байжээ", 10-Ардын эрх сонин, 2006 оны 11 дугаар сарын 23-ны өдрийн дугаарт прокурор Т.Жадамбаагийн өгсөн ярицлагаас



болохыг үгүйсгэх аргагүй. Мөн хилийн чанадад хаа нэгтээ хүчинд автан биеэ үнэлж, боолчлогдож, хүчинд автан хулгай хийж, гуйлга гуйж байгаа<sup>47</sup> хүүхэд, охид, эмэгтэйчүүдийн талаар төрийн болон төрийн бус байгууллагын судалгаанаас үзэж болно. Монгол Улсад эд эрхтний наймаа цэцэглэн хөгжих үндэс суурь төвигдаж эхэлсэн болох нь дээрх тодорхой баримт жишээгээр харагдаж байна. Түүнчлэн, "Хятадын Эрээн хотод автагтайаа авсан 10 настай хүү төөрч сураггүй алга болсон ба эрэл сурал болсны эцэст байрны хонгиолоос танигдахын аргагүй болтлоо зодуулж, цусандаа хутгалдсан цогцсыг нь олтол бүх дотор эрхтнийг нь авчирсан байсан тухай наймаачдын яриа, өнгөрсөн сард нь мөн л 14 настай хүү Эрээн хотод очиж сураггүй болоход хэд хоносны дараа дотор эд эрхтэнгүй болсон цогцос нь олдсон"<sup>48</sup> тухай мэдээллийг анхаарахгүй байх аргагүй юм.

Нийслэл Улаанбаатар хотод 2008 он гарсаар 12-23 орчим насны охид сураггүй алга болох нь эрс ихэссэн бөгөөд 40 дүгээр сургуулийн орчмын охидуудыг БНХАУ-ын иргэд хулгайлан хөрхж, тэдний судаснаас цус авч байсан гэх мэт мэдээллүүд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр цацагдаж байна. Энэхүү мэдээлэлд УИХ-ын Аюулгүй байдал, Гадаад боллогын байнгын хороо, улс төрийн намууд, төрийн бус байгууллагууд ихээхэн анхаарал хандуулсан. Хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэгдэх нэг хэлбэр болох эд эрхтний дотор болгон дамлан худалдаалах гэмт хэргийг үндэсний хэмжээнд тэмцэх, хууль хяналтын байгууллагуудыг сонор сэрэмжээ нэмэгдүүлэхийг мөн нийгмийн сэтгэл зүй шаардаж байна. 2008 оны 3 дугаар сард БНСУ-ын иргэд Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын сургуулийн 7-12 дугаар ангиудын сурагч тус бүрээ шинжилгээ хийнэ гэсэн нэрийдлээр 20 мл цус авсан бөгөөд энэхүү үйл ажиллагааг тус сумын сургуулийн захиргаа, БНСУ-ын иргэдтэй хамтран зохион байгуулсан байсан бөгөөд үүний удирдлага, сурагчдын эцэг, эхийн аль аль нь сумийн огт мэдээгүй өнгөрсө.

Олон улсын практикаас үзэхэд хүн худалдаалах гэмт хэргийн нэг хэлбэр болох эд эрхтнийг нь авч, дамлан худалдаалах гэмт хэрэг нь:

1. Хуурч мэхлэн хил давуулан эд эрхтнийг авч дамлан худалдаалах;
2. Хуурамч гэрлэлтээр халхавчлан эд эрхтнийг авч дамлан худалдаалах;
3. Үрчлэлтээр халхавчлан эд эрхтнийг авч дамлан худалдаалах;
4. Үхлийн явцад эд эрхтнийг ашиглаж байна;
5. Эд эрхтнийг ашиглах зорилгоор хүнийг санаатай алж байна;

6. Хүчээр эд эрхтнээ гэрээслэх гэрээслэл бичүүлэх, эсхүл төрөл садангийн хүмүүстэй үгсэн тохиролцоо, хохирогчийн эд эрхтнийг дотор болгох зөвшөөрөл бичгээр гаргуулан, хүнийг санаатай алж, эд эрхтний дотор болгох<sup>49</sup> гэсэн хэлбэрүүдээр үйлдэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд хүн амины гэмт хэргийг хохирогчийг мөчилж, эд эрхтнийг нь тараан хаях, цогцсыг шатаах, амьтдын тэгээл болгох, цогцсыг үгсэн тохиролцоо оршуулах зэргээр олон харгис хэргийг аргаар үйлдэж байгаа нь хохирогчийн цус, эд эрхтнийг ашиглах зорилгоор бусдыг санаатай алсан гэмт хэргийг нуун далдсан үйлдлүүд байхыг үгүйсгэх аргагүй юм. Эд эрхтний дотор шаардлагатай байгаа хүн (реципиент) цусны бүлэг, цусны цагаан цогцос, нас хүйс ойролцоо, эд, эрхтэн удам зүйн шинжээрээ тохирох хүнийг захиалга өгч алуулах, хүчээр эд эрхтнээ гэрээслэх, гэрээслэл бичүүлж авто аваар, зөлгүй учрал зохион байгуулан улмаар эд эрхтнийг нь авч өөртөө шилжүүлэн суулгуулж болзошгүй учраас хууль хяналтын байгууллагууд ихээхэн хүч гарган хяналт тавих нь зүйтэй байна.

Сүүлийн таван жилийн хугацаанд 6835 хүнд шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийсэн<sup>50</sup> нь шүүх эмнэлгийн шинжээч эмч задлагч нарт хяналт зайлшгүй тавих шаардлагатай илтгэж байна. Монгол Улсад бөөр шилжүүлэн суулгах мээ засал 1997-2005 оны 2 хүнд хийгдэж байсан бол 2007 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 10 хүнд бөөр шилжүүлэн суулгах мээ засал амжилттай хийгдэж энэ нь 8 мээ ажилбараар буюу 66.6 хувиар өссөн байна.

Дэлхийн практикт доноросоо эрхтнийг дараахь 4 арга замаар авч, шилжүүлэн суулгах мээ засал хийгдэж байна.<sup>51</sup>

1. Нас барсан хүний<sup>52</sup> (кадавер донор) эрхтнийг хугацаа алдахгүйгээр, нас барсан даруйд нь авч, шилжүүлэн суулгадаг.
  2. Тархи нь үхэжсэн хүний эрхтнийг шилжүүлэн суулгах бас нэг тохиолдол бий. Энэ нь бие эрүүл ч осол гэмтлийн улмаас ч юм уу, тархи нь ажиллахгүй хүний эрхтнийг авч донор болгохыг хэлнэ.
  3. Төрөл, садангийнх нь хүний<sup>53</sup> зөвшөөрлөөр хос эрхтнүүдийн нэгийг мээ заслын аргаар авч, өвчтөнд шилжүүлэн суулгадаг.
- Эрхтэн шилжүүлэн суулгах зайлшгүй шаардлагатай өвчтөнтэй цусны бүлэг, цусны цагаан цогцос, нас хүйс ойролцоо, хууч өвчингүй эрүүл чийрэг эд, эрхтэн удам зүйн шинжээрээ тохирох<sup>54</sup> хүнийг хууль бусаар донор болгодог байна.

### Дөрөв. Дүгнэлт, үнэлгээ

Хэдийгээр 2000 оноос эхлэн энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар олон тооны сургалт, сурталчилгааг зохион байгуулсан боловч

<sup>47</sup> С. Туул, "Сураггүй болгогчид ба хүний наймаа", //Өнөөдөр сонин, 2006 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн №239/2893 дугаар

<sup>48</sup> "Мөнгөнд улайрсан зандалчид таныг ч хайрлахгүй", //Өнөөдрийн Монгол сонин, 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн №140 дугаар, <http://www.0100.mn/modules.php?name=News&file=article&id=17573>

<sup>49</sup> Доторын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т "Амьгүй донорос эд, эрхтэн авахдаа нас барагчийн өөрийн гэрээслэл, эсхүл түүний төрөл, садангийн зөвшөөрлийг бичгээр авах буюу шаардлагатай бол хуулийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэн" гэж заасан байдаг.

<sup>50</sup> Шүүх эмнэлэг 45 эрдэм шинжилгээний бага хурлын амьтгалт, УБ хот, 2006 он, 29-р тал

<sup>51</sup> 2005 оны 06 дугаар сарын 14-ний өдөр //Зууны мэдээ сонинд ЭМШУИС-ийн мээ заслын тэнхимийн багш Г. Базраагийн өгсөн ярилцлагаас [http://www.mongolmedia.com/printversion.php?ns\\_id=92062](http://www.mongolmedia.com/printversion.php?ns_id=92062)

<sup>52</sup> Доторын тухай хуулийн 3.1.4-т "Амьгүй донор" гэж тархины үйл ажиллагаа эргэцгүй алдагдаж, нас барсан нь тогтоогдсоны дараа хэвийн үйл ажиллагаатай байгаа зарим эд, эрхтэн нь шилжүүлэн суулгах зорилгоор авч болох цогцсыг;

<sup>53</sup> Доторын тухай хуулийн 3.1.2-т "Амьд донор" гэж бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахад зориулан түргэн нөхөн төлөгд эд /архи, чөмөг/, эсхүл хос эрхтнийгээ нэгийг өгөхийг;

<sup>54</sup> Доторын тухай хуулийн 3.1.5-д "эд, эрхтний тохироо" гэж донор болон реципиентийн эд, эрхтэн удам зүйн шинжээрээ тохирох зэргээг хэлнэ;





төдийлэн үр дүнд хүрээгүй байсан бөгөөд 8 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэргийн болон хохирогчдын тоо нэмэгдэх хандлагатай болж эхлэснээс үүдэн 2008 оноос эхлэн хууль хяналтын байгууллагууд болон улсын байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран нилээд эрчимтэй ажиллаж эхэлснийг тэмдэглэх байна.

Энэ сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаа, цугларсан мэдээ, мэдээлэл, тоо баримт зэргээс харахад хүн худалдаалах гэмт хэрэг тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг ноцтойгоор зөрчсөн үйлдлүүд гарч байна. Ялангуяа, залуу эмэгтэйчүүд, охидуудыг хүчээр хулгайлан биеийг нь үнэлүүлэн ашиг олдог, хил дамнуулан зохион байгуулалттайгаар олноор нь хууран мэхлэх замаар элсүүлэн гадагш гарган худалдаж, хувьдаа болон хамтрагч нартаа ашиг олдог, түүнийгээ хуваарилдаг, телевиз, сонин хэвлэлийн зар сурталчилгааг ихээр ашигладаг зэрэг байдлууд харагдаж байна.

4.1. Охид, эмэгтэйчүүдийг биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор зохион байгуулалттай бүлэг болж хүчээр, ёс бус үйлдлүүдийг хэрэглэн тарчлаан зовоох, айлган сүрдүүлж хүчиндэх, зодох, балгийн дур хүслээ ёс бусаар хангах, дээрэмдэх зэрэг бусад төрлийн гэмт үйлдлүүдийн хамт тээврийн хэрэгсэл ашиглан үйлдэж байна. Хуулийн холбогдох заалтуудыг хууль хяналтын байгууллагагынхон төдийлэн хэрэглэж сураагуудтай холбоотойгоор өөр хөнгөн төрлийн ялтай зүйл ангиар зүйлчлэн ял завшуулах явдал г гарч байна.

4.2. Өвөндрин мөрдөж байгаа Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх, Садар самунтай тэмцэх тухай, Гэр бүлийн тухай, Зар сурталчилгааны тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаан-члах тухай зэрэг хууль нь Монгол Улсын нэгдэн орсон "Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг" НҮБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-ын заалтуудтай уялдахгүй байхын зэрэгцээ эдгээр хуулиуд нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх найдвартай баталгаа болж чадахгүй байна.

Эмэгтэйчүүдийн, хүүхдийн эрх, эрх чөлөөнд халдах, хууль бус үйлдлүүдээс ангид байлгах, хүний эрхийн ноцтой зөрчилт таслан зогсооход түргэн шуурхай, бодлогын чанартай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.3. Холбогдох байгууллагуудаас гаргаж буй дүрэм, журмын зөвлөмжийг олон улсын гэрээ конвенц болон дотоодын гэрээ тогтоомжтой нийцүүлэн шинээр боловсруулан мөрдөж ажиллах хэрэгтэй байна.

4.4. Хамгийн анхаарал татсан асуудал болох хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчдыг хамгаалах явдал байна. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчдын хохирлыг түргэн шуурхай барагдуулах, хохирогчдыг нөхөн сэргээх сэтгэл зүйч, эмч, хуульч нарыг бэлтгэх ажлыг эхлүүлэх шаардлагатай байна. Ялангуяа, сэтгэл санааны хувьд эргэн хэвийн байдалд оруулан нийгэмшүүлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллааны явцад хохирогчийн эрхийг хамгаалах ажиллагааг бүрэн хэмжээгээр бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна.

4.5. Хууль хяналтын байгууллагуудын ажилтнууд ялангуяа энэ гэмт хэргийг дагнан мөрдөх, янхач, шүүх эрх бүхий албан тушаалтнуудад бүрэн цогц мэдлэгийг олгох, зөв шийдвэрлэдэг практикийг бий болгох нь нэн чухал байна.

4.6. Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ тавигдах шалгуурыг өндөрсгөн, нарийн хяналтын дор үрчлэлтийг хийж

байхын тулд одоогийн мөрдөж буй журмыг шинэчлэн өөрчилж мөрдүүлэх нь чухал байна.

4.7 Нийгэм, олон нийтэд хандсан сурталчилгааг үнэн бодитой, зөв явуулахын тулд хэвлэл мэдээллийн байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг тусалцааны арга хэмжээг бодлогын дагуу авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.8. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ажилладаг төрийн байгууллага тэр дундаа цагдаагийн байгууллагын ажилтнуудын бүтэц бүрэлдэхүүн хангалтгүй, улс орны хэмжээнд өвөндрин байдлаар энэ асуудлыг 2-3 хүн л ЦЕГ-ын ЭЦГ-т хариуцан ажиллаж байгааг анхаарах нь зөв байна.

## Тав. Санал, зөвлөмж

### 5.1 Хууль эрх зүйн орчныг боловсруулж болгох хүрээнд

5.1.1. Монгол Улсын нэгдэн орсон "Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц"-ийн нэмэлт болох "Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-ын зарим зүйл заалтуудтай уялдуулан үндэсний хууль тогтоомжоо, тухайлбал Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх, Хилийн тухай, Гэр бүлийн тухай хууль зэрэг холбогдох бусад хуулиудын зарим зүйл заалтыг нийцүүлэх;

5.1.2. Бусдыг худалдсан этгээдүүдийн хэргийг түргэн шуурхай шалган шийдвэрлэж, ял завшуулахгүй байх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, түүний мөн чанарын талаарх хичээлийг хуулийн байгууллагын ажилтнууд болон эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын сурталтын хөтөлбөр, өрөнхий боловсролын сургуулиудын сурталтын төлөвлөгөөнд оруулан баталж мөрдүүлэх;

5.1.3. Холбогдох байгууллагуудын дотоод үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог дүрэм журмуудыг судлан шинжилж, шинэчлэх арга хэмжээг авах;

5.1.4. Гадаадын иргэнд Монгол Улсын иргэн, харьяат хүүхдийг үрчлэх журамд яаралтай өөрчлөлт оруулах, Хил хамгаалах байгууллагын дотоодод үйлчилдэг нууцын хэрэглэлгүй дүрэм журмыг судлан шинжилж ялангуяа, хилийн шалган нэвтрүүлэх боомтод үйлчилдэг дүрэм, журмуудыг өөрчлөн, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон эрсдэл бүхий охид эмэгтэйчдийг таньж мэдэх, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох цэг үүргийг талаарх дүрэм журмыг хэрэгжүүлэн мөрдөх боломжийг судлах;

5.1.5. Гадаадын иргэнтэй гэр бүл болох асуудлыг зуучилдаг хувь болон хуулийн этгээдийг нарийн судлан шалгаж, хууль зөрчиж үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэн, үйл ажиллагаа явуулах дүрэм журмыг нь хуульд нийцүүлэх;

5.1.6. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хуулийг батлан гаргах;

5.1.7. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдыг хамгаалах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа бусад төрлийн гэмт хэргийн хохирогч нараас тусад нь тусгайлсан өрөө, тасалгаа ашиглах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг цацахгүй байх

тал дээр онцгойлон анхаарч ажиллах эрх зүйн зохицуулалтыг бий болгож хөрөнгө оруулалт хийж;

5.1.8. Донорын тухай хууль болон холбогдох дүрэм журмуудыг нягтлан үзэж, шаардлагатай бол олон нийтэд энэ талаар мэдээлдэг журмыг бий болгож;

## 5.2 Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд

5.2.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр түгээж буй зар сурталчилгаа, нэвтрүүлгүүдэд дүн шинжилгээ хийж, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай цаашид хамтран ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5.2.2. 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын 234 дүгээр тогтоолоор баталсан "Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг шаардлагатай бол шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, үндэсний зөвлөл, түүний ажиллах нөхцөл бололцоо болон хөтөлбөрт заасан заалтуудыг хэрэгжүүлэх төсвийг яаралтай шийдвэрлэж үйл ажиллагааг нь эрчимжүүлэх;

5.2.3. Хил хамгаалах байгууллага, Цагдаагийн байгууллага, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх байгууллагуудын хооронд энэ гэмт хэргийн талаарх мэдээллийн сүлжээг сайжруулах, бодит мэдээллээр хангадаг тогтолцоог бий болгоход анхаарч ажиллах;

5.2.4. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэн ажилладаг Цагдаагийн байгууллагын бүтцийг өргөжүүлэх;

5.2.5. Төрөл бүрийн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд тусгай хөтөлбөрийн дагуу сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

5.2.6. Хараа хяналтгүй хүүхдүүдийн талаарх мэдээллийг хилийн шалган нэвтрүүлэх албад, иргэний бүртгэл мэдээллийн байгууллагуудад мэдээлдэг болох, гадаадад зорчих баримт бичиг олгох, хилээр нэвтрүүлэх асуудлыг хяналтанд авдаг, тогтмол бүртгэлтэй болох тогтолцоонд шилжих;

## 5.3. Төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд

5.3.1. Хуулийн байгууллагууд болон төрийн, төрийн бус байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, үнэн зөв мэдээллээр шаардлагатай тохиолдолд ямар нэгэн саадгүйгээр нийгэм, олон нийтийг хангах, хуулийн заалтад харшлахгүй бол бусад тохиолдолд хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

5.3.2. Хараа хяналтгүй, тэнэмэл, биеэ үнэлдэг хамсанд хүрээгүй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах ажлыг эрхлэн явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулан, хяналтын тогтолцоог үр өгөөжтэй болгоход хамтран ажиллах;

5.3.4. Энэ төрлийн гэмт хэргэтэй тэмцэх ажлын хүрээнд хамтарсан судалгааны ажлыг зохион байгуулах, эрсдэл бүхий бүлгүүд болон тэдгээрийн талаарх мэдээллийг нэг мөр болгон гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах;

### Товчилсон үгийн тайлал

БЗД - Баянзүрх дүүрэг  
 БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс  
 БНСУ - Бүгд Найрамдах Солонгос Улс  
 БНХГУ - Бүгд Найрамдах Холбооны Герман Улс  
 БСШУЯ - Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам  
 ГХЯ - Гадаад Харилцааны Яам  
 ГИХАЭГ - Гадаадын Иргэн, Харьяатын Асуудал Эрхлэх Газар  
 ДЭМБ - Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага  
 ДОХ - Дархлалын олдмол хомсдол  
 ИБМУТ - Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын Төв  
 МАХН - Монгол Ардын Хувьсгалт Нам  
 МУИС - Монгол Улсын Их Сургууль  
 НХХЯ - Нийгэм Хамгаалах Хөдөлмөрийн Яам  
 НҮБ - Нэгдсэн Үндэстний Байгууллага  
 НЦГ - Нийслэлийн Цагдаагийн Газар  
 НПГ - Нийслэлийн Прокурорын Газар  
 ОВГ - Оюуны Өмчийн Газар

ОХУ - Оросын Холбооны Улс  
 СЗХ - Санхүүгийн Зохицуулах Хороо  
 СБД - Сүхбаатар дүүрэг  
 ТББ - Төрийн бус байгууллага  
 УДШ - Улсын Дээд Шүүх  
 УЕП - Улсын Ерөнхий Прокурор  
 УМБГ - Улсын Мөрдөн Байцаах Газар  
 УКТЭ - Улсын Клиникийн Төв Эмнэлэг  
 УИХ - Улсын Их Хурал  
 ХААИС - Хөдөө Аж Ахуйн Их Сургууль  
 ХЗДХЯ - Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам  
 ХХЕГ - Хил Хамгаалах Ерөнхий Газар  
 ХУД - Хан-Уул дүүрэг  
 ХЭХУ - Хүний Эрхийн Үндэсний Комисс  
 ЦЕГ - Цагдаагийн Ерөнхий Газар  
 ЭМШУИС - Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль  
 ЭЦГ - Эрүүгийн Цагдаагийн Газар

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.  
 Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
 Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
 Төрийн ордон-128 тоот

☎ 262420, 329512  
 Индекс 14003

☎ 329487  
 Хэвлэлийн хуудас 5.5